



МЭТГЭЛЦЭЭН

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

Designed by macrovector_official/Freepik



САНАЛ ӨГӨХ

САНАЛ ХУРААЛТ



САНАЛ АВАХ ӨДӨР

САНАЛ ТООЛЛОГ



САНАЛ АВАХ ӨДӨР

СОНГУУЛИЙН ҮР ДҮН

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

СОНГУУЛИЙГ МЭДЭЭЛЖ, СУРВАЛЖЛАХ НЬ

Гарын авлага



СОНГУУЛИЙГ МЭДЭЭЛЖ, СУРВАЛЖЛАХ НЬ Гарын авлага

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар
2021

Тус гарын авлагыг АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн хэрэгжүүлж буй **“Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь”** хөтөлбөрийн хүрээнд Глоб Интернэшнл төвөөс бэлтгэв.

Гарын авлагад илэрхийлэгдсэн агуулга нь хувь хүний үзэл санаа бөгөөд АНУ-ын засгийн газар эсхүл дээрх агентлаг, хүрээлэнгийн албан ёсны байр суурь биш болно.

Боловсруулсан: М.Наранчимэг, Улаанбаатар Эрдэм Их Сургуулийн сэтгүүл зүйн багш, доктор (Ph.D)
 Д.Цэнд, СУИС-ийн РТМУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, магистр
 Г.Хулан, СУИС-ийн РТМУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, магистр
 Г.Баярмаа, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, докторант
 Г.Мөнхбаяр, СУИС-ийн РТМУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, магистр
 М.Дэлгэрцэцэг, Отгонтэнгэр Их Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, магистр
 Б.Чинзориг, МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, докторант
 Л.Ариун, ХУИС-ийн Сэтгүүл зүй, медиа технологийн тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор
 Б.Ёндондүйчир, Сити их сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, магистр

Зөвлөх: Х.Наранжаргал, Глоб Интернэшнл төв

Хянан тохиолдуулсан: Т.Аюушжав, Глоб Интернэшнл төв
 Ч.Энхбаяр, Глоб Интернэшнл төв

ОИХ.МН
 СУДАЛГААНЫ САН

Товчилсон үгийн жагсаалт	5
Зургийн жагсаалт	5
Өмнөх үг	6
1. Сонгууль ба хэвлэл мэдээлэл	8
2. Сонгуулийн эрх зүйн орчин	12
3. Сонгуулийн сурталчилгааг нийтэлж, нэвтрүүлэх нь	21
4. Сонгуулийн үеэр редакцын баримтлах бодлого	23
5. Сонгуулийн мэдээллийг төлөвлөх нь	30
6. Сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээллийн онцлог	38
7. Сонгуулийн үед эх сурвалжтай ажиллах нь	42
8. Сонгуулийн үеэр нээлттэй өгөгдөлтэй ажиллах нь	47
9. Сонгуулийг мэдээлж, сурвалжлахдаа ёс зүйг баримтлах нь	59
10. Баримт нягтлах нь	65
11. Сонгуулийг мэдээлж, сурвалжлахдаа аюулгүй байдлаа хангах нь	69
12. Ном зүй	72

Товчилсон үгийн жагсаалт

АИХЭГ	Ардчилсан институт, хүний эрхийн газар
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ИБУТЭОУП	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт
МЧАСЭ	Монголын чөлөөт, ардчилсан сэтгүүлчдийн эвлэл
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОУСХ	Олон улсын сэтгүүлчдийн холбоо
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
ХМЗ	Хэвлэл мэдээллийн зөвлөл
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
ХХЗХ	Харилцаа Холбооны Зохицуулах Хороо
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	
Зураг 1.	Сонгуулийн мэдээ сурвалжилга
Зураг 2.	Сонгуулийн мэдээллийн сэдэв, агуулга төлөвлөх жишээ
Зураг 3.	Сонгогчдын боловсролд зориулсан сэтгүүл зүйн бүтээлийн агуулга, үр дүн
Зураг 4.	Конгрессийн дунд хугацааны сонгуулийн үр дүн
Зураг 5.	1982 оны "USA Today" сонин мэдээллийн график
Зураг 6.	АНУ-ын сонгуулийн мэдээ мэдээллийн график
Зураг 7.	Икон.тп сайтын 2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүнг мэдээлсэн мэдээллийн график.
Зураг 8.	Статистик суурьтай мэдээллийн график, дүрст тэмдэгтийн төрлүүд
Зураг 9.	Түүхэн харьцуулалт мэдээллийн график, дүрст тэмдэгт
Зураг 10.	Үйл явцын мэдээллийн график, дүрст тэмдэгт
Зураг 11.	Газар зүй болон байршил заасан мэдээллийн график, дүрст тэмдэгт «АНУ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН САНАЛЫН ЗУРАГЛАЛ»
Зураг 12.	Дата дүрсжүүлэлт хийх үйл явц (Нью-Йорк хотын дүүргүүдийн хүн амын тоо)
Зураг 13.	Дата дүрсжүүлсэн байдал (Нью-Йорк хотын дүүргүүдийн хүн амын тоо)

Глоб Интернэшнл төв ТББ та бүхэнд сэтгүүл зүйн багш нартай хамтран бэлтгэсэн “Сонгуулийг мэдээлж, сурвалжлах нь” гарын авлагаа толилуулж байна. Энэ гарын авлагыг бэлтгэж, сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхэн, сэтгүүл зүйн багш нар, оюутнууд, олон нийтийн хүртээл болгоход “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг үзүүлсэн АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн хамт олонд талархал илэрхийлье!

Чөлөөт, шударга сонгуулиар засаг төрөө нээлттэй сонгох иргэдийн боломж бол ардчилсан нийгмийн онцлог шинжийн нэг билээ. Монгол Улс 1992 онд ардчилсан Үндсэн Хуулиа батлаж, гуравдугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн иргэдийнхээ шууд оролцооны эрхийг баталгаажуулсан юм. Сонгууль бол иргэдийн шууд оролцооны эрхээ эдлэх анхан шатны бөгөөд суурь эрх юм. Засаг төрөө товхинуулахад иргэний зөв сонголт туйлын чухал бөгөөд түүний саналд чөлөөт, бодит мэдээлэл нөлөөтэй. Ийм учраас сонгуулийн аяны үеэр хэвлэл мэдээлэл онцгой үүрэг хүлээдэг.

Манай улсад 1992 онд парламентын, 1993 онд Ерөнхийлөгчийн анхны чөлөөт, ардчилсан сонгууль болж, үүнээс эхлэн хэвлэл мэдээлэл сонгогчдод мэдээлэл түгээхэд чухал үүрэг гүйцэтгэсэн бөгөөд энэ явцдаа алдаа оноо бүхий сургамж, туршлагаудыг хуримтлуулсан билээ. Энэ хугацаанд сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд аль хэр тэнцвэртэй, шударга ажиллаж буйд мониторинг хийдэг уламжлал ч тогтсон. Анхны мониторингийг 1996 онд тухайн үеийн Монголын чөлөөт, ардчилсан сэтгүүлчдийн эвлэл (МЧАСЭ), Олон улсын сэтгүүлчдийн холбоо (ОУСХ)-той хамтран хийсэн бөгөөд гадаадын гурван шинжээчийн бүрэлдэхүүнтэй Ажиглах хэсэг Улаанбаатар, Дархан, Мөрөн хотод долоо хоног ажилласан юм. ОУСХ-ны Хэвлэл мэдээллийн Ажиглах хэсгийн тайланд “Төр, засгийн хэвлэл мэдээллийг оролцуулан хэвлэл мэдээллийн бүх төрлийн хэрэгсэл нэр дэвшигчдийн үйл ажиллагаа, үзэл бодлыг сурталчлан төлбөр авч, редакцын хараат бус, бодит мэдээлэл, нийтлэл, хөтөлбөрт бага цаг, зай талбай гаргаж байв. Монголын хэвлэл мэдээлэл сонгуулийн аяны явцад орлого хөөцөлдсөнөөс бус, соёлтой маргааны шүүгч болж, ингэснээрээ сонгогчдын ул суурьтай шийдвэр гаргахад туслах үүрэг хариуцлагаа хангалтгүй биелүүлсэнд ОУСХ-ны Ажиглах хэсэг сэтгэл дундуур байна” гэсэн билээ. Үүнээс хойш Глоб Интернэшнл төв, Хэвлэлийн Хүрээлэн сонгуулийн үеэр мониторинг тогтмол хийж байна. Харамсалтай нь, өнгөрсөн хугацаанд ОУСХ-ны тайлангийн дүгнэлтэд дурдсан тэр байдалд жинтэй ахиц гарсангүй. Өнөө хэр нь сонгуульд өрсөлдөгч нам, нэр дэвшигчдийн сурталчилгаа, сонгуулийн чөлөөт, хараат бус, шударга сэтгүүл зүйн хоорондын ялгаа төдийлөн онцгойрохгүй байна. Үүнд манайд үйлчилж буй сонгуулийн тухай хуулиуд ч нөлөөлдгийг үгүйсгэх аргагүй. Гэсэн хэдий ч, сонгуулийн сэтгүүл зүйн мэргэжлийн түвшин тухайн редакцын соёлоос ихээхэн хамаардгийг бид умартах ёсгүй.

Иймд бид сонгуулийн төлбөрт сурталчилгаа, хэвлэл мэдээллийн аяны явцад хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, маркетингийн ажилтан, сэтгүүлчийн үүрэг, тэдний ажил үүргийн ялгаа, ялангуяа, сонгуулийн сэтгүүл зүйн зарчмуудын тухай тодорхой ойлголтуудыг цэгцлэхэд энэ гарын авлага чухал эх сурвалж болно гэдэгт найдаж байна.

Нөгөөтээгүүр, сонгуулийн хараат бус мэдээлэл бэлтгэх, түгээх нь сэтгүүлчдийн хувьд сорил бэрхшээл дагуулдаг амаргүй даалгавар байдаг. Улс төрийн нам, нэр дэвшигчид, тэднийг дэмжигчдийн зүгээс сэтгүүлчдийг сүрдүүлэх, айлгах, дарамтлах явдал үзэгддэг ба манай түүхэнд “долдугаар сарын нэгэн” хэмээн тэмдэглэгдсэн тэй адил эмх замбараагүй байдал, үймээн самуун дэгдэх ч тохиолдол гарч болзошгүй тул аюулгүй байдлаа хэрхэн хангах, хамгаалах тухай гарын авлагад мөн дурдав.

Энэ дашрамд манай саналыг хүлээн авч, гарын авлага туурвихад хүчин чармайлтаа зориулсан эрдэмтэн багш нартаа хамт олныхоо өмнөөс талархал илэрхийлье!

Сонгуулийн хэвлэл мэдээллийн аяны үеэр бид хэрхэн ажиллахаас иргэдийн мэдээлэлтэй шийдвэр, зөв сонголт хамаарна. Хэвлэл мэдээллийн менежер, ажилтан, сэтгүүлч бүгд сонгогч, гэхдээ улс орныхоо сайн сайхан ирээдүйн төлөө хувийн сонирхлоос дээгүүр мэргэжлийн, ёс зүйн онцгой үүрэг хүлээнэ.

Та бүхэнд амжилт хүсье!

Глоб Интернэшнл төвийн Удирдах зөвлөлийн дарга Х.Наранжаргал

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СОНГУУЛЬ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Ардчилсан нийгмийн нэг мөн чанар нь иргэд төр засгаа нээлттэй сонгох шударга үйл явц юм. Үүнийг манай улсын хувьд Үндсэн хууль болон бусад хуулиар баталгаажуулсан. Чөлөөт, шударга сонгуулиар дамжуулан, иргэн бүрийн төрийн үйл хэрэгт оролцох эрхийг ардчилсан улс орнуудад үндэсний хууль тогтоомж болон олон улсын хэм хэмжээгээр баталгаажуулдаг.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 3 дугаар зүйлд иргэдийн шууд оролцооны эрхийг **“Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ”** хэмээн баталгаажуулсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III/ тогтоолоор Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг батлаж, түүний бүх заалтыг дагаж мөрдөхийг гишүүн орнуудад уриалжээ. Монгол Улс 1961 НҮБ-д 101 дэх гишүүн орноор элсэн орсон. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 21-р зүйлд **“Хүн бүр улс орноо удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй”** гэж заасан.¹

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор батлаж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (ИБУТЭОУП)-ын 25 дугаар зүйлд иргэн бүрийн “төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох, сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох” эрхийг баталгаажуулдаг.²

Сонгууль бол иргэдийн шууд оролцооны эрхээ эдлэх анхан шатны бөгөөд суурь эрх юм. Засаг төрийг эмхлэн байгуулахад иргэний зөв сонголт туйлаас чухал бөгөөд иргэдийн санал, шийдвэрт чөлөөт, бодит мэдээлэл чухал нөлөө үзүүлнэ. Иймээс ч сонгуулийн үед иргэдийн үнэн бодит мэдээлэл олж авах эрх, ашиг сонирхолд үйлчлэхэд хэвлэл мэдээлэл онцгой үүрэг хүлээдэг.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ) сонгуулийн аяны явцад хос үүрэг хүлээдэг.

НЭГДҮГЭЭРТ, сонгуулийн тухай мэдээлж, сурвалжлах, гол асуудлуудад дүн шинжилгээ хийх гэх мэт сонгуулийн сэтгүүл зүйн бүтээлүүд туурвин нийтэлж, нэвтрүүлэх.

Сонгуулийн сурталчилгаанаас ялгаатай нь энэ бол мэдээ, мэдээллийн төрөл зүйлүүдээр бэлтгэдэг хараат бус сэтгүүл зүй бөгөөд сэтгүүлчдийн ажил. Энэ нь хэзээ ч төлбөртэй байж болохгүй!

1 Монгол Улсын Олон Улсын Гэрээ. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал. <https://www.legalinfo.mn/law/details/1271>

2 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт. <https://www.legalinfo.mn/law/details/1257>

ХОЁРДУГААРТ, Сонгуулийн сурталчилгааны материалуудыг нийтэлж, нэвтрүүлэх.

Сонгуулийн сурталчилгаа гэж тухайн улс төрийн нам, нэр дэвшигчийн төлөө аль болох олон санал өгүүлэхийн тулд санаа бодолд нь нөлөөлөх зорилгоор олныг хамарсан аян зохион байгуулах үйл явцыг хэлнэ. Сонгуулийн сурталчилгааг хуульд заасан тодорхой хугацаанд хийдэг бөгөөд сонгогчдын санаа бодолд эргэлт гарах хүртэл нөлөөлдөг тул улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид асар их хөрөнгө, мөнгө зарцуулдаг. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгаандаа хэвлэл мэдээллийн нөлөө, хүчийг ашиглах сонирхол их байдаг нь ард иргэдэд өөрсдийнхөө мөрийн хөтөлбөрийг ойлгуулах, таниулах, иргэдийг зөв мэдээлэлтэй байж, зөв сонголтоо хийхэд тусалж чадах хамгийн найдвартай, үр нөлөөтэй суваг гэж үздэгтэй холбоотой. Үнэхээр ч, иргэд улс төрийн сонгуульд оролцож, саналаа аль нам, эвсэл, нэр дэвшигчид өгөхөд ХМХ хамгийн их нөлөөлдөг болохыг олон шатны сонгуулийн үеийн судалгаа нотолдог.

1.1. СОНГУУЛИЙН СЭТГҮҮЛ ЗҮЙ

Сурвалжлах, сурталчлах хэмээх ямагт тусдаа, өөр өөрийн зарчим, онцлогтой хоёр өөр үйл ажиллагаа сонгуулийн үеэр ХМХ-д жирийнхээс илүү давхцаж, нэгдмэл мэт харагддаг учраас олон нийтийг төөрөгдүүлж, маргаан үүсгэдэг.

Сонгуулийн үеэр ХМХ гурван чухал үүрэг хариуцлага үүрнэ.

НЭГДҮГЭЭРТ, ХМХ СОНГУУЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛНЭ.

ХМХ сонгуульд өрсөлдөж буй улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн аяны тухай шударга мэдээлэл түгээх үүрэгтэй. Сонгогчид ХМХ-ээс өрсөлдөгчдийн хоорондын ялгааг олж мэдэх хүсэлтэй бөгөөд энэ нь тэдний сонголтод нөлөөлдөг. ХМХ мөн сонгогчдын үзэл бодлыг түгээдэг. Түүнчлэн, ардчилсан сонгуулийн утга учир, мөн чанар, ач холбогдол, хэзээ, хаана, хэрхэн саналаа өгөх тухай мэдээлэл дамжуулна. Аливаа сонгуулийн үеэр болдог онцлох үйл явдлууд, санхүүжилтийн ил тод байдал зэрэг чөлөөт, шударга сонгуулийн чухал ач холбогдол бүхий зүйлүүдийн тухай шуурхай мэдээлэх үүрэгтэй. Ийнхүү сурвалжилж мэдээлэхдээ шударга байж, тал тохой татахгүй, аль нэг талыг баримтлахгүй байх ёстой.

Улс орны хөгжил, хүмүүсийн аж амьдрал, сайн сайхан нийгмийн төлөө улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн боловсруулсан мөрийн хөтөлбөрийг хараат бусаар дүгнэн шинжилж, харьцуулах, амлалтын мөн чанар, өмнөх амлалтуудын хэрэгжилтийн тухай зэрэг сонгогчдын эрх ашигт нийцсэн, хүсэн хүлээсэн мэдээллээр тэднийг хангах нь ХМХ-ийн бас нэг чухал үүрэг бөгөөд энэ нь тэдний зөв сонголтод чухал нөлөө үзүүлдэг. Түүнчлэн, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдэд мөрийн хөтөлбөрөө тайлбарлах, амлалтынхаа тухай сонгогчдод зөв ойлголт өгөх, мөн улс орны хөгжил дэвшил, иргэдийн өмнө тулгамдаж буй асуудлаар үзэл бодол, байр сууриа илэрхийлэх тэгш, шударга боломж олгох үүрэгтэй. Өрсөлдөгч нам, эвсэл, нэр дэвшигчдийн байр суурийг илэрхийлсэн ярилцлага, хэлэлцүүлэг мэтгэлцээнүүд бэлтгэн иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, аливаа нөлөөнд авталгүйгээр сонголтоо зөв хийхэд нь туслах ёстой.

ХОЁРДУГААРТ, ХМХ “ОЛОН НИЙТИЙН ХОТОЧНОХОЙ”-Н ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭНЭ.

Сонгуулийн явц, тухайлбал нэр дэвшигч тодруулах, бүртгэх, саналын хуудас хэвлэх, санал хураах, санал тоолох, дүн танилцуулахад оролцох, СЕХ, салбар хороод үүргээ шударгаар биелүүлж буй эсэх гэх мэт бүхий л үйл явцад хяналт тавина. Мөн сонгуулийн үеэрх булхай луйвар, авлига, хээл хахуулийг илчлэх нь ардчилсан хэвлэл мэдээллийн нийгэм, иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг болохыг умартах учиргүй. Ингэхдээ, аль нэг нам, хүчин, нэр дэвшигчийн үгээр бус, мэргэжлийн үүднээс баримтаар нотолсон, үнэн бодит байх ёстой.

ГУРАВДУГААРТ, ХМХ СОНГОГЧДЫН ДУУ ХООЛОЙ БАЙНА.

Сонгууль бол зөвхөн улс төрчдийн хэрэг бус. Энэ бол бүх нийтийн үйлс юм. Иймд ХМХ жирийн иргэдэд улс орны амьдрал, хөгжлийн асуудлын талаар санал бодлоо илэрхийлэх боломж олгоно. Мөн ийм боломжгүй хүмүүс, боломж нь хязгаарлагдмал эмзэг бүлгүүдийн нэрийн өмнөөс ХМХ дуугарах ёстой. Нийгмийн янз бүрийн бүлгийн дуу хоолой сонгуулийн үеэр өрсөлдөгчдийн анхааралд байх ёстой. Тэд ч бас сонгогч. Сонгуулийн мэдээлэл олон ургальч, тэнцвэртэй байвал сонгогчдод сайн мэдээлэлтэй, зөв сонголт хийх илүү боломж олгодог.

Мэргэжлийн сэтгүүл зүйд хэн нэгнийг, аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг дөвийлгөн магтах, өмгөөлөх, хамгаалах, эсвэл хурцаар эсэргүүцэн шүүмжлэх нь өрөөсгөл. Энэ нь сонгогчдыг төөрөгдүүлэх хор уршигтай. Баримтаар нотлоогүй цуу яриа, худал хуурмагт тулгуурласан мэдээлэл түгээх нь тухайн нэр дэвшигчийн улс төрийн амьдралд хохирол учруулж, ХМХ-д иргэдийн итгэх итгэлийг бууруулж, улс төрийн сонголтод нь сөргөөр нөлөөлөх том аюулыг дагуулдаг. Тиймээс сонгуулийг мэдээлж, сурвалжлахдаа сэтгүүлч олон талаас нь нухацтай хандан, баримтаар нотолж, баталгаажуулан мэдээллийн агуулгадаа ач холбогдол өгч, няхуур хандах ёстой гэдгийг сонгуулийн үеэр ажиллаж буй ХМХ-үүд ухамсарлан ойлгож, Монгол Улсын ирээдүйн сайн сайхны төлөө, ард түмэндээ сонголтдоо хийхэд нь туслах зүй ёсны үүрэгтэй юм. Сонгуулийг мэргэжлийн өндөр түвшинд, ёс зүйтэй сурвалжилж мэдээлэх нь сэтгүүлчийн үүрэг төдийгүй, олон нийт, улс орныхоо ирээдүйн өмнө хүлээж буй онцгой бөгөөд өндөр хариуцлага юм.

Сонгуулийн үеэр сэтгүүлч агуулгаа тодорхойлох, мэдээ, сурвалжилга бэлтгэхдээ тухайн нутаг, газар орон, тойргийн хүн амын насжилт, санал өгөх иргэдийн тоо, суурь боловсрол эзэмшигчдийн тоо, үндэстэн угсаатан, шашин шүтлэг, хэл соёл, төвийн болон алслагдмал орон нутгийн хүн ам зэрэг мэдээ баримтыг цуглуулах нь зүйтэй. Эдгээр мэдээлэл нь анхаарал хандуулбал зохих сонгогчид, сонгогчдын боловсролын өмнө тулгарч буй асуудал бэрхшээл, анхаарлын гадна орхигдох эрсдэлтэй хүн амын бүлэг, орон нутгийн гэх мэт асуудлыг тодорхойлоход чухал тул хэвлэл мэдээллийн байгууллага, сурвалжлагчид сонгуулийн сурталчилгааг мэдээлж, сурвалжлахдаа анхаарах нь зүйтэй.

1.2. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА

Сурталчилгааны материал гэдэг нь сэтгүүл зүйн бүтээл. Ихэнх тохиолдолд улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид өөрсдөө бэлтгэж, ХМХ-ээр дамжуулахаар гэрээ хийдэг. Гэрээ хэлэлцээр хийх нь сэтгүүлчийн бус, хэвлэл мэдээлийн менежерүүдийн ажил юм. Тухайн редакцын томилсон менежер эсвэл баг сонгуулийн штабуудын бэлтгэсэн бэлэн нийтлэл материал, зар сурталчилгаа, нэвтрүүлгийг аль хуудсанд нийтлэх, аль цагт нэвтрүүлэхээ төлөвлөдөг.

Ихэнх ардчилсан улс оронд олон нийтийн радио, телевизүүд сонгуулийн сурталчилгааг үнэ төлбөргүй, тэнцвэртэй нэвтрүүлэх үүрэг хүлээдэг. Арилжааны хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдээс хэвлэл мэдээллийн аян өрнүүлэхэд төлбөр авдаг. **Сонгуулийн төлбөртэй сурталчилгаа бол цэвэр наймаа юм. Төлбөртэй сурталчилгаа нь аль нэг нам, хүчин, хэн нэгнийг сонгохыг шууд уриалсан зар сурталчилгаа бөгөөд сэтгүүл зүйн арга барил ашиглан бэлтгэсэн төлбөртэй агуулга, материал байдаг.** Өрсөлдөгчдийнхөө тухай хэт их сөрөг, дайрч давшилсан, гутаан доромжилсон гэх мэт хэвлэл мэдээллийн ёс зүйд харшилсан байвал тэдгээр сурталчилгааг нийтлэх, нэвтрүүлэхээс татгалзах нь тухайн редакцын баримталж буй бодлого, тогтсон соёлоос хамаарна.

Сонгуулийн сэтгүүл зүй, сонгуулийн сурталчилгаа нь ардчилсан нийгэмд ХМХ чөлөөт, хараат бус, олон ургальч мэргэжлийн сэтгүүл зүйн зарчмаар ажиллаж буй эсэхийн шалгуур болдог. Тиймээс редакцууд мэдээллийн тэнцвэрт байдлаа хангахын тулд сэтгүүл зүйн агуулга, төрөл зүйл, төлбөрт сурталчилгаанд зориулах зай талбай, эфирийн цаг зэргийг эртнээс нарийн бодож, төлөвлөлт хийж, тусгай хуваариар ажиллаж, сурвалжлагчдын бүлэг, маркетингийн багаа томилдог.

Нэг нэгнээсээ салангид тусдаа байж, хоёр өөр ажил эрхэлдэг сэтгүүлч, менежер хоёр төлбөртэй материал бэлтгэх гэж хамтран ажиллах, сэтгүүлчдэдээ төлбөртэй агуулга туурвих даалгавар өгөх нь мэргэжлийн сэтгүүл зүйд харшилдаг төдийгүй хортой.

Сонгуулийн үеэр ажиллах сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд Сонгуулийн тухай хууль тогтоомж, дүрэм журмууд, Зар сурталчилгааны тухай хууль, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, мөн сонгууль болон сэтгүүл зүйн үйл ажиллагаатай холбоотой хуулийн заалтуудыг сайтар судалсан байх нь чухал.

2.1. СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЛЭХ НЬ

СОНГУУЛИЙН ҮЕЭР АЖИЛЛАХ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ ЖУРАМ

Монгол Улсын Үндсэн хууль

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
- Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль

Зөрчлийн тухай хууль

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль

Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журам (СЕХ, ХХЗХ хамтран батласан)

Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам (Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооны 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 21 дүгээр тогтоол)

СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА

Төрийн сонгууль
(Улсын Их Хурал,
Ерөнхийлөгч)

Сонгуулийн Ерөнхий Хороо нь Монгол Улсын Их Хурлын болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, ард нийтийн санал асуулгыг зохион байгуулж явуулах бүрэн эрхтэй төрийн байгууллага мөн болно.

Нутгийн өөрийн удирдлагын сонгууль
(Аймаг, нийслэл, сум
дүүргийн ИТХ-ын
сонгууль)

Сонгуулийн Ерөнхий Хороо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ҮЕЭР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛД ХЯНАЛТ ТАВИХ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА

1. Харилцаа холбооны зохицуулах хороо
2. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
3. Цагдаагийн Ерөнхий газар
4. Тагнуулын Ерөнхий газар

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ӨӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хэвлэл мэдээллийн зөвлөл (ХМЗ) нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд байгуулагдсан хэвлэмэл, цахим, радио, телевизийн хараат бус өөрийн зохицуулалтын байгууллага бөгөөд Радио, телевизийн болон Сонин, сэтгүүл, сайтын гэсэн хоёр Ёс зүйн хороотой.³

ХМХ САНАЛ ХУРААЛТААС ӨМНӨ ЮУ ХИЙХ ВЭ?

1. БҮРТГҮҮЛНЭ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.9

Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх бол сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх тухай мэдэгдлийг дараах баримт бичиг, мэдээллийн хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлж, бүртгүүлнэ

- сурталчилгааны нэвтрүүлэг явуулахаар тогтоосон нарийвчилсан цагийн хуваарь;
- ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хийж байсан гурваас доошгүй зар сурталчилгаа нэвтрүүлэх гэрээ;
- сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх дундаж үнийн талаарх мэдээлэл.

2. СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ДАГАЛДАХ ЖУРАМ, БУСАД ХАМААРАЛ БҮХИЙ ХУУЛИАР НОГДУУЛСАН ҮҮРГИЙН ХҮРЭЭНД СУРТАЛЧИЛНА.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.11

- Радио, телевиз нэгээс илүү сувагтай бол сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн үндсэн сувгаар нэвтрүүлнэ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.12

- Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх радио, телевиз нь сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчид тэгш хандах үүрэгтэй.

³ Хэвлэл мэдээллийн зөвлөл, <http://www.mediacouncil.mn/>

ХМХ-ИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- ❖ Сонгуулийг тэнцвэртэй, шударга мэдээлэх (нам, нэр дэвшигчдэд тэнцвэртэй, хараат бус, ялгаварлахгүйгээр эфирийн цаг, зай талбай олгох)
- ❖ Сонгуулийн өмнөх намын сонгуулийн сурталчилгааны нээлт болон бусад аянд оролцох (сонгуульд оролцогч бүх намуудад адил тэгш хандах).

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.13

- Радио, телевиз нь мэдээллийн хөтөлбөрөөрөө нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх сонгуулийн үйл явцын мэдээллийг хүргэхдээ бодит, тэнцвэртэй, нэг талыг барихгүй, хараат бус байх зарчмыг баримтална.

ХМХ-ИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- ❖ Редакцын хараат бус байдлыг хангах (Сонгуулийн төлбөртэй болон төлбөргүй сурталчилгаа гэж хаягласнаас бусад бүхий л контент нь сурталчилгааны агуулга, зорилго олон нийтийн эрх ашигт нийцсэн байх)
- ❖ Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сонгуулийн сурталчилгааг нийтэлж нэвтрүүлэхдээ бодитой, баримттай, олон талын эх сурвалжаар баталгаажсан мэдээллээр иргэдийг хангах
- ❖ Бүх намуудын мөрийн хөтөлбөрийг харьцуулсан контент бэлтгэх (инфографик, анимейшн г.м.)

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.15

- Радио, телевиз сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй.

ХМХ-ИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- ❖ Сонгуулийн хороо, хэсгийн хорооны үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг харуулсан контент бэлтгэх (Жишээ нь, урьдчилсан санал асуулга хэрхэн авч байгаа, сонгогчдын нэрсийн жагсаалтын талаар гэх мэт)
- ❖ Сонгуулийн үеэр мэргэжилтнүүдийн эх сурвалж буюу гадаад, дотоодын сонгуулийн шинжээчидтэй харилцаа холбоотой байж, тэдний оролцсон сурвалжилга, ярилцлагыг түлхүү нийтэлж, нэвтрүүлэх (Эдгээр эх сурвалж нь хамгийн бодит мэдээллийг өгдөг боловч хамгийн бага нийтлэгдэж, нэвтрүүлэгддэг тул үүнд анхаарал хандуулах)
- ❖ Сонгуулийн амлалтын талаар урьдчилан мэдээ материал цуглуулж, харьцуулсан, дүн шинжилгээтэй, хийсвэр амлалтын хор уршгийг таниулсан контент бэлтгэн, нийтэлж нэвтрүүлэх (Сонгуулийн хуульд

ямар нэг амлалт өгч сонгогчийн санал авахыг хориглосон боловч энэ үзэгдэл бодит байдал дээр байсаар байна. Жишээ нь, хөдөө орон нутгийн оюутнуудад унааны зардал болон төлбөрийг олгох, нэг удаагийн мөнгөн тусламж гэх мэт бусад тусламж үзүүлэх нь улс төрийн эрх барих, улс орны хөгжилд муугаар нөлөөлнө гэдгийг ойлгуулах)

- ❖ Сонгогчийн боловсролын асуудалд анхаарал хандуулж, сонгуульд оролцох, сонгох эрхийн талаар мэдээлэл өгөх (санал өгөх насанд буюу 18 нас хүрэгчдэд зориулсан контентийг ХМХ-үүд урьдчилан бэлтгэн нийтлэх)
- ❖ Тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөртэй сайтар танилцаж, мөрийн хөтөлбөрт тусгагдсан асуудлыг ямар арга замаар, хэрхэн хэрэгжүүлэх тухай тодорхой асуулт тавьж, мэдээлэх.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.16

- Радио, телевизийн редакцад бэлтгэгдээгүй, сонгуульд оролцогч нам, эвсэл, нэр дэвшигчийн зүгээс бэлтгэн нийлүүлсэн мэдээ, нэвтрүүлгийг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамааруулна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.17

- Улс төрийн мэтгэлцээний талаарх нэвтрүүлэг, хөтөлбөр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэгт хамаарахгүй боловч уг нэвтрүүлэг, хөтөлбөрт нэг намын бус, түүнчлэн бие даагч хэд хэдэн нэр дэвшигч, эсхүл өөр өөр нам, эвслийн төлөөлөл оролцсон байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.19

- Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй.

ХМХ-ИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- ❖ Сонгуулийн дүнг мэдээлэх (сонгуулийн үеэр аль нэг талыг барихгүй иргэдийн санал бодлыг чөлөөтэй нэвтрүүлэх, сонгуулийн ил болон далд үйл явцыг эрэн сурвалжлах).

3. СОНГУУЛИЙН ҮЕЭРХ ХЯЗГААРЛАЛТ

- ❖ Бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.10).
- ❖ Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй боловч нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх

мэдээг хоногт таван минутаас хэтрүүлэхийг хориглоно (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.15).

- ❖ Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хуваарь, цагийг бусад нам, эвсэл, нэр дэвшигчид шилжүүлэхийг хориглоно (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.18).
- ❖ Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийн талаарх мэдээ, мэдээллийг дагнан гаргах, эсхүл гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48.7).
- ❖ Нам, эвслийн дарга, түүнчлэн нэр дэвшигч нь сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал сонгуулийн сурталчилгааны бус бие даасан нэвтрүүлэг, хөтөлбөр, ярилцлагад орохыг, түүнчлэн сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө хийгдсэн аливаа нэвтрүүлэг, хөтөлбөр, дуу, дүрс бичлэг, ярилцлагыг нэвтрүүлэх, нийтлэхийг хориглоно (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48.9).

4. ХУУЛЬ, ДҮРЭМ ЖУРАМ ЗӨРЧСӨН ТОХИОЛДОЛД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Сонгуулийн Ерөнхий хороо (СЕХ) болон Харилцаа Холбооны Зохицуулах Хороо (ХХЗХ)-ны 2020 оны 04 сарын 07-ны өдрийн дугаар 18/22-тоот хамтарсан тогтоол:

- ❖ Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмыг зөрчсөн бол эхний удаад сануулах арга хэмжээ авах, эсхүл радио, телевизийн сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхийг санал авах өдөр хүртэл цуцлах тухай шийдвэр гаргана ([Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.24](#)).
- ❖ Бүртгүүлээгүй радио, телевизээр сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлсэн бол телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгоно (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.25).
- ❖ Сонгуулийн сурталчилгаа зогсоох хугацаанаас өмнөх 48 цагт доорх зөрчил гаргасан бол Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо хүчингүй болгоно (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.26).
- ❖ Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт нэг цаг /60 минут/-аас илүүгүй байна (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.6).
- ❖ Сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлгийн хоногт гарах нийт хугацаа

/60 минут/-ны хорин таваас илүүгүй хувь /15 минут/ нь нэг нам, эвсэлд, түүнчлэн бие даан нэр дэвшигчдэд ногдоно ([Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 46.7](#)).

5. СОНГУУЛИЙН ДАРАА СЭТГҮҮЛЧ, ХМХ ЮУ ХИЙХ ШААРДЛАГАТАЙ ВЭ?

1. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, амлалтыг сайтар судалсны үндсэн дээр сонгуульд ялсан нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, амлалтыг нэхэн сануулж байх нь зүйтэй.
2. Сонгуулийн сурталчилгаа явуулсан ХМХ сонгуулийн сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор сурталчилгаа явуулсан талаарх тайланг тухайн ОНМХ-ээр мэдээлнэ.

Хүснэгт №1

Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийн доор үзүүлсэн бүрэн эрхийн хүрээнд улс оронд тулгамдаж буй асуудлуудыг тэд хэрхэн, хэзээ, яаж шийдвэрлэх талаар нийтлэл нэвтрүүлэг бэлтгэж болно.

<p>УИХ-ын гишүүний бүрэн эрх (Монгол Улсын Их Хурлын тухай хуулийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон. Тиймээс МУ-ын УХ-ийн 3-р бүлгийн 27-р зүйлд заасны дагуу)</p>	<p>Ерөнхийлөгчийн бүрэн эрх (Монгол Улсын Үндсэн Хуулийн 3-р бүлгийн 33-р зүйл)</p>	<p>Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрх (Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2-р бүлгийн 12-р зүйл)</p>
<p>хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;</p> <p>төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох;</p> <p>Ерөнхийлөгчийн ба Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;</p> <p>Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх;</p> <p>Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах;</p> <p>Ерөнхий сайд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;</p> <p>төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг,</p>	<p>Улсын Их Хурлын батласан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;</p> <p>Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;</p> <p>Гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;</p> <p>Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;</p> <p>Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;</p>	<p>Асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;</p> <p>Хэлэлцэж байгаа асуудлын талаар асуулт тавьж хариулт авах, санал дүгнэлт гаргах, санал хураалгах;</p> <p>Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;</p> <p>Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, Тэргүүлэгчдийг сонгох, хороо байгуулах, тэдгээрт сонгогдох, бүрэлдэхүүнд нь өөрчлөлт оруулах тухай санал, дүгнэлт гаргах;</p> <p>Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх санал гаргах;</p> <p>хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах;</p> <p>хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг</p>

СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

<p>нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;</p> <p>Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.</p> <p>Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ, Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.</p> <p>Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно:</p> <p>хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;</p> <p>Улсын хил тогтоох;</p> <p>Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох;</p> <p>Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх;</p> <p>нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;</p>	<p>улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;</p> <p>уучлал үзүүлэх;</p> <p>Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;</p> <p>Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;</p> <p>бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;</p> <p>Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.</p> <p>Ерөнхийлөгч Монгол Улсын зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна.</p> <p>Ерөнхийлөгч Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно.</p>	<p>хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах;</p> <p>хуралдааны шийдвэрийн биелэлтийг тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр шалгах, шаардлага тавьж биелэлтийг хангуулах;</p> <p>сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах.</p> <p>Нийтийн сонголын тухай хуульд заасны дагуу нийтийн сонгол явуулах хүсэлт гаргах.</p> <p>орон нутгийн буюу тухайн аймаг, нийслэлийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийг хувьчлалаас гадуур худалдах, шилжүүлэх талаар Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцэж шийдвэрлэх;</p> <p>орон нутгийн өмчийг хувьчлах бодлого, чиглэл, хувьчилж үл болох орон нутгийн өмчийн жагсаалтыг Засаг даргын өргөн мэдүүлснээр хэлэлцэж батлах, түүнд өөрчлөлт оруулах;</p> <p>хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>
---	---	--

улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох;

өршөөл үзүүлэх шийдвэр гаргах;

Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах;

Ард нийтийн санал асуулга явуулах. Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно; Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхын санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах;

энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох.

Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ НИЙТЭЛЖ, НЭВТРҮҮЛЭХ НЬ **3.**

Сэтгүүлч, ХМХ нь Монгол Улсын Үндсэн хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Бүх шатны сонгуулийн хууль тогтоомжийн дагуу сонгуулийн аян, бүх шатны сонгуулийн явцын талаар иргэдэд үнэн бодит мэдээлэл түгээх үүрэгтэй.

Хэвлэлийн Хүрээлэнгээс 2020 оны Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн сурталчилгааны мониторинг хийсэн юм. Тус мониторингийн дүнгээр “Сонгуулийн сурталчилгааны албан ёсны хугацаанд буюу 2020 оны 6 дугаар сарын 2-22-ны өдрүүдэд Фэйсбүүкээр түгээсэн, сонгуультай холбоотой мэдээллийн 80 гаруй хувь нь төрөл бүрийн ил, далд ухуулга, сурталчилгаа болон өрөөсгөл, дэгсдүүлсэн, бүрэн бус, гуйвуулсан мэдээлэл байв. Эдгээрээс зөвхөн 20 орчим хувь нь нам, нэр дэвшигчийн нэр, лого бүхий хууль ёсны сурталчилгаа, үлдэж буй дийлэнх хэсэг нь ухуулга байх магадлалтай хувь хүний үзэл бодол, мөн бусдын үзэл бодлыг баримт мэт харагдуулах, нэр дэвшигч, нам, эвслийн нэр хүнд, итгэл үнэмшлийг унагах, дөвийлгөх, буруутгах, эргэлзээ төрүүлэх зорилго бүхий мэдээлэл байв.”⁴ Худал, дэгсдүүлсэн, буруу ташаа мэдээлэл нь олон нийтийг төөрөгдүүлж, мэдээлэлтэй сонголт хийхэд нь саад учруулдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь үнэн бодит, тэнцвэртэй мэдээлэл түгээснээр иргэдийн мэдэх эрхийг жинхэнэ утгаар нь хангаж чадна.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ НЬ СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦАД ОРОЛЦОГЧ ЭТГЭЭДИЙН ХУВЬД СОНГУУЛИЙН АЯНЫГ ДАРААХ БАЙДЛААР МЭДЭЭЛЖ, СУРВАЛЖИЛНА. ҮҮНД:

- ✓ Сонгуульд оролцогч бүх нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг харьцуулсан контент бэлтгэх (инфографик, анимейшн г.м.)
- ✓ Сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэл олон нийтийн эрх ашигт бус, улс төрийн нам, нэр дэвшигчдэд үйлчлэх хандлага гаргахгүй байх (Тухайн хэвлэл мэдээллийн эзэмшигчийн харъяалагддаг нам, эвсэлээс хамааран тухайн нам, эвсэлд сонгогчдын хамгийн их үзэж, сонсдог оргил цагуудаа өгөх гэх мэтээр давуу байдал олгохгүй байх.)
- ✓ Сонгуулийн үеэр санал асуулгыг зайлшгүй тохиолдолд мэдээлэх (ямар нэг судалгааны байгууллагын явуулсан) нь сонгогчийн шийдвэр гаргахад нөлөөлж мэдэх тул болгоомжтой хандах шаардлагатай.
- ✓ “Худал мэдээлэл”-ийн тархалт, үр дагаврыг тооцож, мэдээлэлтэй, мэдлэгтэй сонгогч төлөвшүүлэхийн тулд хэвлэл мэдээллийн суурь боловсролыг дэмжин ажиллах хэрэгтэй.
- ✓ Цахим орчин, технологийн улмаас уламжлалт сэтгүүл зүй өөрчлөгдөж буй энэ үед сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаанд олон сорилт тулгарч байгаа гэдгийг цаг ямагт санаж байх нь зүйтэй.

⁴ Хэвлэлийн Хүрээлэн, 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр түгээсэн мэдээллийн мониторинг, https://pressinst.org.mn/wp-content/uploads/2020/12/IRI_DISINFO_MONITORING_FINALREPORT.pdf

- ✓ Сонгуулийн үеэрх сурталчилгаанд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчид Үндсэн хууль, Сонгуулийн хуулиудын заалтуудыг баримтлан ажиллахын зэрэгцээ мэргэжлийн ур чадвар, ёс зүй, нэр төр, аюулгүй байдлаа хангаж ажиллах нь зүйтэй.

Бүх нийтийн тэгш, ардчилсан, шударга сонгуулийн үр дүн хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн үйл ажиллагаанаас ихээхэн хамаарна. Ардчиллыг бэхжүүлэх, иргэдийн төрийн эрх барих байгууллагаа сонгоход мэдээллийн эрх чөлөө хамгийн чухал үүрэгтэй. Нөгөө талаар, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь сонгогчдын “дуу хоолой” болдог. Иймд намуудын эрх мэдэл, нэр хүнд, нэр дэвшигчдийн мэдээлэл, сонгуулийн хорооны мэдээлэл зэргийг нээлттэй мэдээлэх шаардлагатай. Намуудын мөрийн хөтөлбөр нь иргэд, айл өрхүүдэд тараагддаг хэдий ч түүнийг уншдаг, дүн шинжилгээ хийдэг иргэд нэн ховор тул редакцууд энгийн, хамгийн ойлгомжтой хэлбэрээр иргэдэд мэдээлэх нь зүйтэй.

Редакцууд улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчидтэй сонгуулийн сурталчилгааны гэрээ байгуулдаг. Гэрээний дагуу сонгуулийн штабаас ирүүлж байгаа мэдээллийн агуулгыг нягтлаж байх хэрэгтэй. ХМХ нь “хар пиар” (PR) хийхээс зайлсхийж, мөрийн хөтөлбөр, зорилгоо сурталчлахыг тэднээс шаардах эрхтэй. Мөн сэтгүүлчид сонгуулийн сурталчилгааг дамжуулахдаа аль болох төвийг сахиж, өөрийн үзэл бодлыг тулгахгүй байх, нэг талд үйлчлэхгүй байх, мэдээллийг олон эх сурвалжаас авахыг эрхэмлэнэ.

Нийтэлж нэвтрүүлсэн контентоо хадгалах, баримтжуулах нь хэвлэл мэдээллийн байгууллага болон сэтгүүлчийг болзошгүй эрсдэлээс хамгаалдаг.

СОНГУУЛИЙН ҮЕЭР РЕДАКЦЫН БАРИМТЛАХ БОДЛОГО

4.

Сэтгүүлчид хөдөлмөрийн гэрээний дагуу ажил үүргээ гүйцэтгэдэг тул тэднээс ямар уран бүтээл, ямар нийтлэл, нэвтрүүлэг гарах нь тухайн редакцын баримталж буй бодлоготой шууд холбоотой. Иймээс, ХМХ-үүд сонгуулийн үеэр баримтлах дотоод бодлого боловсруулан, хэрэгжүүлэх нь чухал.

СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ БОЛОВСРУУЛАХ ҮЙЛ ЯВЦАД ИДЭВХТЭЙ ОРОЛЦОХ НЬ. Сонгуулийн тухай хуулийн хэвлэл мэдээлэлтэй холбоотой заалтууд нь амьдралд хэрэгжих боломжтой, шударга, зүй ёсны эсэхэд редакцууд хяналт тавих нь эхний чухал алхам мөн. Шударга бус сонгуулийн хуулийг сахин биелүүлэх нь нийгмийн өмнө хариуцлагаа хүлээх явдал биш. Эрх баригчид ямагт сэтгүүлчдийг хараандаа, өөрсдийн үгээр байлгахын тулд хуулийн заалтыг чангатгах, журмуудад улам олон заалт нэмж оруулахыг хичээдэг. Эндээс редакц хараат бус байхын төлөөх “тэмцэл” эхэлнэ.

Сонгуулийн тухай хууль, журам нь олон нийтийн мэдэх эрхийг хангаж чадаж байна уу, үнэн бодит, хүртээмжтэй мэдээллээр иргэдийг хангах боломж бий юу гэдэгт анхаарах шаардлагатай. Тухайлбал, сонгуулийн сурталчилгааны хугацаа хэт богино байх нь олон нийтэд хангалттай мэдээлэл олж авах, түүнийгээ эргэцүүлэн тунгаах боломж олгодоггүй. Богино хугацаанд, олон мэдээлэл дунд төөрөлдөх, шинэ нэр дэвшигчийн талаар ямар ч мэдээлэлгүй хоцрох тохиолдол олон гардаг.

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаа 18 хоног байсан. Сонгуулийн сурталчилгааны хугацаа хэтэрхий богино, мөн хуулиар мөрийн хөтөлбөрүүдийг урьдчилан батлахыг зааж өгсөн зэрэг нь нэр дэвшигчдийг олон нийтэд үзэл санаагаа илэрхийлэх боломжийг нь хязгаарласан гэж Олон Улсын Сонгуулийг Ажиглах Хорооны тайланд дурджээ.⁵ 2020 оны орон нутгийн сонгуулийн сурталчилгааны хугацаа 22 хоног байсныг 15 болгож богиносгосон асуудлын талаар ХМХ-үүд мэдээлээд өнгөрснөөс биш, яагаад ийм заалт оруулсан, энэ нь ямар сөрөг үр дагавартай талаар нийтлэл, нэвтрүүлэгтээ дурдаагүй байна. Ийнхүү сурталчилгааны хугацаа бага байгаа нь шударга сонгууль болох нөхцлийг бүрдүүлж чадахгүй. Тиймээс ХМХ-үүд иргэдийн дуу хоолой нь болж, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай.

УИХ-ын 2020 оны сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үйл явдлын мэдээлэл дамжуулахад түлхүү анхаарч, харин нам, улс төрчдийн булхайг илрүүлсэн, хийсэн ажлыг нь үнэлж дүгнэсэн нийтлэл, нэвтрүүлгээс зайлсхийх хандлага нийтлэг ажиглагдаж байсан нь сэтгүүлчдийг бусдыг гүтгэх, доромжлох, илт худал мэдээлэл тараах үйлдэлд хариуцлага хүлээлгэх заалтуудтай холбоотой.

2017 онд батласан Зөрчлийн тухай хуулиар сэтгүүлч бусдыг гүтгэсэн гэх гомдол ирвэл тухайн сэтгүүлч олон хоног цагдаагийн байгууллагын “үүд сахидаг” байсан. Харин 2020 оны нэгдүгээр сард Эрүүгийн хуульд “илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол...” гэсэн шинэ заалт орсон нь редакцууд болон сэтгүүлчдийг эрсдэлтэй алхам хийхээс эмээхэд хүргэсэн.

⁵ Олон Улсын Сонгуулийг Ажиглах Хороо (OSCE ODIHR, OSCE PA, European Parliament), Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26, Урьдчилсан үр дүн ба дүгнэлтийн тайлан, <https://www.osce.org/files/f/documents/7/3/327166.pdf>

Энэ нь нэг талаас, хуулийг хэрэгжүүлж байгаа мэт боловч улс төрчдийн булхай луйвар, хууль зөрчсөн үйлдлийн талаарх мэдээлэл олон нийтэд хүрч чадахгүй, иргэд дутуу мэдээлэлтэйгээр сонголтоо хийх эрсдэл дагуулдаг. Тиймээс редакцууд тухайн мэдээлэл хуулийн хариуцлага хүлээхээр худал мэдээлэл, гүтгэлэг мөн үү гэдэгт анхаарахгүйгээр нам, улс төрчдийг шүүмжилсэн л бол нийтэлж, нэвтрүүлэхээс татгалзаж буй нь хэвлэлийн эрх чөлөөнөөс сайн дураараа татгалзаж буй хэрэг юм. Үүнээс үүдээд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд үнэн бодит мэдээллийг хүргэх, иргэдийн дуу хоолой болох, тэнцвэртэйгээр мэдээлэх зэрэг олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ хойш тавихад хүрч байна.

ХАРААТ БУС БАЙДЛАА БЭХЖҮҮЛЭХ НЬ. Дэлхий даяар улс төр, бизнесийн хүрээнийхэн олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшиж, эрх мэдэл нэг гарт төвлөрөх үзэгдэл түгээмэл байна. Олон нийт таамаглахаас биш хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшигч, хөрөнгө оруулагчийн талаарх мэдээлэл бүрхэг. Ийм нөхцөлд сэтгүүлчид бодит, тэнцвэртэй мэдээлэл хүргэхэд улам хүндрэлтэй болж, саад бэрхшээл их тулгардаг. Үүнд, редакцын хараат бус байдалд нийтлэл, нэвтрүүлгийн бодлогодоо цензур тавих, сэтгүүлчийн нэрийг ашиглах, сэтгүүлчийн хүсэл зоригийн эсрэг нийтлэл бичүүлэх, нэвтрүүлэг бэлтгэх даалгавар өгөх зэрэг багтана.

2018 онд нэгэн өдөр тутмын сонин (тус сонины сэтгүүлч өөрийн болон байгууллагын нэрийг нууцлахыг хүсэв) хуульч М-ийн талаар худал мэдээлэл бэлтгэсэн гэдэг үндэслэлээр хуулийн байгууллагад дуудагдсан. Тухайн үед ийм хэргийг Зөрчлийн тухай хуулиар зохицуулж, аж ахуйн нэгжийг 20 сая төгрөгөөр, сэтгүүлчийг хоёр сая төгрөгөөр торгох заалттай байв. Уг хэргийг шалгах явцад тухайн редакц нь сэтгүүлчийн хүсэл зоригийн эсрэг үүрэг даалгавар өгч бичүүлсэн нь тогтоогдсон бөгөөд сэтгүүлч нь үүнд хариуцлага хүлээхгүй гэдгээ мэдүүлсэн. Тиймээс редакц нь нэхэмжлэгчээс уучлал хүссэнээр хэрэг хаагдаж байжээ.

Хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдлыг хангах хэд хэдэн арга байдаг. Үүнд, ХМХ-ийн үүсгэн байгуулагч, өмчлөгч, хувь эзэмшигчийг хуулиар нээлттэй, ил тод болгож болно.⁶ Тухайлбал, 1984 онд батласан Франц улсын “Ил тод байдлын тухай хууль”-д хувьцаа эзэмшигчээ ил тод зарлахыг шаардсан байдаг. Ийм төрлийн зохицуулалтыг Итали, Нидерланд зэрэг орнууд хуульдаа тусгасан. Мөн өөрийн зохицуулалтын замаар, ёс зүйн зарчимд тусгаж болно. Редакцын хараат бус байдлыг бэхжүүлэх талаарх заалтыг улс орнууд хуулиар болон ёс зүйн дүрмүүдээр зохицуулж байна.

Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Швейцарь Улс “Сэтгүүлчийн эрх ба үүргийн тунхаглал” баримт бичигтээ тусгасан. Герман улс Хэвлэл мэдээллийн тухай хуульдаа тусгаснаас гадна “Сэтгүүлчийн ёс зүйн дүрэм” баримт бичигтээ илүү дэлгэрэнгүй зохицуулсан байдаг. Тус дүрмийн долдугаар хэсэгт “сэтгүүл зүйн үүрэг хариуцлага болон түүний утга, агуулгад бизнесийн болон бусад хувийн сонирхолтой гуравдагч этгээд нөлөөлөхгүй байх, сэтгүүлч нь өөрийн сэтгүүлчийн үүргийг хувийн болон арилжааны ашиг сонирхлоос тусгаарлах ёстой” гэжээ.

⁶ Батзориг, Т. (2019) Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа, х.176.

Олон улсад редакц болон эздийн хооронд нийтлэл, нэвтрүүлгийн агуулгатай холбоотой гэрээ, санамж бичиг байгуулдаг жишиг бий. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрхлэгч, албаны дарга, нөлөө бүхий сэтгүүлчдээс бүрдсэн зөвлөл байгуулж, эзэдтэй үйл ажиллагааныхаа горим, журмыг тохирдог. Ингэхдээ, эзэд нь санхүү, менежментийн ажилд бүрэн эрхтэйгээр оролцох ч нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хэлбэрт хөндлөнгөөс оролцохгүй гэсэн гэрээ хийхийг олон улсын мэргэжлийн байгууллагууд зөвлөдөг.

Манай улсад 2012 ба 2015 онд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийн хэлэлцүүлгийн үеэр ийм гэрээний талаар идэвхтэй яригдаж байсан хэдий ч үүнийг ажил хэрэг болгосон редакц ховор. Энэ нь эзэн, редакц хоорондын гэрээ бодит байдал дээр хэрэгжих нь тун төвөгтэй гэдгийг харуулна. Иймээс, нэн тэргүүнд сэтгүүлчид өөрсдөө редакцынхаа өмнө бие даасан байдлаа хамгаалдаг болох, түүнийг нь хамт олон нь хөхиүлэн дэмждэг байх, эзэд нь хүлээн зөвшөөрдөг болох соёл тогтоохыг эрмэлзэх хэрэгтэй. Ийм соёл тогтоох амаргүй ч редакцууд эзэдтэйгээ санамж бичиг, зөвлөмж, журам зэрэг төрөл бүрийн аргаар албажуулж, алхам алхмаар хараат бус байдлаа хангахыг хичээх нь зүйтэй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр хүнд олон нийтийн дунд ямар түвшинд байгаа, сонгуулийн үеэр нэг талыг дэмжсэнээр байгууллагын нэр хүнд, цаашдын ашиг орлогод хэрхэн сөргөөр нөлөөлөх талаар удирдлагатайгаа нээлттэй ярьж хэлэлцдэг байх нь чухал.

Сонгуулийн үеэр улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдээс хараат бус байх нэг арга нь хамтран ажиллах гэрээний заалт бүр тодорхой, хоёр тал ижил ойлголттой байх явдал юм. Сонгуулийн үеэр улс төрийн намууд редакцуудтай сурталчилгаа түгээх гэрээ байгуулдаг. Хамтран ажиллах гэрээ байгуулсан бол тухайн нам, нэр дэвшигчийн талаарх сөрөг мэдээллийг нийтэлж болохгүй гэсэн хандлага байдаг. Тиймээс анхнаасаа хамтран ажиллах гэрээнд гүйцэтгэх ажлаа маш нарийн, тодорхой зааж өгөх ёстой. Хэрэв сөрөг мэдээлэл нийтэлж, нэвтрүүлсэн гэж үзээд, захиалагч тал гэрээгээ цуцалбал гэрээг цуцалсан нөхөн төлбөрийг захиалагч тал төлөхөөр тохиролцох боломжийг эрэлхийлэх нь зүйтэй. Мөн гэрээний дагуу нийтэлж, нэвтрүүлж буй материалын агуулга болон техникийн алдаа гарсан эсэхийг нягтлах үүргээ мартаж болохгүй. Төлбөртэй мэдээлэл алдаатай нийтлэгдсэн тохиолдолд нийтлүүлсэн этгээд хариуцлага хүлээдэг ч редакцын нэр хүнд давхар яригддаг билээ.

БҮХ НЭР ДЭВШИГЧДЭД АДИЛ ТЭГШ БОЛОМЖ ОЛГОХ НЬ. Сонгуулийн тухай хуулийн 46.12-д сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг нэвтрүүлэх радио, телевиз нь сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигч тэгш хандах үүрэгтэй гэж заасан. Тэгш хандах гэдэгт эфирийн цагийг нэр дэвшигчдэд тэгш хуваарилах, үг хэлэх боломжийг нь тэгш олгох зэрэг хамаарна. Ялангуяа, сонгуулийн өмнөх жилд сонгогчид хэвлэл мэдээллийн хэрэгслийн оргил цагаар олон удаа гарсан хүний нэр, царай төрхийг илүү тогтоох магадлалтай байдаг. Тиймээс олны танил, өмнө нь УИХ-ын гишүүн байсан, улс төрийн нөлөө бүхий хүнийг сонгох магадлал өндөр. Нөгөө талаар, сонгуулийн сурталчилгааны цөөхөн хоногт залуу нэр дэвшигчид өөрсдийгөө таниулж чадахгүй байх явдал гардаг.

Телевизүүд нийт эфирийн цагийг нам, эвсэл, нэр дэвшигчдэд адил тэнцүү хуваарилах нь чухал. Гэхдээ үзэгчид хамгийн идэвхтэй байдаг оргил цагийн эфирээ нэр дэвшигчдэд адил тэнцүү хуваарилах нь жинхэнэ утгаараа ялгаварлахгүйгээр тэгш боломж олгож буй явдал юм.

Бодит байдал дээр хууль, судалгааны байгууллагууд бүх хэвлэл мэдээллийн хэрэгслийн эфирийн цаг, зай талбайг судлан хэмжих боломж байдаггүй. Тухайлбал, Монголын судалгааны байгууллагууд веб сайт, сонин, сэтгүүлүүд нэр дэвшигчдэд тэгш боломж олгож чадаж байгаа эсэхийг хэмжих судалгаа хийх нь ховор. Эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувьд, хуульд сонгуулийн сурталчилгааны материалын хэмжээг зааснаас биш, тэгш хандах үүргийг радио, телевизтэй адил үүрэг болгоогүй. Гэсэн ч редакцууд шударга, тэгш ардчилсан сонгууль, тийм нийгмийн төлөө нэр дэвшигчдэд эрх тэгш хандаж чадаж байгаа эсэхдээ дотоод хяналт тавих нь зүйтэй.

СОНГОГЧДЫН ДУУ ХООЛОЙ БОЛОХ НЬ. Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь сонгуулийн үйл явцыг дамжуулан мэдээлэх, нам эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгааг хүргэх, олон нийтийн сонгуулийн боловсролыг дээшлүүлэх зорилготойгоор зэрэг төрөл бүрийн нийтлэл, нэвтрүүлгийг нэвтрүүлэхээс гадна сонгогчдын үзэл бодлын индэр, дуу хоолой болох нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ирсэн. Ийм боломжийг ч сонгуулийн мөчлөг олгодог онцлогтой. Сонгуулийн жилд улс төрчид олон нийтэд таалагдахын тулд иргэдэд тулгарч буй асуудалд илүүтэй анхаардаг. Тэдний асуудлыг сонсдог, шийддэг улс төрчийн имижтэй болохыг хүсдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд энэ байдлыг ашиглаж жирийн иргэдэд ярих боломж олгож, дуу хоолой, үзэл бодлоо улс төрчдөд хүргэх гүүр нь болсоор ирсэн. Иргэд нам, эвслийн өнгөрсөн жилүүдэд хийсэн ажлыг хэрхэн дүгнэв, тэднээс юу хүсэн хүлээж байна вэ гэдгийг хүргэснээр төр, иргэн хоёрын хооронд эргэх холбоо бий болдог.

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ. Нийгмийн тэгш байдал, сайн сайхны төлөө зүтгэж байгаа учраас сонгуулийн үеэр жендэрийн тэгш байдлыг хангах нь редакцын цаасан дээр бичигдээгүй үүрэг мөн. Эрэгтэй, эмэгтэй хүн нийгэм болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байж, хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдахыг жендэрийн тэгш байдал гэнэ⁷.

Зөвхөн сонгуулийн үеэр ч гэлтгүй бүхий л цаг үед эрэгтэй, эмэгтэй улс төрчдийн дүр төрхийг эрх тэгш харуулах нь иргэдийн улс төрийн сонголтод жинтэй нөлөөлдөг. Эрдэмтэн судлаач, улс төрч, лидер, УИХ-ын гишүүн гэхээр эрэгтэй хүн, эмч, багш, үйлчилгээний ажилтан гэхээр эмэгтэй хүний дүрээр төсөөлдөг хэвшмэл ойлголт нийгэмд түгээмэл байна. Угтаа бол эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ажил мэргэжилд хүйс хамаагүй байх ёстой. Гэтэл 2009 онд Хараат Бус Судалгааны Хүрээлэнгийн (IRIM) гаргасан “Жендэр ба сэтгүүл зүй” судалгааны тайланд амралт, чөлөөт цаг, соёл урлаг зэрэг сэдэвт эмэгтэй, харин улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, спортын салбарт эрэгтэй хүн холбоотой гэсэн ойлголтыг хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд олон нийтэд түгээж байна гэж дүгнэжээ.

⁷ Хүний эрх хөгжил төв (2003), Жендэр судлалын удиртгал, х.17.

2009 онд IRIM судалгааны хүрээлэнгээс жендэрийн үүрэг, оролцоог телевиз, сонин хэвлэлээр хэрхэн дүрслэн харуулдаг талаар хоёр сарын хугацаанд хийсэн агуулгын дүн шинжилгээгээр, “телевиз, сонин, сэтгүүлүүд амралт, чөлөөт цаг, соёлын холбогдолтой сэдвээр нэвтрүүлэг, нийтлэл бэлтгэхдээ эмэгтэйчүүдээр түлхүү төлөөлүүлж, харин улс төр, эдийн засаг, хууль эрх зүй, спорт зэрэг сэдвийг эрэгтэйчүүдээр төлөөлүүлэх нь элбэг байгаа нь ажиглагдсан бөгөөд энэ нь олон нийтийн дунд жендэрийн хэвшмэл ойлголтыг улам түгээн дэлгэрүүлсэн үйлдэл юм.”⁸

Дарга, улс төрч, УИХ-ын гишүүн гэхээр эрэгтэй хүнийг төсөөлдөг хэвшмэл ойлголт нь сонгогчдын саналд их бага хэмжээгээр нөлөөлж, улс төрийн салбар дахь жендэрийн тэгш бус байдлыг өөгшүүлж байдаг. Сонгогч нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэлгүй тохиолдолд өөрийн хэвшмэл ойлголтоор эрэгтэй хүнийг сонгох нь түгээмэл гэж үздэг. Улс төрийн сэдэвтэй нэвтрүүлэгт ихэнхдээ эрэгтэй улс төрч, судлаачдыг урих нь ийм сонголт хийх далд ухамсар, хэвшмэл ойлголтыг дараа үеийн сонгогчдод төлөвшүүлдэг. Сэтгүүлчид “УИХ-д цөөхөн эмэгтэй гишүүн сонгогдлоо”, “УИХ-ын 11 эмэгтэй гишүүний нэг”, “Ганцхан эмэгтэй сайд” гэх зэргээр бичих нь наанаа эмэгтэй улс төрчийг дэмжиж буй мэт харагдах авч, цаагуураа улс төрийн салбарт эмэгтэйчүүд цөөн байдаг гэсэн хэвшмэл ойлголтыг улам дэвэргэсээр байдаг. Тиймээс ХМБ-ын удирдлагууд сэтгүүлчдийнхээ жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах, мөн түүнчлэн нийтлэл, нэвтрүүлэг, мэдээ сурвалжилга, зар сурталчилгаан дахь жендэрийн мэдрэмжтэй байдлыг хангах, ёс зүйн код, редакцын бодлогодоо жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг тусгах нь зүйтэй.⁹

НИЙГМИЙН СҮЛЖЭЭ АШИГЛАХ НЬ. Редакцууд мэдээллээ түгээхдээ олон нийтийн сүлжээг хэрхэн ашиглах талаарх дотоод дүрэм, журамтай байх нь сэтгүүлчид болон редакцын нэр хүндийг олон эрсдлээс холдуулна. Редакцууд нийгмийн сүлжээнд албан ёсны хуудсуудаа албажуулж, түүнийг өөрийн ажлын талбарын нэг хэсэг гэж үзэж, хууль дүрэм, ёс зүйн журмыг мөн адил мөрдөх ёстой. Тухайлбал, ikon.mn сайт редакцын бодлогодоо олон нийтийн сүлжээнд хэрхэн ажиллах талаар заасан. Ингэхдээ фэйсбүүк, твиттерийн албан ёсны хуудсаа нэрлэсэн. Мөн тухайн редакцын сэтгүүлчид олон нийтийн сүлжээн дэх хувийн хуудсаараа өөрийн болон бусад агуулгыг түгээх эрхтэй.

“Олон нийтийн сүлжээ дэх хувь хүний хувийн үзэл бодол нь нийт байгууллага хамт олон болоод ikon.mn сайтын редакцын нийтлэг эрх ашгийн төлөөлөл болохгүй” гэж заажээ. Энэ нь харьцангуй зөөлөн зохицуулалт юм. Харин ардчилал хөгжсөн улс орнуудад сэтгүүлч нийгмийн чухал асуудал, улс төрийн байр сууриа хувийн нийгмийн сүлжээгээр илэрхийлэх нь ёс зүйд харш гэж үзэх нь түгээмэл байдаг.

8 Швейцарын Хөгжлийн Агентлаг, IRIM (2014), Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа, https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/mn/2015-Gender-Overview-%20Desk-Study-Mongolia_MN.pdf

9 ЮНЕСКО (2014) Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт, Орч. Глоб Интернэшнл төв, <http://globeinter.org/mn/images/upld/Genderbookast2014.pdf>

Хэдийгээр сэтгүүлч хувь хүнийхээ хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй ч олон нийт үүнийг тухайн сэтгүүлчийн ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагын байр суурь хэмээн хүлээж авдаг. Сэтгүүлч аль нэг нам, улс төрчийг дэмжиж буйгаа нийгмийн сүлжээгээр илэрхийлэх нь мэргэжлийнхээ давуу байдлыг санаатайгаар ашигласан явдалд тооцогдоно. Тиймээс барууны хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сэтгүүлч нь байгууллагынхаа өмнөөс байр суурь илэрхийлэх эрхгүй гэж үзэн, сэтгүүлчдийн энэ эрхийг түдгэлзүүлэх заалтыг дотоод журамдаа оруулж эхэлсэн байна.

СОНГУУЛИЙН ҮЕЭР СЭТГҮҮЛЧДИЙН ОЛОН НИЙТИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сонгуулийн санал хураалтад идэвхтэй оролцохыг уриалахаас эхлээд сонгуулийн үйл явц шударга явагдаж буй эсэх, улс төрийн нам болон нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, мөн чанар, амлалтын биелэлт зэрэгт хяналт тавих, үнэн бодит мэдээллийг тэнцвэртэйгээр хүргэх зэрэг үүрэг хүлээдэг. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн олонх нь хувийн хэвшлийн, ашгийн төлөө байгууллага боловч яагаад олон нийтийн улс төрийн сонголтын өмнө буюу сонгуулийн үеэр онцгой үүрэг хүлээж буйг тайлбарлая. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээллийн нийгмийн хамгийн үнэт зүйл болох мэдээллийг түгээгдэгийн хувьд нийгмийн өмнө онцгой хариуцлага хүлээдэг. Тухайлбал, сонгуулийн үеэр намуудын мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулсан, эрх баригч намын хийсэн ажлыг тоймлосон нэг талыг бариагүй нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх нь редакцуудын үүрэг бөгөөд үүгээр дамжуулан сонгогчдыг зөв сонголт хийхэд тусалдаг. Мөн нэр дэвшигчид, улс төрийн нам, эвслүүд сонгуулийн санхүүжилтээ бүрдүүлэхдээ хууль зөрчсөн эсэхэд хяналт тавих нь редакцуудын “бичигдээгүй” үүрэг болжээ. Сэтгүүлчид зөвхөн үйл явдлыг мэдээлээд, нэр дэвшигчид, намуудын хууль бус үйл ажиллагааны талаар бичихгүй өнгөрөх нь ямар нэг хууль зөрчихгүй ч олон нийт, сонгогчдын өмнө хүлээсэн үүргээ хангалттай биелүүлээгүй гэж үзэж болно.

2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр NTV телевиз нэр дэвшигчдийн өнгөрсөн хугацаанд юухийж, бүтээсэн талаар тоймлон, задлан шинжилсэн “Нэр, мөр” цуврал нэвтрүүлэг бэлтгэн хүргэсэн нь олон нийтийн талархлыг хүлээсэн юм.

<https://www.youtube.com/watch?v=G-1Riv-Eg4I>

РЕДАКЦЫН ХҮРЭЭНД:

Хүн хүчний нөөцөө сайн тооцоолох (Сонгуулийн сурталчилгааг нийтэлж нэвтрүүлэхэд хангалттай тооны сэтгүүлч, найруулагч, зураглаач, бусад мэргэжилтэн байгаа эсэх, тэдний ачааллыг жигд хуваарилах, хүн хүч нэмэх, гэрээт ажилтан авах, шинжээч түр хугацаагаар ажиллуулах г.м).

Санхүүгийн боломжоо тооцоолох (Сонгууль сурвалжлахад гарах зардлын тооцоо. Энэ нь нарийн төлөвлөгдсөн байх ёстой бөгөөд сонгуулийн сурталчилгаанд зориулж аль нам эвслээс хэдэн төгрөг авснаа ил тод мэдээлэх, түүнийг хуваарилах г.м).

Сэтгүүлчид, ажилтнуудаа сонгуулийг мэдээлж, сурвалжлах талаарх сургалтад хамруулах (Сонгууль мэдээлэхтэй холбоотой хуулийн заалтуудыг эргэн сануулах, сургалтад хамруулах, удирдамж, гарын авлага, бусад материалаар хангах г.м).

Мэдээллийн хэрэгслүүд тухайн сонгуулийн онцлогоос хамаарч сонгуулийн үеэр хамтран ажиллах нийтлэг дүрэм, журам боловсруулж, мөрдөх (Жишээ нь, орон нутгийн сонгуулийн үеэр аймгуудыг хувааж авч, мэдээлэл хүргэх гэх мэт).

СОНГУУЛИЙН ҮЕЭР СЭТГҮҮЛЧ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН АЖИЛТНУУД ДАРААХ ЗАРЧМЫГ БАРИМТАЛБАЛ ЗОХИНО. ҮҮНД:

- Ёс зүйтэй, хүнлэг, энэрэнгүй байх;
- Мэдээ, сурвалжилга бэлтгэхдээ өөрийн үзэл бодол буюу шүүмжлэлээс зайлсхийх;
- Аль нэг нам, нэр дэвшигчийн талаар мэдээлэхгүй байх амлалтаас зайлсхийх;
- Сэтгэл хөдлөлдөө автахгүй байх (тухайн нэр дэвшигч нь таны дэмждэг, аль эсвэл ойр дотны хүний аль нь ч байсан сэтгэл хөдлөлөө илэрхийлэхгүй байх);
- Та хэний төлөө, аль намын төлөө саналаа өгсөн (өгөх) вэ? гэдэг асуултаас зайлсхийх. (Энэ бол хувь хүний нууцтай байх эрх тул ийм асуулт тависнаар хүний эрхийг зөрчиж байна гэдгээ ойлгох);
- Нэр дэвшигчийн гэрэл зураг болон видео бичлэгүүдийг баримтжуулан цуглуулах, нягталсны үндсэн дээр мэдээлэл түгээх.

5. СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ ТӨЛӨВЛӨХ НЬ

(Хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, редакцуудад зориулав)

Сонгуулийн аян бол нэр дэвшигч, нам эвслүүд олон нийтэд мөрийн хөтөлбөр, бодлого, зорилгоо танилцуулах, олны итгэлийг олох, нөгөө талд иргэд дөрвөн жилийн хугацаанд өөрийг нь төрд хэн төлөөлөхийг шийдвэрлэдэг чухал үйл явц юм. Нийгэм төгөлдөршиж, улс орон хөгжиж, иргэд сайн сайхан амьдрах эсэхэд онцгой нөлөө үзүүлдэг энэ үйл явдалд хэвлэл мэдээллийн байгууллагууд ач холбогдол өгч, нягт нямбай ажиллах нь зүйтэй. Үүний тулд **хэвлэл мэдээллийн байгууллагууд сонгуулийг мэдээлж сурвалжлах тодорхой зорилго, төлөвлөгөө гаргах** нь чухал. Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 8.1-д Сонгуулийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал товлон зарлана¹⁰ хэмээн заасан. Дээрх хугацаанд хэвлэл мэдээллийн байгууллагууд тодорхой зарчим, зорилгын хүрээнд сонгуулийг мэдээлж сурвалжлах төлөвлөгөө боловсруулсан байх.

Юун түрүүнд сонгуулийг мэдээлж, сурвалжлах төлөвлөгөөг сурталчилгаа эхлэхээс өмнө боловсруулах шаардлагатай. Үйл явдалд хариу үйлдэл үзүүлэхээс илүүтэй урьдчилан төлөвлөж, мэдээлж сурвалжлах асуудлаа тодорхойлох нь зүйтэй. Ингэснээр сонгуулийн мэдээллийг бодитой, тэнцвэртэй, түргэн шуурхай хүргэх боломж бүрдэнэ. Эс тэгвээс нам эвсэл, нэр дэвшигчийн зохион байгуулж буй томоохон арга хэмжээ таны анхаарлыг татаж, мэдээний сэдэв болно.¹¹

Сонгуулийг мэдээлэх төлөвлөгөө гаргаагүй үед сэтгүүлчид сонгуулийн үед болж буй дуулиан шуугиантай үйл явдалд хэт их анхаарал төвлөрүүлж, үндсэн үүрэг, зарчмаа умартах тохиолдол цөөнгүй гардаг.¹²

Төлөвлөгөө гаргахаас өмнө Монгол Улсын Сонгуулийн тухай хууль тогтоомж болон холбогдох дүрэм журмыг судлах шаардлагатай. Мөн редакц, ажилтнуудаа нийтээр нь хамруулсан мэргэжлийн ёс зүй, сонгуультай холбоотой хууль эрх зүй, дүрэм журмын талаар сургалт зохион байгуулж, мэргэжлийн байгууллага, мэргэшсэн судлаачдын заавар, зөвлөмжийг сонсох нь зүйтэй. Сонгуулийн тухай хуулиуд, дүрэм журмын нэмэлт өөрчлөлтийн талаар хэвлэл мэдээллийн ажилтнууд цаг алдалгүй олж мэдэх зайлшгүй шаардлагатай.

Төлөвлөгөө гаргахдаа шударга, тэнцвэртэй байж, бүх нэр дэвшигчдэд адил тэгш хандана гэдгээ “чанга дуугарч, шуугиан тарьсан” улс төрчдөд ойлгуулах хэрэгтэй юм.¹³ Жишээлбэл, Монгол ТВ “Оргил цаг” мэдээний хөтөлбөрийнхөө эхэнд төлбөртэй мэдээ болон хаалтын гэрээ хийдэггүй болохыг албан ёсоор мэдэгддэг. Энэ нь үзэл бодол, дүгнэлтээс ангид байх учиртай мэдээний хөтөлбөрөө сэтгүүл зүйн үндсэн зарчмын хүрээнд хамгаалж, дархлаа тогтоож буй нэг хэлбэр юм.

¹⁰ Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, 2015 он

¹¹ Олон Улсын Хэвлэл мэдээллийн дэмжлэг, Хэвлэл мэдээлэл ба ардчилал групп, Эрх чөлөөний сүлжээ (2006), Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийг дэмжих нь (Coaching Manual for Media Support during Elections). Дадлагажуулагчдад зориулсан гарын авлага, Орч. Глоб Интернэшнл төв, https://www.gic.mn/public/docs/publications/coaching_manual_2020_FINAL.pdf

¹² Мөн тэнд

¹³ Мөн тэнд

Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ)-ын үндсэн институт болох Ардчилсан институт, хүний эрхийн газар (АИХЭГ)-аас Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийг ажиглахаар томилогдсон хязгаарлагдмал хороо нь тайлан гаргасан. Уг тайланд Монгол TV телевиз төлбөртэй сонгуулийн сурталчилгаа явуулахаас татгалзан, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрүүдэд өдөр тутам харьцуулсан дүн шинжилгээ хийсэн нэвтрүүлэг бэлтгэж, нэр дэвшигчдийн талаар тэнцвэртэй мэдээлэл цацсан тухай, мөн хоёр дахь шатны санал хураалтын өмнө хоёр нэр дэвшигчдэд нэвтрүүлгийн цагаа адил тэнцүү хуваарилж өгсөн талаар дурджээ.¹⁴

Түүнчлэн, “чанга дуугарсан” улс төрчийн үгийг дамжуулж мэдээлэхдээ бусад нэр дэвшигчийн санаа бодлыг оруулах нь зүйтэй. Нэр дэвшигчид хэвлэл мэдээллийн анхаарлыг татахдаа, тэнцвэртэй мэдээлэл гаргуулахыг хүсдэггүй.¹⁵ Тэнцвэртэй мэдээлэл нь хараат бус мэдээ, сурвалжилга бэлтгэх төлөвлөлтөд маш тодорхой тусгагдсан байх зарчим юм.

Сонгогчдын дуу хоолойг илэрхийлэх үзэл баримтлалыг сана. Сонгогчдын ярьж буй, санааг нь зовоож буй асуудлыг тусгах нь нэр дэвшигчдийн ганхаарал хандуулж, тэднийг энэ талаар ярихад хүргэнэ. Мөн сонгогчдоос нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт ямар үнэлэлт, дүгнэлт өгч буй хийгээд бодит амьдралтай хэр ойр тусч байгааг тодруулах хэрэгтэй. Сэтгүүлч, сонгогчдын нэрийн өмнөөс тухайн нам, эвсэл, нэр дэвшигч амлалтаа хэрхэн, ямар арга замаар хэрэгжүүлэх талаар тодорхой асуулт тавих, үүнийг төлөвлөгөөндөө тусгахаа бүү мартаарай. Тухайн нам өмнө нь эсэргүүцэж байсан асуудлаа одоо яагаад дэмжих болов гэдгийг асуух ёстой. Яагаад, юуг, хэрхэн яаж гэж эхлэх нээлттэй асуулт тавихаа төлөвлөгөөндөө тусгахаа мартуузай. Эдгээр асуулт улс төрчдийг бүрэн дүүрэн хариулт өгөхөд хүргэдэг. Энэ үед ч бас мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалах зарчмаа умартаж болохгүй.¹⁶

Сонгуулийн үед үндсэн гурван төрлийн мэдээлэл иргэдэд хүрдэг бөгөөд үүнд сэтгүүл зүйн хараат бус мэдээлэл, сурталчилгаа, зар сурталчилгаа хамаарна. Сонгуулийн үед редакцын бүтээлийг нөлөөллийн бүтээлээс хэрхэн яаж ойлгомжтойгоор ялган тэмдэглэх, мөн эдгээрийн эфирийн цагт эзлэх хувийг ч нарийн сайн тооцоолох ёстой.

14 ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар (2017), Монгол Улс. Ерөнхийлөгчийн сонгууль. 2017 оны 6-р сарын 26-н болон 7-р сарын 7-ны өдрүүд. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлан, Варшав, <https://www.osce.org/files/f/documents/1/3/366136.pdf>

15 Олон Улсын Хэвлэл мэдээллийн дэмжлэг, Хэвлэл мэдээлэл ба ардчилал групп, Эрх чөлөөний сүлжээ (2006), Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийг дэмжих нь (Coaching Manual for Media Support during Elections). Дадлагажуулагчдад зориулсан гарын авлага, https://www.gic.mn/public/docs/publications/coaching_manual_2020_FINAL.pdf

16 Мөн тэнд

АНХААРВАЛ ЗОХИХ АСУУЛТ

Танай хамрах хүрээ хязгаарлагдмал уу? (үндэсний, бүсийн, орон нутгийн хэмжээний аль нь болох)

Сонгуулийн мэдээлэл төлөвлөхдөө өөрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамрах хүрээг зайлшгүй бодолцох хэрэгтэй. Энэ нь ээлжит сонгууль, ээлжит бус сонгууль хийгээд орон нутгийн сонгууль, Улсын Их Хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгуулийн аль нь гэдгээс хамаарах бөгөөд төлөвлөгөөний агуулгаа өөр өөрөөр гаргах шаардлагатай болно.

Зарим тодорхой үйл явдлын үеэр бусад радио, телевиз, сонинтой хамтрах нь зүйтэй юу?

Сонгууль сурвалжлах төлөвлөгөө бэлтгэхдээ болгоомжтой хандаарай. Жишээлбэл танай хүн хүч, хөрөнгө санхүү хязгаарлагдмал бол цөөн асуудал сонгон авах нь зүйтэй. Энэ нь юм бүхнийг хамруулж, дутуу дулимаг хийхээс хавьгүй дээр. Сонгуулийн үеэр танай байгууллагын нөөц зөвхөн сонгуулийн тухай мэдээ мэдээлэлд зориулагдахгүй гэдгийг мартаж болохгүй. Ялангуяа, орон нутаг дахь хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, ажиллах хүч хязгаарлагдмал газрууд хүн хүч, техник технологийн нөөц боломжоо тооцоолж үзсэний дараа төлөвлөгөөгөө гаргах хэрэгтэй. Өргөн нэвтрүүлгийн хэд хэдэн станц нь улс төрийн мэтгэлцээн, олон нийтийн уулзалтуудыг дамжуулахдаа камер, микрофон, дуу, дүрсний нэг багц ашиглан хамтран ажиллавал хямд төсөр тусаж болно. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн хүн хүч, техник, материаллаг баазын боломжид тулгуурлан энэ асуудал дээр оновчтой шийдвэр гаргаснаар сонгуулийн мэдээллийн төлөвлөгөөнд тусгасан бусад асуудлыг орхигдуулалгүй нийтэлж, мэдээлэх боломжтой. Сонгуулийн үеэр төлөвлөгөөнд тусгагдаагүй, гэнэтийн олон онцлох үйл явдал өрнөдгийг мартаж болохгүй. Бусад станц, сонинтой хамтрах нь хөрөнгө мөнгө хэмнэхээс гадна хараат бус байдлаа хадгалах боломж олгоно. Мөн санал хураалтын тооллогын үр дүнг мэдээлж, сурвалжлахдаа бусад ХМХ-тэй хамтран ажиллах боломжтой. Ийм туршлага олон оронд нийтлэг байдаг. Энэ нь сонсогч, үзэгч, уншигч бүр ижил мэдээлэл авахад тустай. Ийн ажиллахад, радио, телевиз, сонин, онлайн ХМХ бүр сонгуулийн үр дүнг өөрийнхөөрөө мэдээлж, тайлбарлахад редакцын хараат бус байдлаа хэвээр хадгална.¹⁷ Гэхдээ, хамтрах хэвлэл мэдээллийн хэрэгслийнхээ редакцын бодлого, ашиг сонирхол, хараат бус байдал зэргийг маш сайн судалсны үндсэн дээр ийм шийдвэр гаргах нь зүйтэй юм.

Сонгуулийг мэдээлж, сурвалжлах төлөвлөгөөгүй бол та олон нийтэд чанартай, бодит, тэнцвэртэй мэдээлэл хүргэхэд анхаарахаас илүүтэйгээр гагцхүү тухайн үйл явдалд хөтлөгдөх өрөөсгөл талтай. Сонгуулийн мэдээ сурвалжилгыг төлөвлөгөөтэй, эс төлөвлөгөөтэй хүргэхэд агуулгын хувьд ямар ялгаатайг дараах зургаас харна уу.

¹⁷ Олон Улсын Хэвлэл мэдээллийн дэмжлэг, Хэвлэл мэдээлэл ба ардчилал групп, Эрх чөлөөний сүлжээ (2006), Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийг дэмжих нь (Coaching Manual for Media Support during Elections). Дадлагуулагчдад зориулсан гарын авлага, https://www.gic.mn/public/docs/publications/coaching_manual_2020_FINAL.pdf

ЗУРАГ 1. СОНГУУЛИЙН МЭДЭЭ СУРВАЛЖИЛГА



Эх сурвалж: International Media Support, Media & Democracy Group ба Réseau Liberté


СОНГУУЛИЙГ МЭДЭЭЛЖ, СУРВАЛЖЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАХ НЬ:

Сонгуулийг мэдээлж, сурвалжлах төлөвлөгөөг цаг хугацааны хувьд үндсэн гурван хэсэгт хувааж болно. Үүнд:

1. Сонгуулийн өмнө.
2. Сонгуулийн сурталчилгааны үед болон санал авах өдөр.
3. Сонгуулийн дараа.

Сонгуулийн талаар мэдээлж, сурвалжлах төлөвлөгөө хийх талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтсон загвар байхгүй. Гэхдээ, үүнийг бэлтгэх нь сонгуулийг чанартай мэдээлж, сурвалжлахад чухал үүрэгтэй учраас доорх жишээг үлгэр болгон сэдэв агуулгаа төлөвлөх боломжтой. Тухайн сонгуулийн онцлог, редакцын бодлого, байгууллагын хүн хүч, хамрах хүрээнээс хамаараад байгууллагынхаа онцлогт тохирсон загвар боловсруулж болно.

ЗУРАГ 2. СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН СЭДЭВ, АГУУЛГА ТӨЛӨВЛӨХ ЖИШЭЭ



Сонгуулийн сурталчилгааны үеэр хэн аль намд харъяалагдаж байсан, нам эвсэл тус бүр хэдэн нэр дэвшигчтэй байсан зэрэг тоо баримт цуглуулах нь чухал. Түүнчлэн нэр дэвшигч, сонгуулийн тойрог, өрсөлдөгч бүрийн тухай суурь мэдээлэл цуглуулна. Энэ баримтжуулалтыг судалгаа, хэвлэлийн мэдээ, сонин, интернэт дэх мэдээллээр байнга баяжуулж, сурталчилгааны гурван үе шат бүхэнд ашиглана.¹⁸

Олон нийтийг мэдээлэлтэйгээр саналаа өгөхөд туслахын тулд нам, эвсэл бүрийн талаар үнэн шударга, тэнцвэртэйгээр мэдээлбэл зохино. Энэ нь нам, эвсэл бүрийг адил тэнцүү мэдээлж, сурвалжилна гэсэн үг.

18 Олон Улсын Хэвлэл мэдээллийн дэмжлэг, Хэвлэл мэдээлэл ба ардчилал групп, Эрх чөлөөний сүлжээ (2006), Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийг дэмжих нь (Coaching Manual for Media Support during Elections). Дадлагуулагчдад зориулсан гарын авлага, https://www.gic.mn/public/docs/publications/coaching_manual_2020_FINAL.pdf

Олон нийтийн санал асуулга бол тухайн үедээ улс төрчийн нэр хүнд хэр байгааг хэмжих нэг арга юм. Хэрэв тухайн санал асуулгад тулгуурлах боломжгүй бол долоо хоногт нэг удаа хамт ажиллагсдаасаа өөрсдийн нэр хүндтэй гэж үзэж буй 5-аас 10 нэр дэвшигчийг тус бүр жагсааж бичих хүсэлт тавьж болно.¹⁹ Жагсаал бүрт нэгээс гурван нэр дэвшигч давтагдах магадлал өндөр байдаг. Энэ нь тухайн долоо хоногт аль нэр дэвшигчид анхаарал хандуулах талаар санаа өгөх болно. Сонгуулийн сурталчилгаа эрчимжихийн хэрээр зарим нэр дэвшигчийн хувийн чанар, санаа бодол нь таны анхаарлыг бусад нэр дэвшигчдээс илүү татаж болно. Иймээс дээрх жагсаалт өөрчлөгдөх боломжтой. Рейтинг нь тааруу байгаа нэр дэвшигчдийн талаар мөн мэдээлж, сурвалжлах, тэдний хөндөж буй асуудлыг рейтинг өндөртэй нэр дэвшигчийнхтэй харьцуулах нь мөн чухал. Таны жагсаалтад доогуур байгаа нам, эвсэл, нэр дэвшигч олны нүдэн дээр нэр хүнд нь өсч байгаа бол та уян хатан байж, зохих түвшинд мэдээлэх ёстой.²⁰

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

19 Мөн тэнд
20 Мөн тэнд

ЗӨВЛӨМЖ

- 1. Чөлөөт сэтгэлгээгээр эхэл.** Баримт цуглуул. Үүнд, сонгуулийн хууль, сонгуульд оролцогч бүх нам, эвсэл, нэр дэвшигчдийн нэр, холбоо барих утас багтаж болох бөгөөд тэдгээрийг мэдээлэх нь зүйтэй.²¹ 2020 онд болсон УИХ-ын сонгуулийн үеэр ikon.mn, gogo.mn сайт цэсэндээ “СОНГУУЛЬ 2020” булан нээж нэр дэвшигчдийн танилцуулга, нэр дэвшиж буй тойрог, мандатын тоо, өмнө нь УИХ-д хэдэн удаа нэр дэвшсэн тоо, цахим хуудас, нийгмийн сүлжээний мэдээллийг оруулснаас гадна нам эвслүүдийн мөрийн хөтөлбөрийг дэлгэрэнгүй, ойлгомжтой байршуулсан нь сонгогчдод мэдээлэлтэй сонголт хийх, ажлын туршлага, мөрийн хөтөлбөрийг нь харьцуулан дүгнэхэд чухал ач холбогдолтой байв.

Мөн олон нийтийн санал асуулгын судалгаа хийдэг байгууллагууд, сонин хэвлэлийн мэдээ нийтлэл, онлайн судалгаа, зарцуулахаар зөвшөөрөгдсөн санхүүжилтийн хэмжээний тухай мэдээлэл орно. Нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын тухай мэдээллийг АТГ-ын <http://xacxom.iaac.mn> сайтын Сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлэг (Сонгуульд нэр дэвшигчдийн ХОМ) цэснээс авч, нийтлэх боломжтой.

- 2. Бүх нам эвслийн сонгуулийн аяны хуваарийг нь олж мэд.** Нам эвслүүд зохион байгуулах арга хэмжээгээ урьдчилан төлөвлөдөг. Сонгуулийн штаб, санал хураах байруудын байршлын талаар мэдээлэл цуглуул. Санал авахаас арав хоногийн өмнө тухайн хэсэг дэх санал авах байрны дугаар, нэр хаяг, орчин тойрны дэвсгэр зураг /план/-ыг нийтэд зарлан мэдээлэх үүрэгтэй бөгөөд санал авах байршлыг тухайн засаг захиргааны нэгжийн ИТХ шийдэж тогтоол гаргадаг. Мөн дээрх мэдээллийг Сонгуулийн Ерөнхий Хорооны www.gec.gov.mn сайтаас харах боломжтой.
- 3. Холбогдох мэргэжилтнүүд, улс төрийн тоймч, улс төр судлаач, шинжээчдийн жагсаалт гарга.** Эдгээр хүмүүс нь сонгуулийн үеэр болон дараа нь мэдээ, сурвалжилга хийхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулж болно.
- 4. Ажлын байраа бэлтгэ.** Сонгуулийн үеэр цуглуулсан бүх баримт, мэдээ материалаа цуглуулж, санал солилцох, уулзалт хийх буланг мэдээний өрөөндөө байрлуулаарай.²²
- 5. Ёс зүйн зарчмаа чанд мөрд.**
 - Мэдээ мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж, санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийх.²³

21 Мөн тэнд

22 Мөн тэнд

23 Хэвлэл мэдээллийн зөвлөл, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, <http://www.mediacouncil.mn/p/7>

- Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягтлаж, тодорхой дурдахыг эрмэлзэх.²⁴ (Сонгуулийн үеэр, ялангуяа, өрсөлдөөн ширүүсч, санал хураалтын өдөр ойртох тусам нууц эх сурвалжаас баримт, мэдээлэл ирэх тохиолдол цөөнгүй. Үүнд онцгой анхаарч, болгоомжтой хандаж, сайтар нягтлах хэрэгтэй).
- Фото, видео, аудио мэдээллийн агуулгыг техникийн арга хэрэгслээр гуйвуулахгүй байх²⁵ (Сонгуулийн үеэр бүтээлийн дүрс, дуу, эшлэл зэргийн агуулгыг техникийн аргаар өөрчилж, өрсөлдөгч талын нэр хүндийг унагах гэсэн зохион байгуулалттай үйл ажиллагаа байж болзошгүйг санах).
- Нөлөөллийн болон мэдээллийн бүтээлийг ялгах²⁶ (Зар сурталчилгаа, зар, хэвлэлийн мэдээ, сэтгүүл зүйн хараат бус мэдээллийн аль нь болохыг маш тодорхой ялгаж тэмдэглэх, дурдах, далд сурталчилгаанаас зайлсхийх).

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

24 Мөн тэнд

25 Мөн тэнд

26 Мөн тэнд

СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ОНЦЛОГ

Сонгуулийн тухай хуулийн 4.1-д сонгуулийн үндсэн зарчим нь сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох зарчмын үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгох эрхийг хангахад үндэслэн²⁷ хэмээн заасан байдаг.

Сонгогчдыг сонгуулийн дээрх үндсэн зарчмыг нэр төдий биелүүлэх биш, үр дүнтэй, хариуцлагатай, оновчтой сонголт хийхэд СЕХ-ноос гадна **сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн хэрэгсэл чухал үүрэгтэй.**

Иргэдийн сонгуулийн талаарх үзэл санаа, ойлголт хэвлэл мэдээллийн хэрэгслээс ихээхэн хамаардаг. Улс орон хөгжихөд иргэдийн зөв сонголт туйлын чухал юм. Зөв сонголтыг сонгуулийн талаар зөв мэдлэг, мэдээлэлтэй, аливаа асуудалд бодит дүн шинжилгээ хийдэг, өөрөөр хэлбэл, боловсролтой, мэдээлэлтэй сонгогч хийнэ. Сонгуулийн онцлог, систем, хууль журам, ач холбогдол, санал хураах болон бусад үйл явц, нэр дэвшигч, нам эвслийн мөрийн хөтөлбөрийн асуудлаар сонгогч иргэдэд мэдлэг олгоход чиглэсэн үйл ажиллагааг бүхэлд нь сонгогчийн боловсрол гэдэг.

Сонгогчдод мэдээлэлтэй, хариуцлагатай, идэвхтэй сонголт хийдэг чадавхийг бий болгоход хэвлэл мэдээллийн үүрэг, нөлөөлөл чухал учир үүнийг Сонгуулийн тухай хуулиар зохицуулдаг. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 46.15, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 45.15-д “Радио, телевиз сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй”²⁸ хэмээн заасан.

Мэдээлэл эрж хайх, боловсруулан түгээх, иргэдийг үнэн бодит мэдээллээр хангах нь сэтгүүлч, ХМХ-ийн үүрэг мөн. Нөгөө талаас, иргэд нам эвсэл, нэр дэвшигчдийн талаар үнэн, зөв мэдээлэлтэй сонголт хийж, хөндлөнгийн зорилтот нөлөөллөөс ангид сонгуульд оролцсоноор төрийн тогтолцооны бүхий л түвшний бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц сайжирч, түүнд нөлөөлөх боломжтой болно.

Иргэдийг шат шатны сонгуульд ач холбогдол өгч, сонголтоо зөв хийхэд нөлөөлөх нэгэн чухал хүчин зүйл бол үнэн бодит мэдээлэл юм. Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэл бэлтгэхдээ хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид дараах асуудалд зайлшгүй анхаарах шаардлагатай. Мэдлэгтэй, мэдээлэлтэй, туршлагатай, хариуцлагатай, бие даасан, идэвхтэй, судлаач сонгогчдыг төлөвшүүлэхэд хэвлэл мэдээлэл чухал үүрэгтэй.

27 Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, 2015 он

28 Аймаг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, 2020 он

ЗУРАГ 3. СОНГОГЧДЫН БОЛОВСРОЛД ЗОРИУЛСАН СЭТГҮҮЛ ЗҮЙН БҮТЭЭЛИЙН АГУУЛГА, ҮР ДҮН



- 1. ИДЭВХТЭЙ СОНГОГЧ.** Санал өгөх нь сонгуулийн зөвхөн нэг хэсэг бөгөөд дараагийн сонгууль хүртэл 4 жилийн хугацаанд сонгогдсон нам эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, нэхэн сануулах, шийдвэр гаргах үйл явцад идэвхтэй оролцох талаар мэдээлэлтэй болгох.
- 2. ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ.** Сонгуулийн үеэр хууль бусаар эд, мөнгө тараах, сонгуулийн хууль зөрчсөн аливаа үйлдлийн талаар мэдсэн бол хуулийн байгууллагад баримттайгаар цаг тухайд мэдэгдэх нь иргэний үүргээс гадна сонгууль хуулийн дагуу, шударга явагдаж буй эсэхэд хяналт тавьж буй нь боловсролтой, хариуцлагатай сонгогчийн нэг хэлбэр гэдгийг бүтээлийн агуулгад тусгах.
- 3. ТУРШЛАГАТАЙ СОНГОГЧ.** Тухайн жилийн сонгуульд оролцогч сонгогчдын боловсролын түвшин, сонгуульд оролцож байсан туршлага харилцан адилгүй гэдгийг санаж, сонгогчийн боловсролд зориулсан мэдээ мэдээллийн агуулга, хэлбэр хийцийг боловсруулах.
- 4. МЭДЭЭЛЭЛТЭЙ СОНГОГЧ.** Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх, санал өгөх байршил, санал өгөх зааврын тухай мэдээлэл өгөх.
- 5. БИЕ ДААСАН СОНГОГЧ.** Гадаад үзэмж, нутаг усны үзэл, эд материал, гэр бүл, ойр тойрны хүрээллийн хүмүүсийн ятгалга зэрэгт авталгүйгээр засгийн эрх,

төрийг удирдахад оролцож, өөрийнхөө ирээдүйг өөрөө шийдэж буй хийгээд сонгуулийн хууль тогтоомж, үйл явц, сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэлтэй болсноор хариуцлагатай зөв сонголт хийх тухай ойлголт өгөх.

- 6. МЭДЛЭГТЭЙ СОНГОГЧ.** Сонгуулийн төрөл, хэлбэр, тогтолцоо хийгээд орон нутгийн сонгууль, Улсын Их Хурлын сонгууль, Ерөнхийлөгчийн сонгууль хоорондын ялгаа буюу эрх мэдэл, чиг үүргийн тухай тодорхой ойлголт өгөх.
- 7. СУДЛААЧ СОНГОГЧ.** Мөрийн хөтөлбөр бол сонгогчдын сонголт хийхдээ анхаарах гол хүчин юм. Үүнд олон нийтийг төлөөлөн дараагийн дөрвөн жилд эрх барих нам, эвслийн хийж хэрэгжүүлэх ажил тодорхой тусгагддаг. Иймд мөрийн хөтөлбөртэй цаг гарган танилцаж, нийгэмд тулгамдсан асуудал, анхаарлыг нь татаж буй сэдвийн талаар ямар байр суурьтай байгаа, хэрхэн шийдвэрлэхээр төлөвлөж буйг харах нь хариуцлагатай сонголт хийх үндэс болох тухай мэдээлэл бэлтгэх. Тухайн нэр дэвшигч, нам, эвсэл сонгогдсон тохиолдолд мөрийн хөтөлбөр нь төр, засгийн бодлого шийдвэр болон хэрэгжиж, иргэдийн өдөр тутмын амьдралд тусгал болно гэдгийг сануулах, популист амлалт улс орон, нийгэм, эдийн засагт ямар сөрөг нөлөөтэй тухай ойлголт өгөх.
- 8. ЭРХ ТЭГШ СОНГОГЧ.** Сонгогчдын боловсролд зориулсан нэвтрүүлэг, мэдээ, мэдээлэл бэлтгэхдээ хүртээмжтэй байх үүднээс хадмал тайлбар, эсхүл дохионы хэлний орчуулгатай гаргах.

Сонгогчдын боловсрол нь ХМХ-үүд сонгуулийн үеэр л хөндөөд орхих асуудал биш бөгөөд улс орноо хөгжүүлж, та бидний амьдрал дээшлэхэд боловсролтой сонгогчид хамгийн чухал үүрэгтэй гэдгийг санаж, бусад үед ч нөлөөллийн үйл ажиллагаа явуулах нь чухал юм. Сонгогчдын боловсролыг дээшлүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа жил ирэх тусам идэвхжиж, сонгогчдын идэвх мөн сайжирч байна. Сонгогчдын боловсролын асуудлыг зөвхөн 18 нас хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэнээр хязгаарлаж болохгүй. Сонгуульд оролцох нас нь дөхөж буй хүүхдүүдэд ч мөн сонгууль, түүний ач холбогдол, мөн чанар, мэдлэг мэдээлэлтэйгээр сонгуульд оролцохын ач тусын тухай мэдээ мэдээллийг тогтмол өгч байх нь сонгогчдын боловсролыг дээшлүүлэх алс хэтийг харсан алхам мөн.

СОНГУУЛИЙН ХАЛЗ МЭТГЭЛЦЭЭН

Сонгогчдын боловсролд зориулсан сэтгүүл зүйн бүтээлийн нэг болох, үр дүнтэй, сонгуулийн үед хэрэгжүүлдэг, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн томоохон арга, хэлбэр бол халз мэтгэлцээн юм. Сонгуулийн халз мэтгэлцээн бол телевизийн бусад нэвтрүүлгээс өвөрмөц ялгаатай бөгөөд энэ нь нэр дэвшигчдэд улс төрийн байр суурь, улс орны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого, арга замын тухай санаа бодлоо илэрхийлэх, сонгогчдын анхаарлыг татах, нөгөө талаар сонгогчдод

санал хураалтад мэдээлэлтэй, мэдлэгтэй оролцож, өөрийнхөө төлөөллийг сонгох явцад зөв шийдвэр гаргахад тусалдаг.²⁹

Мэтгэлцээн нь ардчилалд олон талаараа ашиг тусаа өгдөг, тэр дундаа сонгогчдод зөв шийдвэр гаргах, сонголтоо мэдээлэлтэй хийхэд тусалдаг. Улс төр, нийгэм соёл, хөгжлийн хувьд өөр өөр дэлхийн 60 гаруй орон улс төрийн мэтгэлцээн зохион байгуулж, хөгжүүлж иржээ. Нэр дэвшигчдийн хувийн шинж чанар, шашин шүтлэг, үндэс угсааг бус, олон нийтийн бодлогын асуудалд анхаарлаа хандуулж буй байдал, иргэний харилцааг сурталчлах замаар хүчирхийллийг бууруулах, сонгогдсон албан тушаалтнуудыг сонгуулийн сурталчилгааныхаа амлалтыг хэрхэн биелүүлснийг нэхэх гэх мэт өргөн хүрээг хамран мэтгэлцээнийг зохион байгуулдаг. Нэг улс төрийн хүчин нь хэвлэл мэдээллийн орчинд давамгайлж байгаа улс орнуудад мэтгэлцээн нь бүх нэр дэвшигчдэд мөрийн хөтөлбөрөө хүргэх, өөрийгөө таниулах боломж олгодог.

Сонгуулийн мэтгэлцээн телевизийн хамгийн үзэгч ихтэй, сонирхолтой хөтөлбөр. Тиймээс мэтгэлцээн зохион байгуулах, хөтөлөхөд сэтгүүл зүйн мэргэжлийн хэм хэмжээг зайлшгүй баримтлах ёстой юм. Сэтгүүл зүйд аль нэг талыг баримтлалгүй, ялгаварлан гадуурхахгүйгээр мэдээллээ хүргэх нь үзэгч, сонсогч, уншигчдад итгэл найдварыг бий болгодог бөгөөд тэнцвэртэй байдлыг хангах нь мэтгэлцээнд баримтлах хамгийн чухал зарчим болдог.

Сонгуулийн халз мэтгэлцээний түүх, ач холбогдол, хэм хэмжээ, онцлог болон халз мэтгэлцээний загварыг хэрхэн боловсруулах талаар “Телевизээр сонгуулийн халз мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ?” гарын авлагаас³⁰ танилцаарай.

Сонгогч саналаа өгнө гэдэг нь дөрвөн жилийн хугацаанд төрд иргэдийг хэн төлөөлж, олон нийтийн дуу хоолой, үзэл санааг, ямар нам, эвсэл, хэн хүргэх, цаашлаад оновчтой бодлого боловсруулж, мөрийн хөтөлбөрөө хэн нь бодитой хэрэгжүүлж, улс орныг хөгжүүлэх вэ гэдгийг шийдэж, төр барих эрх мэдлээ шилжүүлэх чухал үйл явц юм. Иргэд сонгуульд идэвхтэй оролцож, саналаа өгөх нь сонгох эрхээ эдлэхийн зэрэгцээ улс орныхоо өмнө хүлээж буй үүргээ биелүүлж буй гэдгийг сонгогч иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан сануулах нь чухал. Сонгогчид зөвхөн санал өгөх эрхээ эдлээд зогсохгүй нэр дэвшигч, нам эвслүүдийн мөрийн хөтөлбөрт бодит дүн шинжилгээ хийдэг, хэрэгжилтийг нь хянадаг, тэдний амлалтыг эргэн санадаг байх нь чухал. Эдгээр асуудлыг ухамсарласан, мэдлэг мэдээлэлтэй иргэдийг сэтгүүл зүй, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан төлөвшүүлэх боломжтой.

29 Глоб Интернэшнл төв (2019), Телевизээр сонгуулийн халз мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ? https://www.gic.mn/public/docs/publications/DEBATE_handbook_final_2020_06_08.pdf

30 Мөн тэнд

Сонгуулийн үе төдийгүй бүхий л цаг үеийн мэдээ мэдээлэлд эх сурвалж бол мэдээллийн хамгийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог. Мэдээллийн эх сурвалжийг оновчтой сонгож, түүнээс шаардлагатай мэдээлэл олж авах нь сонгуулийн үеийн шуурхай мэдээллийг дамжуулахад нэн чухал.

Мэдээллийн эх сурвалжийг олж авах үндсэн гурван бүлэг байдаг. Үүнд:

- Ажиглалт
- Ярилцлага
- Судалгаа

Сонгуулийн үеэр ажиглалт хэрхэн хийх вэ? Юунд анхаарах ёстой вэ?

Сэтгүүлч үйл явдал өрнөж буй газарт очиж, өөрийн үзсэн харсан, ажигласан, мэдэрснээ уншигчдад дамжуулах замаар мэдээлэлд гэрчийн үүрэг гүйцэтгэх тохиолдол цөөнгүй. Ялангуяа, сонгуулийн үеийн мэдээ мэдээлэлд дээрх үүрэгтэй оролцох явдал олон тохиолддог. Тухайлбал, сонгуулийн хуулийг зөрчиж буй үйл явдал эсвэл тойргийн хороонд болж буй санал өгөх явц, улс төрийн нам эвслийн байрнаас мэдээ мэдээлэл бэлтгэхэд сэтгүүлч өөрөө гэрч болдог. Ажигч гярхай байх чадварын гол үндэс нь үйл явдлыг хөндлөнгөөс болон дотор нь орж харж чаддаг байхад оршдог.³¹

Сонгуулийн үйл явц үр дүнгийн талаар мэдээ мэдээлэл бэлтгэж байгаа нөхцөлд санал өгч буй иргэдийн байр байдал, Сонгуулийн Ерөнхий Хороо, улс төрийн нам эвслүүдийн хийж буй мэдэгдэл, үйл явдалд хандаж буй тэдний байр суурь зэргийг ажиглах шаардлагатай. Тиймээс, сонгуулийн үеийн мэдээ мэдээлэл бэлтгэхэд сэтгүүлчдэд үйл явдлын бүх хэсэгт хурдан шилжиж, мэдээллийг шуурхай цуглуулах чадвар шаарддаг тул ийм төрлийн мэдээлэл бэлтгэхэд багаар ажиллах нь чухал юм.

Сонгуулийн хууль зөрчсөн үйлдлийг (мөнгө тараасан, иргэдийг унаагаар зөөвөрлөсөн, бусдыг гүтгэсэн г.м) мэдээлэхэд тухайн үйл явдал дотор нь орж, шууд ажиглалт хийх зорилгоор сэтгүүлчдэд нарийвчилсан ажиглалт хийх ур чадвар хэрэгтэй.

Сонгуулийн үеийн хууль бус үйлдлийг мэдээлэх нь тухайн хэрэгт голлох үүрэгтэй оролцож буй хүмүүс болон тэдний зорилгыг олж мэдэх, Сонгуулийн болон Эрүүгийн хуулийн ямар зүйл заалтыг зөрчсөн зэргийг харах, болж буй үйл явцад дүн шинжилгээ хийн, мэдээлэл цуглуулах үйл явц юм. Ийм үед сэтгүүлчдэд тухайн үйл явдал болж буй газраас шууд сурвалжилга бэлтгэх шаардлага гардаг. Хууль зөрчсөн онц ноцтой үйл явдал, мэдээлээгүй тохиолдолд олон нийтийн эрх ашигт ноцтой нөлөөлөх асуудлыг мэдээлэхэд сэтгүүлчид зарим үед эрсдэлтэй тулгарах, мэдээлэл цуглуулах шударга бус аргуудыг (баг зүүх, дүрд тоглох г.м.) хэрэглэх зэргээр ёс зүйн дүрмээ зөрчих ч үе гардаг. Хэрэв сэтгүүлч өөрөө үйл явдлын гэрч бол тухайн мэдээ мэдээллийг дамжуулахдаа мэдээллийн эх сурвалж нь өөрөө гэдгийг шууд хэлэх хэрэгтэй. Эс тэгвэл уншигч тухайн мэдээллийг хаанаас авсныг мэдэхгүй үлдэхийн зэрэгцээ эрсдэл хүлээн, олж авсан чухал мэдээллийн үнэ цэн буурах, уншигч, үзэгчид мэдээллийн үнэн бодит байдалд эргэлзэх сөрөг талтай.

31 Амартүвшин.С., Батбаатар.Ж. (2014), Сэтгүүлчийн ур чадвар, Улаанбаатар, х.97.

ЯРИЛЦЛАГА БУЮУ МЭДЭЭЛЛИЙН АМАН ЭХ СУРВАЛЖ БА ТҮҮНТЭЙ АЖИЛЛАХ НЬ

Нийтлэл нэвтрүүлгийн эх сурвалжийн талаар уншигч, сонсогчдод тодорхой мэдээлсэн тохиолдолд түүний итгүүлэн үнэмшүүлэх чадвар ямагт өндөр байдаг. Бодит байдал дээр эх сурвалжийн талаар мэдээлэх нь төвөггүй байдаг.³² Ярилцлага буюу аман эх сурвалжаас авсан мэдээллийг нийтлэл нэвтрүүлэгт эшлэл хэлбэрээр ашиглана.

Бусдын үгийг эшлэл болгон авахдаа эшлэлийн тэмдэг буюу хашилтан дотор бичихгүй байх, ярилцагч эх сурвалжийн хэлээгүйг хэлсэн мэтээр нэмж оруулах, дур мэдэн өөрчлөх нь баримтыг гуйвуулж байгаа хэрэг юм. Иймэрхүү асуудал сонгуулийн үеийн мэдээ мэдээлэлд элбэг ажиглагддаг. Тухайлбал, 2017 оны Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Доналд Трампас бусад нэр дэвшигчдийн хэлсэн үгийг гуйвуулж, ярианы агуулгыг өөрчилсөн тохиолдол хэд хэдэн удаа гарсан. Манай улсад 2020 оны УИХ-ын сонгуулиар нэр бүхий улс төрийн хүчнүүд иргэдийн ярьсан ярианы агуулгыг өөрчилж, эвлүүлэг хийн, телевизээр түгээж байсан баримтууд гарч байсан.

Нэг сэдэв, үйл явдлын тухайд уулзаж ярилцсан хүмүүсийн зарим нь дэмжиж байхад зарим нь эсрэг саналтай байдаг. Ийм эсрэг, тэсрэг эшлэлүүдийг эн тэнцүү хүргэх нь мэдээллийг тэнцвэржүүлнэ. Иймээс сонгуулийн үеийн мэдээ мэдээллийн үнэ цэн, үнэн бодит байдлыг хангахад бүх түвшний эх сурвалжтай уулзаж ярилцах, тэднээс хэрэгтэй мэдээллээ олж авах нэн чухал юм.

Мэдээллийн аман эх сурвалжийг дотор нь гурав ангилдаг. Үүнд:

1. Жирийн хүмүүс /өртөгч/

Мэдээлэлжсэн нийгмийн уншигчид, олон нийт энгийн нэгний тухай энгийн зүйлийг ойшоодоггүй, сонирхдоггүй нь хатуу боловч үнэн учраас сэтгүүл зүй энэ л хуулийг дагадаг.³³ Гэхдээ сонгуулийн үр дүн нь сонгогчдын өдөр тутмын амьдралд чухал нөлөө үзүүлдэг учраас жирийн иргэд чухал эх сурвалж болох тохиолдол элбэг байдаг. Санал өгөх үйл явц, сонгуулийн үр дүн зэргийн талаар энэ түвшний эх сурвалжийн үзэл бодол, байр суурь чухал мэдээлэлд тооцогдож болдог. Манай улсад төдийгүй олон улсад сонгуульд саналаа өгч байгаа энгийн иргэд, тэдний байр суурийг ОНМХ-ээр мэдээлэх тохиолдол цөөнгүй гардаг.

Гэхдээ энгийн иргэдээс яриа авахдаа аль нам, эвсэлд саналаа өгсөн, аль намыг дэмждэг талаар асуулт асуухыг хориглодог. Харин сонгуульд идэвхтэй оролцох уриалгыг дэвшүүлэх, санал өгөхөд ямар байсан талаар ярилцах, эсвэл сонгуулийн хуулийн талаар олон нийтийн үзэл бодлыг нэвтрүүлж болно. Мөн энэ төрлийн эх сурвалжаас мэдээлэл авахдаа сонгуулийн бүх насныхны байр суурийг сонсох нь чухал.

32 Андерсен. Х.У., Мэллит. М.Ф. (1998) Нийтлэл, нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ? Орч.Зулькафил. М. Улаанбаатар, 2008, х.53.

33 Батбаатар.Ж, (2010), Суурь сэтгүүл зүй. Улаанбаатар, х.114.

2. Мэргэжилтнүүд

СЕХ, аймаг, сум, нийслэлийн сонгуулийн хорооны гишүүд, тойргийн хорооны ажилтнууд энэ төрлийн эх сурвалжид багтдаг. Эдгээр эх сурвалжуудын мэдээлэл нь сонгуулийн талаарх хамгийн бодитой, албан ёсны мэдээлэлд тооцогддог. Иймээс энэ төрлийн эх сурвалжаас бусад эх сурвалжийн өгсөн сонгуулийн үр дүн, ирцийн талаарх мэдээллийг ХМХ-ээр дамжуулахдаа заавал өөр эх сурвалжаар баталгаажуулах нь чухал.

Ялангуяа, нийгмийн сүлжээгээр тарсан СЕХ болон эрх бүхий байгууллагаас өмнө түгээсэн мэдээллийг эх сурвалжаар “шууд” ашиглаж болохгүй. Гагцхүү “анхдагч эх сурвалж”-ийн түвшинд авч үзэн, албаны эх сурвалж, эсвэл хоёрдогч эх сурвалжаар баталгаажуулсан нөхцөлд түгээх шаардлагатай.

Мэдээлэл, түүний чанар үнэ цэнтэй учраас орчин үеийн боловсролтой иргэд сонгуулийн явц, үр дүн зэргийн талаар албаны буюу мэргэжлийн хүний ул суурьтай үгийг сонсохыг урьтал болгож, хэвлэл мэдээллээс үүнийг хүсэн хүлээж байдаг.

3. Олны танил хүмүүс

Сонирхолтой нь, нэр алдартай хүмүүст холбогдох бүхий л баримт, мэдээлэл хүмүүст илүү хүрч, сэтгүүл зүй болж чаддаг онцлогтой.³⁴ Тиймээс олны танил хүмүүс, одод сэтгүүл зүйн төвд байж, үргэлжийн гол сэдэв нь болж, хэвлэлүүд тэднийг эх сурвалжаа болгохыг эрмэлздэг. Нам, эвслийн дарга, гишүүд, УИХ-ын гишүүн, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд зэрэг эх сурвалжийг энэ түвшинд авч үздэг. Энгийн үед эдгээр эх сурвалжийг албаны эх сурвалжид тооцох боломжтой ч сонгуулийн үеэр тэд тодорхой нэг нам эвслийг төлөөлөх, хувь хүний үзэл бодлоо түгээх магадлалтай учраас ашиг сонирхлын зөрчилтэй хэмээн үзэж болно.

Иймээс, олон улсын практикт сонгуулийн үеэр энэ төрлийн эх сурвалжийн мэдээллийг нягтлах, төвч өнцгийг баримтлах үүднээс зарим тохиолдолд мэдээлэхээс татгалзах, эсвэл эсрэг тэсрэг байр суурьтай хоёр төрлийн эх сурвалжийн мэдээллийг хамтад нь түгээдэг. Ингэхдээ, сэтгүүлч өөрийн байр суурь болон санаа бодлоо илэрхийлэхээс зайлсхийж, зөвхөн мэдээлдэг.

СОНГУУЛИЙН ҮЕИЙН МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛД ЭХ СУРВАЛЖИЙГ ДУРДАХ, ЭС ДУРДАХ

Сэтгүүлчид үзэж харсан зүйлээ бичихдээ эх сурвалж дурдах шаардлагагүй. Харин эсрэг тохиолдол буюу мэдээллийг хоёрдогч этгээдээс авсан нөхцөлд, ялангуяа, эргэлзээтэй, эсвэл чухал мэдээлэлд эх сурвалжийг заавал тодорхой дурдана.

Сонгуулийн үеэр уншигч, үзэгч, сонсогчдод эргэлзээ төрүүлж болохуйц бүх төрлийн мэдээлэлд заавал эх сурвалжийг дурддаг. Ийм төрлийн мэдээлэлд сонгуулийн үр дүн, ирцийн мэдээлэл, нам эвслээс хийсэн мэдэгдэл зэрэг ордог.

34 Мөн тэнд

Сонгуулийн үеэр нэр дэвшигч, нам, эвслүүд сонгуулийн хууль болон бусад холбогдох хуулийг зөрчсөн, өрсөлдөөний бохир арга хэрэглэсэн талаарх мэдээллийг дамжуулахад эх сурвалжийн хүсэлтээр нэрийг нь нууцалж болно. Эх сурвалж сэтгүүлчид хандан чухал ач холбогдолтой мэдээлэл өгөхдөө нэрээ нууцлахыг хүсвэл сэтгүүлч түүний нэрийг нууцлах ёс зүйн үүрэг хүлээдэг.

СОНГУУЛИЙН ҮЕЭР ЭХ СУРВАЛЖТАЙ ЯРИЛЦЛАГА ХИЙХ НЬ

Сонин сэтгүүл, радио телевиз, мэдээллийн сайт гээд ХМХ-ийн аль ч салбарын хувьд ярилцлага бол сэтгүүлч болон нэр дэвшигч, эх сурвалжийн хооронд харилцан тохиролцох үйл явц юм.

Сэтгүүлч сонгуулийн үеэр ярилцлага авч байхдаа нэр дэвшигч болоод нам эвслийн дарга, улс төрчдийг маш анхааралтай сонсож, хүмүүст үгээ хэлэхэд нь тусалж дэмжих үүрэг хүлээдэг.

CNN, ABC зэрэг томоохон мэдээллийн агентлагийн сэтгүүлчид сонгуулийн үеэр шуурхай мэдээлэл бэлтгэхдээ эх сурвалжийн түвшин тус бүрээс асуух магадлал бүхий тодорхой тооны асуултуудыг бэлтгэж боловсруулдаг байна.

Сонгуулийн үеэр эх сурвалжтай амжилттай ярилцлага хийхэд дараах дөрвөн үндсэн зарчимд тулгуурладаг.³⁵ Үүнд:

1. Ярилцлага авахын өмнө тухайн хүний мэддэг асуудлын талаар олж мэдэх.
2. Ярилцлагын зорилгоо тодорхойлох, тухайлбал, тэр хүнээс ямар мэдээлэл, өгүүлэл, баримт нотолгоо олж авахаа урьдчилж мэдэх.
3. Ярилцлага бүр нь эрх тэгш хүмүүсийн хооронд өрнөж буй үйл явц гэдэг хандлагаар хандах, бүх нэр дэвшигчдэд адил тэгш хандах.
4. Асуулт, хариулт аль хэр хүнд, маргаантай байхаас үл хамааран бусдад найрсаг, хүндэтгэлтэй хандах. Тухайн хүн илэн далангүй хариулт өгөх зориг гаргахаар ойлгомжтой асуулт тавьж, хүндэтгэлтэй хандан, итгэлийг нь төрүүлэх.

СОНГУУЛИЙН ҮЕЭР ИХЭВЧЛЭН ШУУРХАЙ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛДАГ ТУЛ ЯРИЛЦЛАГЫН ҮЕД ДАРААХ ЗҮЙЛСЭЭС ЗАЙЛСХИЙХ ШААРДЛАГАТАЙ.³⁶

1. Нэг дор хоёр буюу түүнээс олон асуулт бүү тавь. Нэр дэвшигч хоёр асуултын сүүлийнхэд нь, эсвэл аль амарханд нь хариулах магадлалтай.
2. Хүссэн хариултаа авахуйц асуулт бүү тавь. Ийм асуулт сэтгүүлчийн зөв, зочны буруу гэсэн сэтгэгдэл төрүүлдэг. Энэ нь “Та тэгж бодоогүй гэж үү?”, “Та тэгэх ёсгүй байсан биш үү?” гэх мэт асуулт юм.

³⁵ Олон Улсын Хэвлэл мэдээллийн дэмжлэг, Хэвлэл мэдээлэл ба ардчилал групп, Эрх чөлөөний сүлжээ (2006), Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийг дэмжих нь (Coaching Manual for Media Support during Elections). Дадлагажуулагчдад зориулсан гарын авлага, https://www.gic.mn/public/docs/publications/coaching_manual_2020_FINAL.pdf

³⁶ Мөн тэнд

3. Үзэл бодлоо асуултдаа бүү оруул. Ингэх нь мэдээллийн чухал урсгалыг таслан зогсоож, нэр дэвшигчийг өөр зүйлийн тухай ярихад хүргэдэг сул талтай.
4. Хэт тулгасан асуулт бүү тавь. Ийм өнгө аястай асуулт чинь тухайн нэр дэвшигчийн санаа бодолтой нийлэхгүй байж болно. Иймээс тухайн нэр дэвшигч сонор сэрэмжээ дээшлүүлж, чөлөөтэй ярилцаж чадахгүйд хүрч, мэдээллээ нуун дарагдуулах тохиолдол гарч болно.
5. Асуулт тавихдаа өдөөн хатгасан, мэдрэмжгүй үг хэллэг бүү ашигла. Тухайн хэлсэн өдөөн хатгалга чинь ярилцлагын зорилгоос нь хазайлгадаг.
6. Нэг талыг барьсан үг хэллэг бүү ашигла. Тухайн нэр дэвшигч, эсвэл ямар нэгэн нам, эвслийг дэмжсэн өнгө аяс бүхий асуулт асуухыг олон улсын практикт хориглодог.
7. Хэт сунжирсан асуулт бүү тавь. Богино асуулт тодорхой байдаг төдийгүй булзайруулах цаг өгдөггүй, мөн тодорхой хариулт шаарддаг.

СУДАЛГАА БУЮУ БИЧГИЙН ЭХ СУРВАЛЖТАЙ АЖИЛЛАХ

Энэ нь хүний хувийн тэмдэглэлээс эхлээд бичиг зохиол, ном, тайлбар болон нэвтэрхий толь, янз бүрийн хэвлэмэл материалууд, улмаар аудио видео бичлэг, албан баримт, архивын материал зэрэгт сэтгүүлч судалгаа хийж, бичих сэдэв, асуудалтай холбоотой мэдээлэл олж цуглуулах арга юм³⁷. Бичгийн эх сурвалжтай ажиллах нь дараах хоёр төрлөөс бүрдэнэ.

- **Бичих сэдвийнхээ дагуу холбоотой мэдээлэл судлах**

Сонгуулийн үеийн мэдээ мэдээллийг бэлтгэж байхдаа нэр дэвшигчдийн өмнө нь хэвлэлд өгч байсан ярилцлага, оролцож байсан үйл явдлын сурвалжилга зэргийг ашигласнаар үзэгч, сонсогч, уншигчдад тухайн хүний өмнө нь ямар ажил эрхэлж байсан талаар эргэн сануулдаг онцлогтой.

Тухайн бичих, нэвтрүүлэх гэж буй үйл явдалтай холбоотой өмнө нь нийтлэгдэж байсан мэдээ, сурвалжилга, нийтлэл, нэвтрүүлэг болон архивын баримт материалуудыг олж, нийтлэл нэвтрүүлэгтээ баримт болгон хэрэглэх, эх сурвалжаас асуулт асуухдаа ашиглах нь мэдээ, мэдээллийг бодитой, үнэ цэнтэй болгодог.

- **Судалгааны байгууллагуудын бэлтгэсэн судалгаа ашиглах**

Нийгмийн судалгаа хийдэг судалгааны байгууллага, хувь судлаачдын судалгааг нийтлэл нэвтрүүлэгтээ ашиглах шаардлага сэтгүүлчдэд цөөнгүй тохиолддог. Ялангуяа, сонгуулийн талаарх мэдээ, мэдээлэлд судалгааны байгууллагуудаас гаргасан судалгааны материалуудыг ашиглах нь оновчтой сонголт. Гэхдээ, нэр дэвшигчийн рейтинг тогтоох судалгааны үр дүнг хэвлэл мэдээллээр дамжуулахыг хориглодог.

³⁷ Амартүвшин. С., Батбаатар. Ж., (2014) Сэтгүүлчийн ур чадвар, Улаанбаатар, х.109.

СОНГУУЛИЙН ҮЕЭР НЭЭЛТТЭЙ ӨГӨГДӨЛТЭЙ АЖИЛЛАХ НЬ 8.

(Статистик тоон мэдээллийг ашиглан нийтлэл нэвтрүүлэг бэлтгэх)

Сүүлийн жилүүдэд визуаль сэтгүүл зүй, моб сэтгүүл зүй, дата сэтгүүл зүй зэрэг сэтгүүл зүйн цоо шинэ арга хэлбэрүүд хөгжиж байна.

Эдгээрээс сонгуулийн үеийн мэдээ мэдээллийг бэлтгэхэд ашиглахад хамгийн чухал, тохиромжтой арга хэлбэр нь дата сэтгүүл зүй юм. Дата сэтгүүл зүйн тухай ярихын тулд эхлээд өгөгдлийн талаар тайлбарлах нь зүйтэй.

ӨГӨГДӨЛ БУЮУ ДАТА ГЭЖ ЮУ ВЭ? ТҮҮНИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ВЭ?

Өгөгдөл гэдэг нь өөрөө компьютерын хатуу диск дээр хадгалагдсан “битүүд болон байтуудаас” бүрдсэн үл үзэгдэх зүйл юм. Мөн өгөгдөл бол боловсруулагдаагүй мэдээлэл бөгөөд баримтуудын цуглуулга юм. Бидний эргэн тойронд хором бүр өгөгдөл үүсч байдаг. Өгөгдөл нь томоохон серверт хадгалагддаг. Сонгуулийн үйл явц нь ихэвчлэн тоон өгөгдөл дээр тулгуурласан мэдээ мэдээлэл байдаг тул тоон өгөгдөлд боловсруулалт хийж, мэдээлэл түгээдэг сэтгүүл зүйн шинэ арга хэлбэр болох дата сэтгүүл зүйг сүүлийн жилүүдэд өргөнөөр хэрэглэх болжээ.³⁸

Дата сэтгүүл зүйг сонгуулийн үеийн мэдээлэлд ашигласнаар:

- Сонгуулийн хэтийн төлөв, нам, эвсэл, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрийн хэрэгжих боломжтой эсэхийг үнэлэх.
- Сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө орлогын мэдүүлэгт харьцуулсан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хууль бус үйлдэлтэй тэмцэх.
- Намуудын мөрийн хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих.
- Сонгуулийн үр дүн болон ирцийн мэдээллийг уншигч үзэгчдэд хялбар, ойлгомжтойгоор түгээх зэрэг боломжуудыг олгож байна.

ӨГӨГДЛИЙГ ХЭРХЭН МЭДЭЭЛЭЛ БОЛГОХ ВЭ?

Өгөгдлийг ойлгох, ойлгомжтойгоор түгээхийн тулд заавал дүрсжүүлэх хэрэгтэй. Өгөгдлийг дүрсжүүлэн, зураг текст, хүснэгт, газрын зураг, график гэх мэт хэлбэрт оруулж, хэрэглэгчдэд түгээх нь маш чухал болоод байна. Орчин цагийн уншигчид аль болох товч хэлбэрээр мэдээллийг хүлээн авахыг хүсдэг болжээ. Иймээс нэг зургаар мянган үгийг орлох сүүлийн үеийн сэтгүүл зүйн нэг арга хэрэглүүр дүрсжүүлсэн өгөгдөл буюу мэдээллийн график, дүрст тэмдэгтүүд юм. Инфографик нь орчин үеийн тоон мэдээллийн хэрэгслийн хамгийн шилдэг агуулгыг хурдан бөгөөд хялбар түгээх маркетингийн нэг хэлбэр юм.

Иймээс орчин үеийн сэтгүүлчид боловсруулсан өгөгдлийг дүрсжүүлэн, олон нийтэд түгээх чадварыг эзэмших шаардлагатай болжээ. Орчин үед өндөр хөгжилтэй орны сэтгүүлчид сонгуулийн мэдээллийг түгээхдээ мэдээллийн график, дүрст тэмдэгтүүдийг ашиглаж байна.³⁹

38 Harrower, T. (2012). Newspaper designers handbook, New York, p.130

39 Harrower, T. (2016). Inside reporting, New York, p.124


МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТ ЯАГААД ХЭРЭГТЭЙ ВЭ? ТҮҮНИЙГ ХЭРХЭН ХИЙХ ВЭ?

XXI зууны уншигчдын дийлэнх нь визуаль мэдээллийг сонирхдог болжээ. Энэ нь сүүлийн үеийн судалгаануудаар ч батлагдаж байна. Олон улсын дата корпорацын судалгаагаар интернэт хэрэглэгчдийн 45 хувь ямар нэг дүрст тэмдэгт эсвэл графикаас өдөрт дор хаяж 30 орчим мэдээлэл тогтмол хүлээн авдаг талаар дурджээ.⁴⁰ Мөн орчин цагийн уншигчдын дийлэнх хувь нь цаг хугацаагаар хязгаарлагдахгүйгээр мэдээ мэдээллийг хялбар олж, хялбар ойлгох хүсэлтэй байдаг талаар өөр нэг байгууллагын судалгаанд дурдсан байна.

“Ганц зураг мянган үгийг орлоно”⁴¹, “Хүний тархи нэг харсан мэдээлээ тогтоохоор кодлогджээ”⁴² зэргээр визуаль мэдээ мэдээллийн ач холбогдлыг өндрөөр үнэлсэн тодорхойлолтуудыг сэтгүүл зүй, тэр дундаа дата сэтгүүл зүйн судлаачид сүүлийн үед өргөнөөр ашиглах болжээ. Учир нь, боловсруулсан өгөгдлийг мэдээлэл болгоход мэдээллийн график, дүрст тэмдэгтийг ашигладаг болсон байна.

Жишээ №1. Америкийн Нэгдсэн Улсын Конгрессийн сонгуульд Ардчилсан нам болон Бүгд Найрамдах Намын гишүүдийн эзлэх тоог харуулсан мэдээллийн график, дүрст тэмдэгт (New York Times сонин)

ЗУРАГ 4. АНУ-ЫН КОНГРЕССИЙН ДУНД ХУГАЦААНЫ СОНГУУЛИЙН ҮР ДҮН



40 Newsom, D. & Haynes, J. (2004). Public Relations Writing: Form and Style. p.236

41 Harrower, T. (2012). Newspaper designers handbook, New York, p.132

42 Smiciklas, M (2012). The Power of Infographics: Using Pictures to Communicate and Connect with Your Audience

Сэтгүүл зүйн судлаачид мэдээллийн график, дүрст тэмдэгтийг “Үйл явдал, үзэгдлийн хамгийн чухал, сонирхолтой баримт, санаа, эсвэл тайлбарлахад төвөгтэй мэдээллийг дүрс хэлбэрээр дамжуулан зохистой орчинд үзүүлж буй бэлгэдэл, дүрслэх урлагийн хосолмол, тэмдэгтийн орчин юм”⁴³ хэмээн тэмдэгт талаас нь оновчтой томъёолжээ. Харин “Мэдээллийн график нь хурдан шуурхай, тодорхой, цогц мэдээллийг танилцуулах зорилготой мэдээлэл, тоо баримтын дүрст төлөөлөл юм”⁴⁴ хэмээн графикийг зорилго талаас нь томъёолсон бол “Мэдээллийн графикийг бий болгох нь өгөгдлийг төсөөлж, мэдээлэл боловсруулах, мэдээ мэдээллийн архитектурын ажил юм”⁴⁵ хэмээн тайлбарласан нь мэдээллийн графикийн боловсруулалтыг уран барилгатай адилтгаж, уран бүтээлч шинжтэй зүйрлүүлсэн. Эдгээрээс харвал, мэдээллийн график нь нэгдүгээрт, үйл явдал үзэгдлийн хамгийн сонирхолтой, тайлбарлахад төвөгтэй зүйлсийг цогц байдлаар мэдээлэхэд тустай, хоёрдугаарт, мэдээллийг танилцуулах зорилготой тоо баримт бүхий цогц мэдээлэл, гуравдугаарт, мэдээллийн графикийг бэлтгэхдээ өгөгдлийг төсөөлж, мэдээллийг боловсруулдгаараа архитекторын ажилтай адил юм. Иймээс, мэдээллийн графикийг үйл явдал, үзэгдлийн хамгийн сонирхолтой, тайлбарлахад төвөгтэй зүйлсийг нэгэн цогц болгон хамгийн сонирхолтой, өвөрмөц шийдлээр илэрхийлж буй тэмдэгтийн орчин хэмээн тодорхойлж болох юм.

Мэдээллийн график, дүрст тэмдэгтийг 1982 онд “USA Today” сонин мэдээллийг хялбар түгээхийн тулд мэдээллийн графикийг ашиглаж эхлэн, ХМХ-д нэвтрүүлсэн түүхтэй. Тус сонины мэдээллийн график нь тухайн үедээ шинэлэг зүйл болсон. “USA Today” сонин өнгөт зураг, диаграмм бүхий графикаараа бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээс ялгарч байв. Гэвч, 1982 оноос өмнө мэдээллийн графикийг ашиглаж байсан түүхэн баримт байдаг. 1898 онд “New York Times” сонин мэдээллийн графикийг ашигласан бол “NASA Voyager” хэмээх хиймэл дагуулаас авсан од хоорондын зайн тухай мэдээллийг 1977 онд диаграм ашиглан хүргэж байжээ. Харин “USA Today” сонин нь зураасан зураг, график, диаграммыг ашиглан гоймонгийн хэмжээ, хэрэглээний талаарх мэдээллийг мэдээллийн график, дүрст тэмдэгт ашиглан үзүүлсэн нь мэдээллийн график дүрст тэмдэгтийн шинэ үе ирснийг батлах үзүүлэлт болсон юм.


Жишээ №2. 1982 оны “USA Today” сонины ашигласан мэдээллийн графикийг сэтгүүл зүйн судлаачид дэлхийн анхны мэдээллийн график хэмээн үздэг.

43 Болд-Эрдэнэ. Б. (2014). Сонины дизайн. Улаанбаатар

44 Newsom, D. & Haynes, J. (2004). Public Relations Writing: Form and Style. p.236

45 Smiciklas, M (2012). The Power of Infographics: Using Pictures to Communicate and Connect with Your Audience

ЗУРАГ 5. 1982 ОНЫ “USA TODAY” СОНИНЫ МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК



XXI зуунд компьютерын хэрэглээ нэмэгдэж, ширээний хэвлэх машин, веб сайт, блог бий болж, мэдээллийн график, дүрст тэмдэгт хөгжих боломж бүрдэж эхлэв.

Мэдээллийн график, дүрст тэмдэгтийн судалгаа нь харьцангуй шинэ салбар хэдий ч, өнөөдөр энэ талаар судалгаа шинжилгээ өргөнөөр хийх болжээ. Өнөөгийн мэдээллийн график, дүрст тэмдэгт нь уншигчдад мэдээллийг уншиж ойлгох, мэдээллийг түргэн боловсруулахад тусладаг гол хэрэглүүр болон хөгжиж байна. Орчин үеийн мэдээллийн график нь текстээрээ биш гарчиг, зураг, диаграммаараа уншигчдын анхаарлыг татаж, унших сонирхлыг нь өдөөдөг. Мэдээллийн график нь уншигчдад мэдээллийг шуурхай дамжуулахын зэрэгцээ маш хурдан ойлгогддог.

МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТ ЯМАР БАЙХ ЁСТОЙ ВЭ?


Мэдээллийн графикийг бүтээх алтан дүрэм бол зөвхөн нэг агуулгын хүрээнд бэлтгэх явдал юм. Тиймээс, дүрс зургийн араас хэт хөөцөлдсөн, эсвэл нэг хавтгайд хэт олон төрлийн баримт, эсвэл санааг багтаасан график чанартай болохгүй.

Мэдээллийн график, дүрст тэмдэг бүхий мэдээллийн давуу талууд нь:

- Мэдээллийн баримт, тоог бичвэрт нуршихгүйгээр графикаар үзүүлэх нь илүү хялбар ойлгогддог.
- Мэдээллийн график дүрст тэмдэгт нь уншигчдад илүү сайн тогтоогддог.
- Веб хуудасны өнгө үзэмж загвар дизайныг сайжруулдаг.
- Мэдээллийн дараалал болон ач холбогдлыг тодотгодог.
- Орчин үеийн уншигчид график, дүрс тэмдэгтийг ашиглан, мэдээлэл авах сонирхолтой байдаг учраас олон хүнд хүрэх боломжтой.
- Тоо, баримт, утга санааг ялгаж харуулдаг.
- Түүхэн хөгжил, өсөлт бууралт, төлөв байдал мэтийн сонирхолтой нотолгоог хялбар аргаар жишээлэн үзүүлдэг.


Жишээ №3. АНУ-ын сонгуулийн мэдээ мэдээллийг графикаар хүргэхдээ тоон мэдээлэл, газар нутгийн нэрийг дурдахгүй өнгөрсөн нь доорх мэдээллийн графикийг сонирхолгүй болгожээ.

ЗУРАГ 6. АНУ-ЫН СОНГУУЛИЙН МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК



Жишээ №4. Ikon.mn сайтын 2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүнг мэдээлсэн мэдээллийн графикийн загвар дизайн, мэдээллийн агуулга нэлээд сайн болсон бөгөөд сонгуулийн тойрог тус бүрт нэр дэвшигчдийн авсан саналыг оруулжээ.

ЗУРАГ 7. ИКОН.МН САЙТЫН 2020 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГ МЭДЭЭЛСЭН МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК



МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТИЙН ТӨРЛҮҮД


Мэдээллийн график, дүрст тэмдэгт нь уншигчдыг мэдээллээр хангах, уншигчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх зорилготой. Мэдээллийн графикийг ихэвчлэн дүрст тэмдэгтэн мэдээлэл, хэвтээ болон дугуй график, хүснэгт, диаграмм гэсэн төрөл зүйлүүдээр бэлтгэдэг.

СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТ

Энэ төрлийн мэдээллийн графикт диаграмм, график, хүснэгт, жагсаалт зэрэг ордог. Хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь хэвтээ график, босоо график, дугуй график, хүснэгт юм. Энэ төрлийн график нь цогц, дэлгэрэнгүй мэдээ, мэдээллийг үзүүлдэг. Мөн үйл явдал, үзэгдлийн үр дүн, дүгнэлтийг хамгийн энгийн байдлаар харуулдаг өндөр үр дүн бүхий мэдээллийн график юм. Манайд эдийн засаг болон спортын мэдээллийг статистик графикаар хүргэж байна.

Жишээ №5. Статистик суурьтай мэдээллийн график, дүрст тэмдэгт мэдээллийн үр дүн, харилцан хамаарлыг тодорхойлоход чухал үүрэгтэй. Энэ нь дотроо олон төрөл зүйлтэй байдаг.

ЗУРАГ 8. СТАТИСТИК СУУРЬТАЙ МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТИЙН ТӨРЛҮҮД



ТҮҮХЭН ХАРЬЦУУЛАЛТ МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТ

Энэ төрлийн график нь үйл явдлыг болсон цаг хугацааг дэс дарааллаар нь мэдээлдэг. Тухайн график нь түүхэн ойлголтыг уншигчдад маш хурдан хүргэдэг онцлогтой бөгөөд хүснэгт болон он цаг заасан график зэрэг хэлбэртэй байдаг.

Жишээ №6. АНУ-ын 2012 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үеийн аяныг харуулсан мэдээллийн график дүрст тэмдэгт. Энэхүү графикт сонгуулийн аяны үе шатыг мэдээлсэн байна.

ЗУРАГ 9. ТҮҮХЭН ХАРЬЦУУЛАЛТ МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТ




ҮЙЛ ЯВЦЫН МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТ

Энэ төрөлд ихэвчлэн хоол хийх арга, эмийн жор зэргийг тайлбарласан байдаг. Мөн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар мэдээлэхэд энэ төрлийн график, дүрст тэмдэгтийг ашигладаг. Диаграмм, хүснэгт, хэвтээ босоо график, фото зураг, зураасан зураг, видео зэрэг дүрст мэдээлэл түгээх бүх хэлбэрийг ашигладаг.

Жишээ №7: АНУ-ын сонгуулийн процессын талаарх мэдээллийн график (New York Times)

ЗУРАГ 10. ҮЙЛ ЯВЦЫН МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТ




ГАЗАР ЗҮЙ БОЛОН БАЙРШИЛ ЗААСАН МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК

Газрын зураг ашиглах нь газар зүйн мэдээллийн графикийн хамгийн чухал сонголт юм. Газрын зурагт бэлгэ тэмдэг, сум, график, диаграмм зэргийг ашигладаг. Хурдны зам, гудамж, метро, эмнэлэг зэрэг байгууламжийг заасан олон дүрст тэмдэгтүүдийг газрын зурагт хэрэглэдэг. Энэ төрлийн дүрст тэмдэгт нь үйл явдал, үзэгдлийн байршлыг заагч, хамрах хүрээ, байдлыг үзүүлж, үр дүн, ач холбогдлыг тодорхойлдог онцгой ач холбогдолтой мэдээллийн график юм.

Жишээ №8. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгийн талаар мэдээлсэн газрын зураг суурьтай мэдээллийн график дүрст тэмдэгт

ЗУРАГ 11. ГАЗАР ЗҮЙ БОЛОН БАЙРШИЛ ЗААСАН МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК, ДҮРСТ ТЭМДЭГТ «АНУ-ЫН 2016 ОНЫ СОНГУУЛИЙН САНАЛЫН ЗУРАГЛАЛ»



Мэдээллийн график, дүрст тэмдэгтийг бэлэн болгоход юуг анхаарах вэ?

Судлаачид мэдээллийн график хийх таван үе шатыг дурдсан байдаг.⁴⁶ Үүнд:

1. Санаа авах
2. Тоймлон бодох
3. Мэдээлэл цуглуулах
4. Баримтаа боловсруулах
5. Хэлбэр хэв маягаа сонгох зэргийг авч үздэг.

Дээрх үе шатыг дэлгэрүүлж мэдээллийн график, дүрст тэмдэгтийг бий болгохдоо хэрэгжүүлэх дараах арван алхмыг боловсруулав. Үүнд:

46 Smiciklas, M (2012). The Power of Infographics: Using Pictures to Communicate and Connect with Your Audience

- 1-р алхам: Хийх хугацаагаа тодорхойлох
- 2-р алхам: Чиглэлээ гаргах
- 3-р алхам: Зардлаа тооцох
- 4-р алхам: Мэдээллийг ялгаж, зохион байгуулах
- 5-р алхам: Тоймлон бодох /таамаглах/
- 6-р алхам: Санаагаа тодорхойлох /таамаглалыг тодорхой болгох/
- 7-р алхам: Эхний хувилбарыг хийх
- 8-р алхам: Сайжруулах
- 9-р алхам: Эцсийн бүтээгдэхүүн гаргах
- 10-р алхам: Олон нийтийн хүртээл болгох

МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК БЭЛТГЭХЭД ЗОРИУЛСАН БАГАЖ ХЭРЭГСЭЛ БОЛОН ПРОГРАММУУД

Мэдээллийн графикийг бүтээхэд сэтгүүлчээс мэдээллийн технологийн өндөр ур чадвар шаарддаг байсан үе саяхан. Гэтэл сүүлийн жилүүдэд өгөгдлийг график, дүрст тэмдэгт болгон хувиргаж, дизайны өвөрмөц шийдлээр түгээхэд маш хялбар болжээ. Учир нь, сүүлийн үед дизайнер, программистын оролцоогүйгээр бэлэн загварыг өөрчилж, дүрст тэмдэгтийг хялбархан бэлтгэдэг интернэтэд суурилсан програмууд бий болжээ.

ӨГӨГДЛИЙГ ДҮРСЖҮҮЛДЭГ ҮНДСЭН ГОЛ ПРОГРАММУУД:

[VISME /WWW.VISME.CO/](http://WWW.VISME.CO/)

Visme бол хөдөлгөөнт танилцуулга, мэдээллийн график, дүрст тэмдэгт, зар сурталчилгаа зэргийг өвөрмөц шинэ шийдэл бүхий дизайнаар бэлтгэх боломжийг олгодог шилдэг мэдээллийн систем юм. Энэ программ нь олон төрлийн сонголт бүхий бэлэн загвараас бүрдсэн электрон каталоогоос бүрддэг. Энэ программ нь слайд /presentation/ бэлтгэхэд зориулсан хамгийн шилдэг программ юм.

[EASEL.LY /WWW.EASEL.LY/](http://WWW.EASEL.LY/)

“Easel.ly” нь мэдээллийн газар зүй болон байршил заасан мэдээллийн график бэлтгэхэд илүү оновчтой мэдээллийн систем юм. Уг программын өгөгдлийн санд маш олон төрлийн бэлэн загвар байдаг.

[FAST COMPANY /HTTPS://WWW.FASTCOMPANY.COM/](https://WWW.FASTCOMPANY.COM/)

Энэ платформ (хэрэглэгчид бүртгүүлж ашиглана) нь олон төрлийн график, газрын зураг, түүхэн харьцуулалт график, bubble graphic, tree map, пиктограмм зэргийг бэлтгэхэд хэрэглэдэг үнэгүй мэдээллийн систем юм.

[PIKTOCHART /WWW.PIKTOCHART.COM/](http://WWW.PIKTOCHART.COM/)

Энэ программ нь график дизайнерын шаардлагагүйгээр хүссэн графикаа бүтээх боломжийг агуулдаг. Piktochart нь өгөгдлийн сандаа 400 гаруй бэлэн загвар, 10 мянга орчим графикийн сантай.

[CANVA /WWW.CANVA.COM/](http://WWW.CANVA.COM/)

Хамгийн гайхамшигтай дизайнтай мэдээллийн графикийг бүтээхэд хэрэглэдэг вебпрограмм бол “canva” юм. “Canva” нь бүх төрлийн мэдээллийн графикийг бэлтгэдэг. Тус программ нь өөртөө хэрэглэгчийн гарын авлага бүхий видео хичээлүүдтэй байдаг. Иймээс анхлан хэрэглэж байгаа хүмүүс суралцахад илүү хялбар.

[INFOGRAM /WWW.INFOGRAM.COM/](http://WWW.INFOGRAM.COM/)

Infogram нь мэдээллийн график, дүрст тэмдэгтийг хамгийн хялбархан бүтээдэг шилдэг программ юм. Энэхүү программыг ашиглаж Photoshop, InDesign, Illustrator, Corel Draw зэрэг мэргэжлийн график дизайны программуудын бүтээсэн мэдээллийн графиктай эн зэрэгцэхүйц загвар дизайн бүхий мэдээллийн график бүтээх боломжтой. Одоогийн байдлаар энэ программыг ашиглан, хэдэн сая төрлийн мэдээллийн график, дүрст тэмдэгт бэлтгэх боломжтой (үнэгүй хэрэглэж байгаа нөхцөлд мянга гаруй төрлийн мэдээллийн график боловсруулах боломжтой). Энэ программыг “Euronews”, “Халпингтон пост”, “Вашингтон Пост” зэрэг томоохон байгууллагууд өдөр тутмын ажилдаа тогтмол хэрэглэж байна. Төлбөргүй ашиглаж байгаа тохиолдолд зөвхөн веб хуудас болон олон нийтийн сүлжээнд байршуулж болно. Энэ программ нь бүх төрлийн платформд зориулсан хувилбартай байдаг.

[FLOURISH STUDIO /HTTPS://FLOURISH.STUDIO/](https://FLOURISH.STUDIO/)

Өргөн цар хүрээ бүхий их өгөгдлийг дүрсжүүлэхэд энэ программыг ашигладаг. Тус программ нь хялбар аргаар мэдээллийн графикийг бий болгодог. Үүлэн технологид суурилсан программ учраас бэлтгэсэн графикаа хүссэн үедээ ашиглах, засварлах боломжийг агуулдаг. Энэ программаар бэлтгэсэн загварын дизайны хувьд тийм төгс болж чаддаггүй.

[TABLEAU /WWW.TABLEAU.COM/](http://WWW.TABLEAU.COM/)

Энэ нь өгөгдлийг дүрсжүүлэхэд ашигладаг хамгийн шилдэг программ хангамжуудын нэг юм. Энэ программ нь дараах хэдэн боломжийг өөртөө агуулдаг. Үүнд:

- Өгөгдлийг маш хурдан нэгтгэж дүрсжүүлдэг.
- Өгөгдлийг өөрөө автоматаар хайдаг.
- Програмын шинэчлэл нь автоматаар тогтмол хийгддэг.
- Үүлэн технологийг ашигладаг тул сүлжээнд холбогдсон газраас бэлтгэсэн график дүрс тэмдэгтээ татаж авч үзэх, засвар хийх боломжтой.


[FASTCHARTS.IO /HTTPS://FASTCHARTS.IO/](https://FASTCHARTS.IO/)

“New York Times” сониноос гаргасан мэдээллийн график бэлтгэдэг шилдэг программ хангамж. Энэ программ нь ихэвчлэн эдийн засгийн болон санхүүгийн тайлан тооцоо аудитын дүгнэлт зэрэг мэдээллийг график хэлбэрт оруулахад ашиглагддаг байна. Өгөгдлийг дүрсжүүлдэг хамгийн орчин үеийн программ юм.


Жишээ №9: Fastcharts.io программыг ашиглан “New York Times” сонины хавсралт “Financial Times”-д зориулан бэлтгэсэн дата

ЗУРАГ 12. ДАТА ДҮРСЖҮҮЛЭЛТ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ (НЬЮ-ЙОРК ХОТЫН ДҮҮРГҮҮДИЙН ХҮН АМЫН ТОО)

Жишээ №10: Fastcharts.io программыг ашиглан “New York Times” сонины хавсралт “Financial Times”-д зориулан бэлтгэсэн датаг дүрсжүүлсэн байдал



ЗУРАГ 13. ДАТА ДҮРСЖҮҮЛСЭН БАЙДАЛ (НЬЮ-ЙОРК ХОТЫН ДҮҮРГҮҮДИЙН ХҮН АМЫН ТОО)



Өгөгдлийг дүрсжүүлэхэд хэрэглэдэг бусад программ:

- Олон янзын дүрсийг Icon архиваас хайх (www.iconarchive.com).
- Pixlr үнэ төлбөргүй онлайн зураг засварлагч (www.pixlr.com).
- Газрын зураган мэдээллийг боловсруулдаг Star planet (<http://www.stat-silk.com/software/statplanet>).
- Цахим график бүтээгч Hohli (<http://charts.hohli.com>).
- Хялбархан диаграмм хийх боломж олгох Creately (www.creately.com).
- Өөрсдийн мэдээллийг маш хялбар аргаар мэдээллийн дүрст тэмдэгт болгоход зориулсан IBM-ийн технологи дээр суурилсан Many Eyes программ (<https://boostlabs.com>).
- Gapminder хэмээх мэдээлэл боловсруулдаг программ хангамж нь мэдээллийн график хийхэд чухал, программ жил бүр шинэчлэгддэг. (www.gapminder.org).
- Inkscape хэмээх олон янзын мэдээллийн график үйлдвэрлэдэг программ хангамж. Энэ программ нь google chart-ын багажийг ашиглан олон төрлийн мэдээллийн график хийдэг (<https://inkscape.org>).
- AmCharts – HTML5 хэлийг ашиглан вебэд суурилсан хөдөлгөөнт мэдээллийн график бүтээдэг программ хангамж юм. (www.amcharts.com).
- Color calculator – Энэ нь мэдээллийн график, дүрст тэмдэгтийг боловсруулахад өнгөний ялгарал, зохицлыг гаргахад тусалдаг интернэтэд суурилсан программ юм. (<https://www.sessions.edu/color-calculator>).

СОНГУУЛИЙГ МЭДЭЭЛЖ, СУРВАЛЖЛАХДАА ЁС ЗҮЙГ БАРИМТЛАХ НЬ

9.

ЁС ЗҮЙН ТҮГЭЭМЭЛ АЛДААНААС СЭРГИЙЛЭХ

1. Сэтгүүлч та мэдээлээ бусдаас шуурхай хүргэхийн тулд нягтлалгүйгээр санамсаргүй алдаа гаргахаас сэргийлээрэй (Сонгуулийн үеэр мэдээллийн хурдаас илүүтэй бодитой, баримттай, тэнцвэртэй мэдээлэл хамгийн чухал).

- ✓ Мэдээлэл бодит эсэхийг шалгах. Хамгийн түрүүнд тухайн үйл явдал, үзэгдэл үнэн бодит, болсон эсэхийг шалга. Тэгээд дараагийн алхмуудаа хий.
- ✓ Тодорхой баримтуудыг шалгах. Жишээ нь, орон зай, цаг хугацаа, холбогдох хүмүүсийн нэр, албан тушаал болон бусад зүйлсийг тодорхойлохоос эхэлнэ. Маш нямбайгаар, нэг нэгээр нь нарийвчлан шалгаарай.

2. Сэтгүүлч та худал мэдээлэл, доромжлол, гүтгэлэг бүү түгээгээрэй.

- ✓ Аливаа мэдээллийг албаны мэдээллээр баталгаажуулсны үндсэн дээр түгээх нь зүйтэй. Сонгуулийн үр дүнг мэдээлэх үед сэтгүүлчид бусдаас түрүүлэх, шуурхай байхад хэт автан, худал мэдээлэл түгээж, олон нийтийг төөрөгдөлд оруулах эрсдэл өндөр болдог. Учир нь, энэ үед олон хэрэглэгч хамгийн түрүүнд гарах мэдээллийг “амьсгаа даран” хүлээдэг тул хэвлэл мэдээллийн байгууллагууд болон сэтгүүлчид туйлын сонор сэрэмжтэй байж, бодит байдалд нийцсэн мэдээлэл бэлтгэж түгээхийн тулд нягтлаж баталгаажуулдаг байх хэрэгтэй.
- ✓ Мэдээллийг гүнзгийрүүлж, учир шалтгааныг тайлбарлах. Сэдэв, өнцгийн дагуу холбогдох бүхий л зүйлийг шалгаарай. Орчин тойрныг оролцуулж, болсон үйл явдлыг өргөтгөж хар. Асуудлыг тэлэх биш, харин түүний гүн рүү ороорой. Ийм үед мэдээллийн “далайд живэх” эрсдэлтэй тул өнцөг хазайсан эсэхийг анхаараарай.
- ✓ Мэдээлэл зөрчилтэй буюу хэн нэгний эсрэг чиглэсэн эсэх. Хэн хэн оролцсон, тэд ямар үүрэгтэй, ямар ашиг сонирхол, зорилготойг шалгаарай.
- ✓ Баримтыг нягтлаж шалгах ажлыг бүрэн хийх. Үүний тулд шат дараалсан хоёр түвшинд ажиллана. Үндсэн судалгаагаар болсон үйл явдалтай холбоотой асуудлыг нягтлаж шалгана. Дараа нь, учир шалтгааныг олох “яагаад, яаж” гэсэн асуултуудад хариулт олно. Өөрөөр хэлбэл, эхний шат болсон үйл явдлын түвшинд, дараагийн шат тайлбарлах түвшинд хийгдэнэ гэсэн үг.
- ✓ Баримтад үндэслэн таамаглал дэвшүүлэх. Гэхдээ энэ нь сэтгүүлчийн өнөөг болтол цуглуулж, үзэж харсан баримтад тулгуурласан, үнэнд ойрхон очсон таамаглал байх ёстой. Учир нь, та энэ мөчийг хүртэл баримтыг нягтлаж шалгах ажлыг хангалттай сайн хийсэн бол болсон үйл явдал, түүний уялдаа холбооны талаар хангалттай мэдээлэл цуглуулсан гэсэн үг.

- ✓ Нягтлаж шалгасан ажлаа үнэлж дүгнэх. Болсон үйл явдал хангалттай тодорхой сэргээгдсэн үү, өртсөн, оролцсон хүмүүсийн үүрэг оролцоо тодорхой болсон уу зэрэг асуултад хариулж чадаж байх ёстой.
- ✓ Баримт нягтлан, үнэн бодит мэдээлэл түгээдэг <http://www.factcheck.mn/> вэб сайтыг ашиглаарай. Баримтыг нягтлах багт мэргэжлийн сэтгүүлч, багш, судлаачид багтдаг бөгөөд тэд “долоо нягтлаж нэг түгээнэ” гэсэн зарчмын дагуу ажилладаг. Редакцын хамт олон баримтыг хэрхэн нягтлах талаар доорх зөвлөмж өгсөн байна.
 - Мэдээлэл түгээгчийн хаягийг шалгах. Сайт эсвэл хувь хаяг уу, URL буюу холбоос нь бодит уу, ямар түүх, хэдэн дагагчтай, өнөөг хүртэл нийтлэгдсэн нийтлэлүүд, эрхлэн гаргагчийн нэр хаяг бий эсэх гэх мэтийг харах. Энэ бүгд илгээгчийн хэр найдвартай, итгэж болох эсэх талаарх мэдээллийг агуулж байдаг.
 - Эх сурвалж, тоо баримт, өгөгдлийг шалгах. Шаардлагатай тохиолдолд бусад эх сурвалж, шинжээч, эрх бүхий байгууллагатай холбоо барьж тодруулна.
 - Зураг, видео контентыг шалгах. Фото зураг агуулгад нийцэж буй эсэх, тухайн газарт авсан бодит зураг мөн эсэх, тэр бүгдийг шалгах техник хэрэгсэл, программ ашиглах гэх мэт.

ҮНЭН БОДИТ МЭДЭЭЛЭЛ ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Сонгуулийн явц, үр дүн нь олон нийтийн санаа бодлоос, тэдэнд ямар мэдээлэл байгаагаас ихээхэн шалтгаалдаг. УИХ-ын 2020 оны сонгуулийн үеэр Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд сонгуулийн үйл явцыг шууд дамжуулах, мэдээлэх үүргээ биелүүлсэн ч сонгогчдын боловсролд зориулсан, үйл явдлыг задлан шинжилсэн, эрэн сурвалжилсан бүтээл хангалтгүй байсан гэсэн шүүмжлэлд өртсөн.

Сонгуулийн сурталчилгааны богинохон хугацаанд намууд, нэр дэвшигчид өөрсдийгөө олон нийтийн анхаарлын төвд оруулах, сонгогчдын сонголтод нөлөөлөхийн төлөө улайрч, өрсөлдөгчийнхөө талаар сөрөг мэдээлэл бэлтгэн, олон сувгаар олон давтамжтайгаар цацдаг нь сонгогч үнэн бодит байдлыг ялган танихад бэрхшээл учруулсаар ирсэн. Жишээлбэл, УИХ-ын 2020 оны сонгуулийн үеэр иргэдийн дунд сонгуулийн санал өгөхдөө олон мандаттай тойрогт заавал нэг намын нэр дэвшигчдийг бүгдийг нь дугуйлах ёстой гэсэн худал мэдээлэл тарсан. Хэрэв хоёр мандаттай тойрогт тухайн намын хоёр хүний нэгийг нь л дугуйлах юм бол санал нь хүчингүйд тооцогдоно гэсэн цуу яриа гарсан нь сонгогчдыг төөрөгдүүлэхэд хүргэсэн. Чухам хэн нь үнэн, хэн нь худал мэдээлэл түгээж буйг таньж чадаагүйгээс сонгогчид өөрийн итгэл үнэмшилд нийцэхээргүй нэр дэвшигч, намыг сонгох тохиолдол гарсаар байна. Харин хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн гол ажил нь энэ эргэлзээг арилгаж, бодит мэдээллээр олон нийтийг чиглүүлэх юм.

Сонгуулийн үеэр улс төр, нийгэм, эдийн засгийн сэдэвт худал мэдээлэл эрс ихэсдэг. Тийм ч учраас энэ өдрүүдэд сэтгүүлч илүүтэй сонор соргог байж, баримтыг сайтар нягтлан шалгаж, үнэн зөв, бодит мэдээллийг олон нийтэд хүргэх үүрэгтэйг дахин сануулъя.

Сэтгүүлч Б. 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр “Нэр дэвшигч Э гадаадад валютын хадгаламжтай” хэмээн нийтлэл бичжээ. Эх сурвалж нь Авлигатай тэмцэх газрын Хөрөнгө орлогын мэдүүлэг. Гэтэл нэр дэвшигч валютын хадгаламжаа төгрөгт шилжүүлсэн байсныг сэтгүүлч нягтлаагүй шууд мэдээлснээс болж “Худал мэдээлэл олон нийтэд түгээсэн” гэсэн үндэслэлээр шүүхэд дуудагджээ. Нэр дэвшигч сэтгүүлчийг “Валютын хадгаламжаа төгрөгт шилжүүлсэн байхад намайг валютын хадгаламжтай гэж бичлээ” хэмээн буруутгасан байдаг.

3. Сэтгүүлч та эх сурвалжаа баталгаатай эсэхийг сайтар нягтлаарай.⁴⁷

- ✓ Олон эх сурвалжтай уулзаж, мэдээллийг нягтлан шалгаж тэнцвэржүүл.
- ✓ Улс төрийн төлөөллөөс гадна мэргэжлийн хүний үг, иргэдийн бодол санааг ч тусгахаа бүү мартаарай.
- ✓ Эх сурвалжуудын хүйсийн харьцааг бодолцоорой.
- ✓ Тодорхой сонирхол агуулсан, үйл явдалд их бага хэмжээгээр оролцсон, ашиг сонирхлын зөрчилтэй байх тусам хөндлөнгийн чанараа алдана.
- ✓ Нийгмийн сүлжээг эх сурвалжаа болгохгүй байх, эх сурвалж болгох тохиолдолд заавал бусад эх сурвалжаар баталгаажуулах, постын эзнээс зөвшөөрөл болон тодруулга авах зэрэгт анхаарна (Хуурамч мэдээллийг түгээх нэг эх үүсвэр нь нийгмийн сүлжээ болдог. Тиймээс энэ үед зөвхөн текст агуулга төдийгүй видео эвлүүлэг, гэрэл зургууд ч хуурамч байж болдог).⁴⁸

4. Сэтгүүлч та аливаа мэдээллийг олон нийтэд хүргэхдээ өөрийн үзэл бодлоо нэмэх, бусдад үзэл бодлоо тулгах нь мэргэжлийн ноцтой алдаа болно.

- ✓ Нам, эвсэл, нэр дэвшигчдээс өгч буй статистик тоо баримт, хэвлэлийн хурал зэрэг нь нэг л түвшний эх сурвалж бөгөөд баримтыг бусад эх сурвалжуудаар заавал нягтлаж баяжуулах нь зүйтэй.

5. Сэтгүүлч та өөрийн бүтээлдээ төдийгүй нийгмийн сүлжээгээр дамжуулан бусдыг үзэн ядах, шашин шүтлэг, нийгмийн гарал үүсэл, бэлгийн чиг баримжаа, үзэл бодлоор ялгаварлан гадуурхсан өнгө аястай үг хэллэг бүү хэрэглээрэй.⁴⁹

⁴⁷ Хэвлэл мэдээллийн зөвлөл, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, <http://www.mediacouncil.mn/p/7>

⁴⁸ Хэвлэлийн Хүрээлэн (2016). Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг.

⁴⁹ Фридрих-Эбертийн сан ба Хэвлэл мэдээллийн зөвлөл (2018). Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг. Контент анализын судалгаа, <http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14785.pdf>

“MAGA hat journalist fired” буюу MAGA малгайтай сэтгүүлчийн тухай кейсийг дурдая. Тэрээр КТТ телевизийн сурвалжлагч. 2018 онд Америкийн ерөнхийлөгчийн сонгуулийг сурвалжилж явахдаа “Америкийг эргээд агуу орон болгоно” гэсэн Д.Трампын уриатай малгайг өмссөн нь ажлаасаа халагдах үндэслэл болсон. Сэтгүүлч хүн сонгуулийн үеэр хэзээ ч хэн нэгнийг дэмжиж буйгаа олон нийтэд мэдээлэх ёсгүй. Сэтгүүлч энэ малгайг өмссөнөөр би төдийгүй манай телевиз Д.Трампыг дэмжиж байна гэдгийг олон нийтэд өглөө гэсэн мессэжийг тараасан.

6. Сэтгүүлч та олон нийтийн санал асуулгын дүнг ашиглахдаа эх сурвалжийг тодорхой дурдаарай.

7. Сэтгүүлч та тухайн нийтлэл, нэвтрүүлгийг бичсэн, бүтээсэн сэтгүүлчийн нэрийг дурдаарай.

8. Сэтгүүлч та ноцтой, далд баримтыг илчилсэн тохиолдолд эх сурвалжаа нууцлаарай.⁵⁰

9. Сэтгүүлч та буруутгагдсан этгээдэд тайлбар өгөх боломж олгоорой.⁵¹

- ✓ “Хэвлэл мэдээлэл нь сонгуулийн санал хураалтаас өмнө буруутгагдсан этгээдийг тайлбар хийх боломжгүй хугацаанд нэр дэвшигчийн талаар мэдээлэл түгээхээс зайлсхийнэ.”⁵²
- ✓ Сонгуулийн үеэр аль нэгэн нам, нэр дэвшигчийн хэн нэгнийг буруутгасан мэдээллийг сонгуулийн сурталчилгааны хугацаа дуусахаас өмнөхөн амжуулах нь бий. Ингэснээр буруутгагдсан этгээдэд тайлбар өгөх боломж олдохгүй байх, олдсон ч “үнэ цэнтэй” хугацаа нь хэдийнээ өнгөрсөн байх тохиолдол олон.

10. Сэтгүүлч та алдаа гаргасан бол залруулга хийж, уучлалт гуйгаарай.

- ✓ Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.9-д “Нийтэлж нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон мэдээллийг нэн даруй залруулна” хэмээн заасан.
- ✓ Мэргэжлийн хариуцлагатай сэтгүүл зүйн нэг онцлог нь хийсэн алдаандаа залруулга гаргах чадвар юм. Залруулга нь хэлбэр төдий биш байх нь хариуцлага хүлээж буйгаа илэрхийлэх нэг хэлбэр юм.
- ✓ Сонгуулийн үеэр хүний нэр төрд халдах, гүтгэх тухай Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Худал мэдээлэл тараах”, “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил

⁵⁰ Хэвлэл мэдээллийн зөвлөл, Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим, <http://www.mediacouncil.mn/p/7>

⁵¹ Мөн тэнд

⁵² Мөн тэнд

хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ” хэмээн заасан байдаг.

Ерөнхийлөгчийн Тамгын газраас Хэвлэл мэдээллийн зөвлөлд гомдол ирүүлжээ. 2019 оны гуравдугаар сарын 18-ны өдөр 24tsag.mn сайтад “Э-г цэргийн гавъяаны улаан тугийн одонгоор шагнажээ” гарчигтай нийтлэгдсэн мэдээлэл нь бодит байдалд нийцэхгүй ташаа мэдээлэл байсан, мэдээллээ залруулахыг хүсэхэд сайтын редакц тоомжиргүй хандсан тул сайтын редакц нь ёс зүйн зарчмын 1.9 буюу “Нийтэлж нэвтрүүлсэн мэдээлэл нь ташаа болох нь тогтоогдсон бол нэн даруй залруулна” гэсэн заалтыг зөрчсөн гэсэн гомдлыг ирүүлжээ. Гомдлын дагуу 24tsag.mn сайт нь ёс зүйн зарчмын 1.9 дэх заалтыг зөрчсөн гэж дүгнэсэн байна.

ҮНЭН БОДИТ МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХЭЭС ТАТГАЛЗАЖ БОЛОХ ТОХИОЛДОЛ БИЙ ЮУ?

Бодит байдлыг мэдээлэх нь сэтгүүл зүйн үүрэг боловч үр дүн, нөхцөл байдлаас шалтгаалж, түгээх эс түгээхээ шийдвэрлэж болно. Хэрэв сэтгүүлчид мэдээллийг сонгуулийн үеэр түгээвэл нийгмийн эмх замбараагүй байдалд хүргэхээр бол түүнийг сонгуулийн дараа мэдээлбэл хэр зохистой талаар бодож үзэх хэрэгтэй. Улс орныг хямраасан дуулиан шуугиан, зөрчил мөргөлдөөнөөс “үнэн” хэр илүү үнэтэй байж болох вэ гэдэг нь амаргүй асуулт. Зарим тохиолдолд сонгуулийн санал хураалтын үеэр нийгмийг хамарсан дуулиан шуугиантай үйл явдлын талаар мэдээлэх нь олон нийтийн сонгуулийн санал хураалтад оролцох идэвхийг сулруулах ч тохиолдол бий. Иргэд дуулиан шуугиантай мэдээллийг сонирхон, харин сонгуулийн санал хураалт, нэр дэвшигчдийн талаарх мэдээллийг үл ойшоох байдал үүсэхээр бол хойш тавих нь зөв сонголт байж мэднэ.

Сонгуулийн үеэр талуудын янз бүрийн мэдээлэл, ухуулга, өдөөн хатгалга дунд олон нийтийн санаа бодол тогтворгүй болдог. Улс төрийн бүлэглэлүүд үүнийг овжноор ашиглаж, нийгмийг хамарсан жагсаал цуглаан, зөрчил мөргөлдөөнд хүргэж болзошгүй. Ийм үед “үнэн” чухал уу, иргэдийн амь нас чухал уу гэдгийг дэнслэх шаардлага гарч болно.

Сонгуулийн үеэр хэрхэн шударга ажиллах вэ?

- ✓ Бүх өрсөлдөгчдөд тэгш хандах.
- ✓ Өнгө аяс төвийг сахих.
- ✓ Хэнийг сонгох ёстойг ямар ч тохиолдолд заахгүй. Зөвхөн мэдээлэх.
- ✓ Баримт, үзэл бодол хоёрыг ялгаж хэлэх.
- ✓ Бусдыг төөрөгдүүлэхгүй байх.
- ✓ Сенсацлахгүй (дуулиан шуугиан дэгдээхгүй) байх.
- ✓ Өөрийн үзэл бодлоо илэрхийлэхгүй байх.
- ✓ Мэргэжил нэгтний мэдээллээс эш татсан бол эх сурвалжийг заавал дурдах.

Хэрхэн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх вэ?

- ✓ Ямар ч мөнгө, бэлэг сэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байх. Энэ нь зөвхөн таны болон танай байгууллагын нэр хүндэд төдийгүй сэтгүүл зүйд итгэх итгэлийг бууруулах гэмтэй.
- ✓ Нийтлэх болон нийтлэхгүйн төлөө ямар ч хахууль авахгүй байх.
- ✓ Хамаатан садан, найз нөхөд, гэр бүл буюу хамааралтай субъект нэр дэвшиж байгаа бол сонгуулийг сурвалжлахгүй.

Хүнлэг байх зарчим

- ✓ Хэн нэгний нэр хүндийг унагаах зорилготой ажиллахгүй байх.
- ✓ Хувийн амьдралыг хүндэтгэх, хувийн нууцад халдахгүй байх (олон нийтийн эрх ашгаас бусад мэдээлэл).
- ✓ Дуулиан шуугиан дэгдсэн үед ч үл даган дуурайх.
- ✓ Үзэн ядах үг хэллэг түгээхгүй байх.
- ✓ Ялгаварлан гадуурхахгүй байх.

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар БЭС клуб, Монгол үнэн гэх мэтээр нэрээ сольж байсан Фэйсбүүк хуудаст нэр дэвшигч Э-ийн нэрийг тодорхой заан “хулгайч”, “хужаа” хэмээн бичжээ. Шүүхээс гэм буруутайд тооцоогүй бол хэнийг ч гэмт хэрэгтэн буюу хулгайч хэмээн дуудах нь гүтгэсэнд тооцогдох юм. Түүнчлэн бичвэр дэх “хужаа” хэмээх доромж үг нь үзэн ядсан шинжтэй үг хэллэг юм.

Ёс зүйн зарчмаа хэрхэн баримтлах вэ?

- ✓ Мэргэжлийн сэтгүүлчид ёс зүйн зарчмаа эрхэмлэх.
- ✓ Ёс зүйн дүрмээ ойлгох (Нягтлах, дахин шалгах үндэс буюу ёс зүйн дүрэм-1.1).
- ✓ Өрсөлдөөнд амжилт гаргах (итгэл үнэмшил).
- ✓ Эх сурвалжийг аль болох ил байлгах (эрэн сурвалжилга).
- ✓ Хөдөлмөрийн гэрээнд ёс зүйн ба эх сурвалжийн талаар тодорхой заалт тусгах, тохиролцох.
- ✓ Өөрийн зохицуулалтаар шийдвэрлэх.
- ✓ Редакцын дотоод журмаар зохицуулах зэргээр ёс зүйн зарчмаа баримтална.

Факт чек /Fact check/ буюу баримтыг нягтлах нь дэлхийг хамарсан томоохон сэдэв болоод байна. Тиймээс, өнөөдөр факт чекээр мэргэшсэн сэтгүүлч, мэргэжилтнүүд бий болж, дэлхийн өнцөг булан бүрт мэдлэг ойлголт дээшлүүлэх үйл ажиллагаа тасралтгүй зохион байгуулагдаж байна. Худал мэдээлэл эрчимтэй түгэж буйд технологийн хөгжил гол хүчин зүйл болж байгаа хэдий ч, уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо буурч, цахим мэдээллийн хурд, тоо хэмжээ эрчимтэй нэмэгдсэн нь тодорхой хэмжээний нөлөө үзүүлсэн гэж үзэж болно. Олон нийтийн дунд уламжлалт мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдэд итгэх итгэл буурсан нь редакцууд нэг үйл явдал, ижил баримтыг эрс тэс, хэд хэдэн янзаар тайлбарлаж байгаа явдал юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн цахимжих хандлага нэмэгдэхийн зэрэгцээ мэдээллийн хурд эрс өсч, цар хүрээ нь өргөжсөөр байна. Үүнтэй зэрэгцээд худал, буруу ташаа мэдээлэл, дуулиан шуугиан хөөсөн мэдээ газар авах хандлага илт өсөн нэмэгдэж байна. “Олсон мэдээллээ эхлээд нягтлаж шалгана” гэсэн сэтгүүлчдийн үүргийн талаар Герман улсад 19 дүгээр зууны эцсээр яригдаж, хөндөгдөж эхэлсэн. Сэтгүүлчид зөвхөн тэдэнд хэлсэн зүйлийг л бичээд байдаггүй, харин өөрсдөө мэдээллийг эрж хайн, нягтлан шалгадаг бол хэвлэл мэдээллийн байгууллага, ажилтнуудын нэр хүнд илүү өндөр байх болно. Шүүхээр буруутгагдсан, бусдыг гүтгэсэн, худал мэдээлэл түгээсэн, баримтын алдаа гаргасан сэтгүүлчтэй холбоотой ихэнх сөрөг мэдээллийн үндэс нь баримтыг сайтар нягтлаж шалгаагүйгээс үүдэлтэй. Хэдий чинээ сайн нягтлаж шалгана, төдий чинээ эрсдлээс хамгаалагдана гэдгийг сэтгүүлчид санаж байх нь чухал.

Хэвлэл мэдээллийн зөвлөлд 2015-2020 оны хооронд нийт 385 гомдол ирсэн байна. Үүний 267 өргөдөл буюу 70 хувийг Ёс зүйн хороодоор хэлэлцүүлж дүгнэлт гаргасан бол, үлдсэн 30 хувийг журмын дагуу Ажлын албанаас шийдвэрлэсэн байна. Ёс зүйн хороодын хэлэлцсэн гомдлуудаас 78 хувьд нь Ёс зүйн зарчим зөрчсөн гэсэн дүгнэлт гарчээ. Үүнд, хамгийн түгээмэл алдаа нь Ёс зүйн зарчим 1.1-т заасан «Мэдээлэл нь үнэнд нийцсэн эсэхийг баталгаажуулж санамсаргүй алдаа гаргахаас зайлсхийнэ» гэсэн, 1.2-т заасан «Эх сурвалжийн баталгаатай эсэхийг нягталж, тодорхой дурьдахыг эрмэлзэнэ» гэсэн заалтуудын зөрчил байна.⁵³

NTN телевиз 2017 оны аравдугаар сарын 25-ны мэдээллийн хөтөлбөрөөр “Монгол адууг амьдаар нь тамлаж байгаа дэндүү харгис гэмээр үйлдэл Эмээлтэд бий болжээ” гэсэн мэдээлэл түгээжээ. Гэтэл “Эмээлт орчмын адуу нядалгааны газруудыг “Эмээлт зах” гэж хавтгайруулан нэрлэж, бусад аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг манай компанийн үйлдэл мэтээр ташаа мэдээлсэн нь байгууллагын нэр хүндэд ноцтой халдаж, бизнесийн үйл ажиллагаанд хохирол учруулж байна” гэсэн гомдлыг Хэвлэлийн мэдээллийн зөвлөлд ирүүлжээ. Ёс зүйн хороо уг гомдлыг авч хэлэлцээд, NTN телевиз нь дээрх сурвалжилгыг бэлтгэхдээ Эмээлт орчимд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн нэрийг нягтлаагүйгээс “Эмээлт зах” ХХК-ийн нэр хүндэд халдсан санамсаргүй алдаа гаргасан гэж дүгнэсэн байна. Энэхүү дүгнэлтийг гаргахдаа Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчмын 1.1 дэх заалтыг зөрчсөн гэжээ.⁵⁴

⁵³ ГГүнжидмаа, Хэвлэл мэдээллийн зөвлөлийн гүйцэтгэх захирал

⁵⁴ Хэвлэл мэдээллийн зөвлөл, Нэр бүхий телевизүүд ёс зүйн зөрчил гаргажээ, <http://www.mediacouncil.mn/a/70>

Дэлхийн сэтгүүл зүйн түүхээс харвал 1990-ээд оноос эхлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакцуудад мэдээллийг нягтлаж шалгах ажлын чанар эрс муудсан гэж үздэг. Хэт олширсон ХМХ, тэдний хоорондын хүчтэй өрсөлдөөнөөс болж, мэдээллээ бүрэн гүйцэд шалгахгүйгээр нийтлэх, мэргэжлийн алдаа гаргах нь ихэсч байна. Эдгээр алдааны хамгийн шуугиан тарьсан хэргийн тоонд 1998 оны зургаадугаар сард CNN, TIME хоёрын олон нийтэд цацсан “АНУ, Вьетнамын дайнд “сарин” (sarin) хэмээх мэдрэлийн хий хэрэглэсэн хэмээх мэдээ орно.⁵⁵ Нягталж шалгалгүй таамаг төдий мэдээг олон нийтэд түгээсэн шалтгаанаар CNN хэд хэдэн мэдээний албаа татан буулгаж, гол сэтгүүлчид нь ажлаа хүлээлгэн өгсөн байдаг.

Энэ бүгдээс харвал, хэвлэл мэдээллийн салбарын хамгийн чухал, хамгийн хүнд ажил бол баримтыг нягтлах юм. Тиймээс шинэ залуу төдийгүй, дадлага туршлагатай, нэр хүндтэй сэтгүүлчид ч баримт нягтлах ажилд туйлын хариуцлагатай, хянамгай хандах ёстой.

БАРИМТ НЯГТЛАХ ГЭЖ ЮУ ВЭ?

Сэтгүүл зүйгээр суралцагсад, дадлага туршлага багатай шинэ залуу сэтгүүлчид баримт мэдээллийг нягтлах ажлыг хийхдээ асуудлын гүн рүү орох бус сэдвийн дагуу нэмэлт мэдээлэл цуглуулж, цар хүрээг нь л өргөжүүлээд байх явдал ажиглагддаг. Гэвч нэмж судалсан, цуглуулсан баримтууд онцын шаардлагагүй байх нь элбэг. Эцэст нь, хэрэгтэй, хэрэггүй олон баримтын дунд төөрч, өнцөг, сэдэв, баримтаа хүчгүйдүүлдэг. Мэдээллийн гүн рүү орж, баримтыг нягтлана гэдэг нь тухайн сэдвийн чухал гэсэн зүйл дээр төвлөрч, оролцогсдын үүрэг оролцоо, уялдаа холбоог дахин сэргээж үзнэ гэсэн үг. Энэ үед сэтгүүлч маш хариуцлагатай, нарийн мэдрэмжтэй байх ёстой.

БАРИМТ НЯГТЛАСНЫ АЧААР ҮНЭНИЙГ ИЛРҮҮЛСЭН САЙН ЖИШЭЭ

Сэтгүүл зүйн түүхэн дэх гайхамшигт бүтээлүүдийн нэг бол Францын Анне Мари Кастерет гэгч сурвалжлагч бүсгүйн “Халдвартай цусны хэрэг” нэрт эрэн сурвалжилга юм. Сурвалжлагч бүсгүйд гемофили хэмээх цусны өвчтэй нэгэн эр хандсанаар энэхүү түүх эхэлсэн байдаг. Тэрээр “Францын засгийн газар, эрүүл мэндийн агентлаг өөр шиг нь өвчтэй хүмүүст санаатайгаар ХДХВ-ээр халдварласан цус худалдаж байсан” хэмээн ярьжээ. Кастерет холбогдох эрүүл мэндийн агентлагийн даргаас тодруулахад “Гемофили өвчтэй хүмүүс манай цусан бүтээгдэхүүнээр дамжин ХДХВ-ээр халдварласан нь үнэн. Гэхдээ түүхий эд халдварласан байсныг хэн ч мэдээгүй, илүү найдвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх шинэ боломж байгаагүй, өөр бусад хүнд тараагаагүй” гэсэн хариулт өгчээ. Энэ бол уялдаа холбоотой, ойлгомжтой, албан ёсны хариулт байв. Гэсэн ч сурвалжлагч дахин баримт мэдээлэл цуглуулан, нягтлаж эхэлтэл агентлагийн даргын хариулт бүгд худал болохыг олж мэдсэн байна.

- Судалгаа шинжилгээний тайлан баримтаас үзэхэд, тухайн үед донорын цусанд ХДХВ байж болох талаар мэддэг байсан, тэр бүү хэл, үүнийг анхааруулж байсан.
- Өөр найдвартай цусан бүтээгдэхүүн хэрхэн үйлдвэрлэх талаар мэдлэгтэй эм зүйн болон Засгийн газрын байгууллагууд байсан боловч тэдний саналыг сонсоогүй.

55 Халлер, М (2015), “Recherchieren” буюу Мэдээллийг нягтлахуй”, Орч. Х.Ариунчимэг, Улаанбаатар, х-53

- Өөрийнх нь бүх бүтээгдэхүүн ХДХВ халдвартайг мэдсэн ч бүх бүтээгдэхүүнээ дуустал нь үргэлжлүүлэн борлуулахаар шийджээ.

Кастеретын энэхүү бүтээлийн ачаар цагаан өмсгөлтэй гэмт хэрэгтнүүд өргөст торны цаана орж, хохирогч эр өөрийгөө ганцаараа биш болохыг мэдэж авчээ. Мөн энэ нийтлэлийг зогсоох гэж оролдсон төрийн эрх баригчид сонгуулиар ялагдаж, эрүүл мэндийн тогтолцоог өөрчилж чадсан байна.⁵⁶

Баримт мэдээллийг нягтлах ажлын аргачлалыг Лейпцигийн их сургуулийн профессор, мэргэжлийн сэтгүүл зүйн багш Михайэл Халлер доорх дүрмээр зохицуулахыг зөвлөсөн байдаг.⁵⁷

БАРИМТ НЯГТЛАХ ХАЛЛЕРЫН ДҮРЭМ ГЭЖ ЮУ ВЭ?

- Анхны мэдээлэл олон нийтэд хамаатай, чухал асуудлыг хөндсөн байх. Хэдий чинээ олон хүний эрх ашгийг хөндөнө, төдий чинээ чухал байж чадна.
- Мэдээлэл бодит эсэхийг шалгах. Хамгийн түрүүнд тухайн үйл явдал, үзэгдэл бодит үнэн, болсон эсэхийг шалга. Тэгээд дараагийн алхмуудаа хий.
- Эх сурвалж ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг шалгах. Болсон үйл явдлаас эх сурвалж хол байх тусам найдвартай мэдээлэл өгдөг. Тодорхой сонирхол агуулсан, үйл явдалд их бага хэмжээгээр оролцсон, ашиг сонирхлын зөрчилтэй байх тусам хөндлөнгийн чанараа алдана.
- Тодорхой баримтуудыг шалга. Жишээ нь, орон зай, цаг хугацаа, холбогдсон хүмүүсийн нэр, албан тушаал болон бусад зүйлсийг тодорхойлохоос эхэлнэ. Маш нямбайгаар, нэг нэгээр нь нарийвчлан шалгаарай.
- Мэдээллийг гүнзгийрүүлж, учир шалтгааныг тайлбарлах. Сэдэв өнцгийн дагуу холбогдох бүхий л зүйлийг шалга. Орчин тойрныг оролцуулж, болсон үйл явдлыг өргөтгөж хар. Асуудлыг тэлэх биш, харин гүн рүү нь ороорой.
- Мэдээлэл зөрчилтэй буюу хэн нэгний эсрэг чиглэсэн эсэх. Хэн хэн оролцсон, тэд ямар үүрэг оролцоотой, ямар ашиг сонирхол, зорилготойг шалгаарай.
- Баримтыг нягтлах ажлыг бүрэн хийх. Үүний тулд, шат дараалсан хоёр түвшинд ажиллана. Үндсэн судалгаагаар, болсон үйл явдалтай холбоотой асуудлыг шалгаж нягтлана. Дараа нь учир шалтгааныг олох “яагаад, яаж” гэсэн асуултуудад хариулт олно. Өөрөөр хэлбэл, эхний шат болсон үйл явдлын түвшинд, дараагийн шат тайлбарлах түвшинд хийгдэнэ гэсэн үг.
- Баримтад үндэслэн таамаглал дэвшүүл. Гэхдээ, энэ нь сэтгүүлчийн өнөөг болтол цуглуулж, үзэж харсан баримтан дээр тулгуурласан, үнэнд ойрхон очсон таамаглал байх ёстой. Учир нь, та энэ мөчийг хүртэл баримтыг нягталж шалгах ажлыг хангалттай сайн хийсэн бол болсон үйл явдал, түүний уялдаа холбооны талаар хангалттай мэдлэгийг цуглуулсан байгаа.
- Нягтлаж шалгасан ажлаа үнэлж дүгнэ. Болсон үйл явдал хангалттай тодорхой сэргээгдсэн үү, өртсөн, оролцсон хүмүүсийн үүрэг оролцоо тодорхой болсон уу зэрэг асуултад хариулж чадаж байх ёстой.

⁵⁶ Ли Хантер, М. ба бус., (2011), Таамагт суурилсан судалгаа. Эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан гарын авлага. Орч. Хэвлэлийн хүрээлэн, х.21

⁵⁷ Халлер, М (2015), “Recherchieren” буюу Мэдээллийг нягтлахуй”, Орч. Х.Ариунчимэг, Улаанбаатар

Америкийн нийтлэлч Куртис Макдугалл хэлэхдээ “Баримтыг дээд зэргээр нягтлаж шалгадаг сэтгүүлч, албан тушаал эргээд моодонд орж, эрэлт нь ихэсч байна” гэсэн байдаг. Монголын сэтгүүл зүйд ч баримтыг шалгадаг сэтгүүлч, албан тушаалтан, редакцын талаар сүүлийн жилүүдэд хурцаар яригдаж хөндөгдөх болсон.

Монгол Улсад анх удаа буюу 2019 оны арванхоёрдугаар сард Германы Дойче Велле Академи, Монголын эрэн сурвалжлах сурвалжлагчдын төлөө төв хамтран худал мэдээлэлтэй тэмцэх зорилгоор төсөл хэрэгжүүлж, улмаар зөвхөн баримтыг нягтлаж шалган, үнэн бодит мэдээллийг түгээх үйл ажиллагаа эрхлэдэг <http://www.factcheck.mn/> вэб сайтыг нээсэн юм. Баримтыг нягтлаж шалгах багт мэргэжлийн сэтгүүлч, багш, судлаачид багтдаг бөгөөд тэд “долоо нягтлаж нэг түгээнэ” гэдэг зарчмын дагуу ажилладаг. Редакцын хамт олон баримтыг хэрхэн нягтлаж шалгах талаар доорх зөвлөмжийг өгсөн байна.

1. Мэдээлэл түгээгчийн хаягийг шалгах: сайт эсвэл хувь хаяг уу, URL буюу холбоос нь бодит уу, ямар түүх, хэдэн дагагчтай, өнөөг хүртэл нийтлэгдсэн нийтлэлүүд, эрхлэн гаргагчийн нэр хаяг бий эсэх гэх мэтийг харах. Энэ бүгд илгээгчийн хэр найдвартай, итгэж болох эсэх талаарх мэдээллийг агуулж байдаг.
2. Эх сурвалж, тоо баримт, өгөгдлийг шалгах: шаардлагатай тохиолдолд бусад эх сурвалж, шинжээч, эрх бүхий байгууллагатай холбоо барьж тодруулна.
3. Зураг, видео контентыг шалгах: фото зураг агуулгад нийцэж буй эсэх, тухайн газарт авсан бодит зураг мөн эсэх, тэр бүгдийг шалгах техник хэрэгсэл, программ ашиглах гэх мэт.

Сонгуулийн үеэр улс төр, нийгэм, эдийн засгийн сэдэвт худал мэдээлэл эрс ихэсдэг. Тийм ч учраас энэ өдрүүдэд сэтгүүлч илүүтэй сонор соргог байж, баримтыг сайтар нягтлан шалгаж, үнэн зөв, бодит мэдээллийг олон нийтэд хүргэх үүрэгтэйг дахин сануулж байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

СОНГУУЛИЙГ МЭДЭЭЛЖ, СУРВАЛЖЛАХДАА АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХАНГАХ НЬ 11.

Сэтгүүл зүйн үйл ажиллагаа эрхэлж буй хэн боловч аюулгүй орчинд, аливаа сүрдүүлэг заналхийллээс ангид үйл ажиллагаагаа явуулах эрхтэй.

ЖИШЭЭ 1. Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн үеэр нэр дэвшигч Г-ын дэмжигчид “Ийгл” телевизийн байр луу дайрч, сэтгүүлч Б.Батцэцэгийн хоолойг боож, биед нь халдсан хэрэг гарсан. Сэтгүүлч хэрэг гарахын өмнөх өдөр нэр дэвшигчээс “Та сонгуулийн үеэр ашиглах гэж 20 сая воныг Солонгосын иргэнээс авсан уу” гэж асуужээ. Энэ хариултгүй асуултын бичлэг Г-ын нэр хүндийг унагасан гэж уурласан дэмжигчид нь ийнхүү сэтгүүлчийг гэмтээжээ.

ЖИШЭЭ 2. 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр Увс аймагт нэр дэвшигчийн сонгуулийн штабынхан мэдээлэл бэлтгэж явсан ТВ9 телевизийн зураглаач, сэтгүүлч рүү дайрч, мэдээлэл дамжуулахад ашиглаж байсан камерыг нь гэмтээсэн.

ЖИШЭЭ 3. 2020 оны оны дөрөвдүгээр сарын 16-нд ажлаа хийж явсан Dorgio.mn сайтын сэтгүүлч А.Баярмаа халдлагад өртөж, хөлөө гэмтээсэн. Тухайн үед “Сахигтун Үндсэн хуулийн эвсэл 19”-ээс хуульч Б-г суллахыг шаардаж, 5000 иргэн гарын үсэг зурсан талаараа хэвлэлийн бага хурал хийж, талбайд жагсаал зохион байгуулна гэсэн байна. “Коронавирусээс болж хөл хорио тогтоосон энэ цаг үед жагсаал хийх шаардлагатай юу” хэмээн өөрсдийнх нь мэдээллийн эсрэг асуулт асуусанд дургүйцлээ илэрхийлж сэтгүүлчийг түлхэснээс болж, зүүн хөлийн зөөлөн эдийг гэмтээсэн.

ЖИШЭЭ 4. “Өнөөдөр” сонины гэрэл зургийн сурвалжлагч Б.Бямба-Очир 2008 оны долдугаар сарын 1-ний өдөр сонгуулийн дүнг эсэргүүцсэн үймээнийг сурвалжилж яваад, шидсэн чулуунд оногдон толгойдоо гэмтэл авчээ. Биеийн байдал нь хүндэрч Гэмтэл, согог судлалын үндэсний төвд яаралтай мэс засал хийж амь насыг нь аварсан бөгөөд эмчилгээний хоёр дахь шат буюу тархины яс нөхөх мэс заслыг гадаадад хийлгэсэн.

Энэ мэтчилэн сэтгүүлч, сурвалжлагчдын аюулгүй байдал байнга хурцаар хөндөгддөг ч тэднийг хэрхэн яаж хамгаалах асуудал дорвитой шийдэлд хүрэхгүй байсаар байна.

СЭТГҮҮЛЧ ТА СОНГУУЛИЙН ҮЕЭР АЮУЛГҮЙ БАЙДЛАА ХЭРХЭН ХАНГАЖ АЖИЛЛАХ ВЭ?

Хил хязгааргүй сурвалжлагчид, Олон улсын сэтгүүлчдийн сүлжээ, Олон улсын мэдээний аюулгүй байдлын хүрээлэнгээс сонгуулийн үеэр зөрчилдөөнт нөхцөл байдал үүсвэл сэтгүүлч хэрхэн ажиллах, юуг анхаарах талаар зөвлөмж гаргасан.⁵⁸ Үүнд:

- ✓ Сэтгэл зүйн бэлтгэлтэй байх нь чухал. Өөрийгөө бусдад хүндлэгдэхүйц байдлаар биеэ авч яваарай.

⁵⁸ Сэтгүүлч, сурвалжлагчдад зориулсан зөвлөмж, Орч. Глоб Интернэшнл төв, <http://www.globeinter.org.mn/?c-md=Record&id=1285&menuid=4>

- ✓ Ажлаасаа гарахдаа хамгаалалтын малгай, хантааз авсан эсэхээ шалгаарай.
- ✓ Өмсөж, хэрэглэж буй зүйл дээр чинь танай байгууллагын таних тэмдэг, сурвалжлах хэсгийн гишүүн гэдгийг чинь тодотгосон эсэхийг нягтлаарай.
- ✓ Үүссэн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх чадвартай байж, сэтгэл хөдлөлөө дарж байгаарай.
- ✓ Бөөгнөрсөн олны дунд орох нь тэндээ гацах аюултай гэдгийг санаарай. Иймээс, байдал эвгүйдвэл тэндээс зугтах боломжтой байрлал сонгоорой.
- ✓ Эмх замбараагүй байдал дунд аль болох том камер ашиглахаас зайлхийгээрэй. Ашиглаж буй хэрэгсэл тань аль болох жижиг, анхаарал татахгүй байх нь дээр болохыг олон улсын мэргэжилтнүүд зөвлөж байна. Зөөврийн авсаархан компьютер, дуу, дүрс бичлэг хийх боломжтой гар утас байхад бараг хангалттай. Ийм боломжгүй бол аль болох аюул багатай байрлал сонгоорой.
- ✓ Үймсэн олон, сэтгүүлчдийн ажлын чухал эсэхэд анхаарах ч сөхөөгүй байдаг тул анхаарлыг өөртөө татахаас аль болох зайлсхийгээрэй.
- ✓ Эмх замбараагүй байдал нь аюултай орчин бий болдог. Учир нь, ихэнх тохиолдолд хүмүүс ууртай, түрэмгий болдог, мөн айдас, эмзэглэлд автсан байдаг тул хэн нэгнээс ярилцлага авах гэж бүү албадаарай.
- ✓ Үймэж шуугисан олны аль нэг талд хатуу зогсох нь аюул дагуулна. Иймд байдлыг сайн ажигла. Хэн нэгэнтэй ярилцахдаа үзэл бодлоо битгий хэлээрэй
- ✓ Редакцтайгаа байнга холбоотой, хаана байгаагаа мэдээлж байгаарай.
- ✓ Ямар нэг маргаан, хэрүүлд бүү хутгалдан оролцоорой.
- ✓ Үзэн ядалт, хүчирхийллийг бүү дэвэргээрэй.
- ✓ Хууль сахиулах байгууллагын хүлээж буй чиг үүрэг, хэм хэмжээний тухай мэдлэг ойлголттой байгаарай.
- ✓ Тусламж хэрэгтэй үед хэнд хандахаа мэдэх нь чухал гэдгийг санаарай.
- ✓ Эмх замбараагүй үед хэн нэг аюултай этгээд өөр рүү чинь дөхөж ирвэл тайван, аль болох эелдэг байж, цаг хожихыг хичээгээрэй. Аль болох өөртөө итгэлтэй байгаа мэдрэмжийг түүнд төрүүлэхийг эрмэлзээрэй.
- ✓ Эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх тухай мэдлэгтэй байгаарай
- ✓ Сэтгүүлч өөрөө хүний эрх хамгаалагч тулд хүмүүст туслах итгэл төгс байгаарай. Гэхдээ өөрийн чадахгүй тусламжийг бүү амла. Шаардлагатай үед санаачилгыг гартаа авахыг хичээгээрэй.
- ✓ Эмх замбараагүй байдал дунд хүний эрх хамгаалагчид байгаа эсэхийг тогтоож, холбоо тогтоогоорой
- ✓ Өөрийг тань сүрдүүлсэн, заналхийлсэн тохиол бүрт нухацтай ханд.
- ✓ Эцэст нь өөрийгөө эрсдлээс хамгаалах аргын тухай мэдлэгтэй байгаарай. Ямар ч тохиолдолд амь нас, эрүүл мэнд тань хамгаас үнэтэй болохыг ухамсарлаарай!

Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг зөрчигдвөл хаана хандах вэ?

Хэрэв сэтгүүлч таны мэргэжлийн эрх зөрчигдөх, танд аюул заналхийлэл тулгарвал Глоб Интернэшнл төвтэй холбогдож эрх зүйн туслалцаа авч болно.⁵⁹

Мөн зөрчлийн хүнд хөнгөн шинж байдлаас хамааран хэд хэдэн аргаар эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой. Үүнд:

- Өргөдөл гомдол - Байгууллагын удирдлага – Шүүх
- Өргөдөл гомдол – Дээд шатны байгууллага, албан тушаалтан – Захиргааны шүүх – Улсын Дээд Шүүх – Хүний эрхийн Үндэсний Комисс
- Өргөдөл, гомдол – Анхан шатны шүүх – Давж заалдах шатны шүүх – Хяналтын шатны шүүх - Хүний эрхийн Үндэсний Комисс⁶⁰

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

⁵⁹ Глоб Интернэшнл төв, www.gic.mn

⁶⁰ Глоб Интернэшнл төв, “Сэтгүүлчдийн аюулгүй байдал” гарын авлага, УБ, 2015 он, х-32

НОМ ЗҮЙ

Хууль тогтоомж ба олон улсын гэрээ

Аймаг нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, 2020 он

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт.

<https://www.legalinfo.mn/law/details/1257>

Монгол Улсын Үндсэн Хууль, 1992 он

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, 2006 он

Монгол Улсын Олон Улсын Гэрээ. Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал.

<https://www.legalinfo.mn/law/details/1271>

Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, 2015 он

Монгол хэл дээр

Амартүвшин, С., Батбаатар, Ж. (2014). *Сэтгүүлчийн ур чадвар*. Улаанбаатар

Андерсен, Х.У., Мэллит, М.Ф. (1998). Нийтлэл, нэвтрүүлгийг яаж бэлтгэх вэ? Орч.Зулькафил. М. Улаанбаатар, 2008.

Батбаатар, Ж. (2010). *Суурь сэтгүүл зүй*. Улаанбаатар

Батбаатар, Ж., Амартүвшин, С., Одмандах, М. (2009). *Практик сэтгүүл зүй*. Улаанбаатар

Батзориг, Т. (2019). *Монголын хэвлэл мэдээллийн хараат бус байдлын судалгаа*, х.176.

Батчулуун, Б. (2011). *Эрх чөлөөний дайсан*. Улаанбаатар, Монсудар

Болд-Эрдэнэ, Б. (2004). *Сонины дизайн*. Улаанбаатар, Адмон

Болд-Эрдэнэ, Б. (2017). *Нийгэм, интернет, сэтгүүл зүй*. Улаанбаатар

Глоб Интернэшнл төв (2019). *Телевизээр сонгуулийн халз мэтгэлцээн хэрхэн зохион байгуулах вэ?*

https://www.gic.mn/public/docs/publications/DEBATE_handbook_final_2020_06_08.pdf

ЕАБХАБ-ын Ардчилсан Институт Хүний Эрхийн Газар (2017). *Монгол Улс. Ерөнхийлөгчийн сонгууль. 2017 оны 6-р сарын 26-н болон 7-р сарын 7-ны өдрүүд. ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлан*. Варшав, <https://www.osce.org/files/f/documents/1/3/366136.pdf>

- Ли Хантер, М. ба бус. (2011). *Таамагт суурилсан судалгаа. Эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан гарын авлага*. Орч. Хэвлэлийн хүрээлэн, х.21
- Наранжаргал, Х. (2009). *Мэдээллийн эрх чөлөө*. Улаанбаатар
- Олон Улсын Сонгуулийг Ажиглах Хороо (OSCE ODIHR, OSCE PA, European Parliament), *Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26, Урьдчилсан үр дүн ба дүгнэлтийн тайлан*, <https://www.osce.org/files/f/documents/7/3/327166.pdf>
- Олон Улсын Хэвлэл мэдээллийн дэмжлэг, Хэвлэл мэдээлэл ба ардчилал групп, *Эрх чөлөөний сүлжээ (2006). Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийг дэмжих нь. Дадлагажуулагчдад зориулсан гарын авлага*, Орч. Глоб Интернэшнл төв. https://www.gic.mn/public/docs/publications/coaching_manual_2020_FINAL.pdf
- Фридрих-Эбертийн сан ба Хэвлэл мэдээллийн зөвлөл (2018). *Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг. Контент анализын судалгаа*. <http://library.fes.de/pdf-files/bue/ros/mongolei/14785.pdf>
- Халлер, М. (2015). *“Recherchieren” буюу Мэдээллийг нягтлахуй*, Орч. Х.Ариунчимэг, Улаанбаатар
- Хүний эрх хөгжил төв (2003), *Жендэр судлалын удиртгал*, Улаанбаатар, Хөх судар
- Хүний эрх хөгжил төв (2003). *Жендэр судлалын удиртгал*
- Хэвлэл мэдээллийн зөвлөл, *Нэр бүхий телевизүүд ёс зүйн зөрчил гаргажээ*, <http://www.mediacouncil.mn/a/70>
- Хэвлэл мэдээллийн зөвлөл (2020). *Сонгуулийг ёс зүйтэй сурвалжлах бодлогын баримт бичиг*.
- Хэвлэл мэдээллийн зөвлөл, *Хэвлэл мэдээллийн ёс зүйн зарчим*. <http://www.mediacouncil.mn/p/7>
- Хэвлэлийн Хүрээлэн (2016). *Монголын хэвлэмэл, цахим мэдээллийн хэрэгслүүд, нийгмийн мэдээллийн сүлжээнд хийсэн сонгуулийн мэдээлэл сурталчилгааны мониторинг*.
- Хэвлэлийн Хүрээлэн (2020). *2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр түгээсэн мэдээллийн мониторинг*, https://pressinst.org.mn/wp-content/uploads/2020/12/IRI_DISINFO_MONITORING_FINALREPORT.pdf
- Швейцарын Хөгжлийн Агентлаг, IRIM (2014). *Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа*. https://www.eda.admin.ch/dam/countries/countries-content/mongolia/mn/2015-Gender-Overview-%20Desk-Study-Mongolia_MN.pdf
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем*, www.legalinfo.mn
- Факт-Чек Монгол, <https://factcheck.mn/>

ЮНЕСКО (2014). *Хэвлэл мэдээлэл дэх жендэрийн мэдрэмжтэй байдлын шалгуур үзүүлэлт*, Орч. Глоб Интернэшнл төв. <http://globeinter.org.mn/images/upld/Genderbookast2014.pdf>

Гадаад хэл дээр

Harrower, T. (2012). *Newspaper designers handbook, 6th edn.* New York

Harrower, T. (2016). *Inside reporting*, New York

Newsom, D. & Haynes, J. (2004). *Public Relations Writing: Form and Style*

Smiciklas, M (2012). *The Power of Infographics: Using Pictures to Communicate and Connect with Your Audience*

